



# МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2023 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН

2023 ОНЫ 06 ДУГААР САРЫН 20-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

## ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААН

### ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дараах  
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**

2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр, Мягмар гараг

<b>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</b>	1
<b>Хуралдааны товч тэмдэглэл:</b>	2-27
<b>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</b>	28-85
<hr/>	
<i>1.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/</i>	28-54
<i>2.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр тус тус өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	54-67
<i>3.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох /</i>	67-85

**Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны  
06 дугаар сарын 20-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны дарга Г.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

*Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 37 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.*

*Томилолттой: А.Адъяасүрэн;*

*Чөлөөтэй: Т.Аубакир, Ё.Баатарбилэг, Х.Ганхуяг;*

*Эмнэлгийн чөлөөтэй: Ц.Мөнхцэцэг.*

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан хэлэлцэх асуудлын дарааллын 3 дугаарт байгаа Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээллийг хэлэлцэх асуудлын дарааллын 1 дүгээрт оруулж хэлэлцүүлбэ гэсэн горимын санал гаргав.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайханы гаргасан горимын саналыг дэмжбэ гэсэн санал хураалт явуулбэ.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 6

Бүгд: 10

40.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

***Нэг.Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, мөн яамны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Цолмон, шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

*Боловсролын ерөнхий хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав. /Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу хураалгах санал/*

**Г.Мөнхцэцэг:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ч.Ундррам, С.Чинзориг, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

#### **“12 дугаар зүйл.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо**

12.1.Багш, ажилтан нь боловсролын хууль тогтоомж Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.2.1.энэ хуулийн 12.2-т заасан дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

12.2.2.энэ хуулийн 12.2-т заасан багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.3.Багш ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэх бөгөөд багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшаар ажиллаж болно.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь энэ хуулийн 5.1.4-т заасан зарчимд үндэслэсэн, Хөдөлмөрийн тухай хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандартад нийцсэн байна.

12.6.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.7-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно.

12.9.Аймаг, сум, дүүргийн захиалга эсхүл өөрөө хүсэлт гаргаж багш хүрэлцээгүй төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 3 буюу түүнээс дээш жил мэргэжлээрээ ажиллах гэрээ багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.10.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн тухайн түвшний боловсролын сургалтын байгууллага боловсролын харилцаанд оролцогч талуудтай хамтран зохион байгуулна.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна.

12.12.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг тухайн боловсролын байгууллагын түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.13.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсоны дагуу хамран сургах тойргийн болон сум дахь боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

12.14.Энэ хуулийн 12.13-т заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах хугацаа, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Багш хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

12.16.Багш нь үндсэн ажлын цагаас бусад цагт өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж, нэмэлт орлого олж болно. Энэ харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	2
Бүгд:	10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш,” гэж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9 дэх хэсэг нэмэх:

“13.2.17.суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;

13.2.18.ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19.суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 1 удааагийн буцалтгүй тусламжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

13.9.Багшаар боловсролын болон хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ж.Чинбүрэн нарын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 80 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ”**-ийн нэрийг **“БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА”** гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

“17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага, насан туршийн суралцахуйн төв болон сургалтын байгууллагаас бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүйн сургалтын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах

бичгийн тохирц, нийцлийг шалган турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.4.1.Энэ хуулийн 17.4-т заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага сонгож, туршилт зохион байгуулах;

17.5.Насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр хангах, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Насан туршийн суралцахуйн төв нь боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын харьяанд байна.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг төлбөргүй зохион байгуулна.

17.7.Энэ хуулийн 17.5-д заасан төв нь танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлж болно.

17.8.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэнд болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжих төв ажиллуулж болно.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасан дэмжих төвийн үйл ажиллагааны зардлыг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

17.10.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүрэгтэй байна.

17.11.Энэ хуулийн 17.10-т заасан үнэлгээ, элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.12.Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага нь боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарыг эрх бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн асуудлыг хариуцсан чиг үүрэгтэй байна.

17.13.Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага нь магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, гадаадын хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

17.14.Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу боловсролын баримт бичиг, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа,

үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурын гишүүн Ч.Ундрамын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21-26 дугаар зүйлийг 21-24 дүгээр зүйл болгон, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“21 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан этгээд байгуулж болно.

21.2.Боловсролын сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг эрх бүхий этгээд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлж хүчингүй болгоно.

21.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 4  
Бүгд: 11  
63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

**22 дугаар зүйл.Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавих шаардлага**

22.1.Энэ хуулийн 21.1-д заасан этгээд зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг сургалтын үйл ажиллагаа эхлэхээс 6-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ:

22.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдийн гэрээ, танилцуулгын хамт;



22.1.2.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах хүний нөөц, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;

22.1.3.стандарт, техникийн зохицуулалтад заасан шаардлагыг хангасан зориулалтын хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биеийн тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, дадлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;

22.1.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;

22.1.5.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд зориулан гаргасан мөнгөн болон бусад хөрөнгийн жагсаалт, хэмжээ, баталгаа, боловсрол сургалтын байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл;

22.1.6.шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа;

22.1.7.ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан баримт бичиг, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага нийт багшийн 90-ээс доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсролын сургалтын байгууллага нийт багшийн 80-аас доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг;

22.1.8.цэрэг, цагдаа, төмөр замын мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын санал;

22.1.9.боловсролын сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, ял шийтгэл хүлээж байсан эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

22.1.10.татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүй талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.

22.2.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага бусад байгууллагад шилжүүлж болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан үндэслэлээр эрх хүлээн авагч тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж эрх шилжүүлсэн байгууллагад тайлагнана.

22.4.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх заалтын 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх,

сэргээх, хүчингүй болгох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

22.5.Мэргэжлийн боловсрол болон дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт эрхлэх магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 22.1.3-22.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх үйл ажиллагааны танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс 5-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

22.6.Энэ хуулийн 21.1-д заасан этгээд зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа хүсэлт, холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

22.7.Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд шинэ мэргэжлээр сургалт эрхлэх хүсэлтийг шийдвэрлэхэд энэ хуулийн 22.5-д заасан хугацаа хамаарахгүй.

### **23 дугаар зүйл.Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах**

23.1.Сургуулийн өмнөх, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас доошгүй байна. Ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрлийн хугацаа 12 жил байна.

23.2.Зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

23.3.Энэ хуулийн 22.1.10-г заасан татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй тохиолдолд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.

### **24 дүгээр зүйл.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах**

24.1.Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

24.1.1.үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;

24.1.2.зөвшөөрлийг хүчингүй болгосон;

24.1.3.татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

24.1.4.нийт суралцагчийг боловсролын сургалтын өөр байгууллагад шилжүүлсэн;

24.1.5.хуульд заасан бусад үндэслэл.

24.2.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдон үүсэх эд хөрөнгийн харилцааг Иргэний хууль, тогтоомжид заасны дагуу зохицуулна.

24.3.Татан буугдсан боловсролын сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох баримт бичгийг орон нутгийн болон үндэсний төв архивт хүлээлгэн өгнө.

24.4.Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах шийдвэрийг тухайн хичээлийн жилтэй уялдуулж суралцагчийн сурах эрхийг хөндөхгүйгээр эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 2

Бүгд: 11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзориг, Н.Учрал нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хариулж, тайлбар хийв.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.4, 33.1.6, 33.1.7, 33.1.9 дэх заалт, 33.3, 33.4 дэх хэсэг, 33.5.3, 33.6.3 дахь заалтыг хасаж, 33.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 33.1.12 дахь заалтад доор дурдсан агуулгатай тайлбар, 33.1.19 дэх заалт, 33.7, 33.8, 33.9 дэх хэсэг нэмж, 33.5.1, 33.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“Тайлбар: Ерөнхий боловсролын сургуулийн хоол, үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-г заасан “сургуулийн орчин” гэдэгт бүх түвшний боловсролын сургалтын байгууллагыг хамааруулна.

33.1.19.зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

33.7.Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.8.Нийслэлийн боловсролын газрын дарга, дүүргийн боловсролын хэлтсийн даргыг сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.9.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно.

33.5.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл, нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх;

33.6.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл, нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан байх;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 1

Бүгд: 11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, энэ хэсэгт доор дурдсан тайлбар нэмэх.

“43.2.Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломжийг хангах зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням хариулж, тайлбар хийв.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3-т заасны дагуу хураалгах санал:*

**Г.Мөнхцэцэг:** 7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5, 6.6 дахь хэсэг нэмэх:

“6.5.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.6.Боловсролын сургалтын байгууллагад судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна” гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн саналаа тайлбарлаж, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

**Г.Мөнхцэцэг:** 7.Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан, Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5, 6.6 дахь хэсэг нэмэх:

“6.5.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт, үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.6.Боловсролын сургалтын байгууллагад судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн саналаа тайлбарлаж, Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Ч.Ундрэм, ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан нар үг хэлэв.

**Г.Мөнхцэцэг:** 8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“43.4.1.өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох хувьсах зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11  
Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Чинзоригийн тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

**Г.Мөнхцэцэг:** 8.Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“43.4.1.өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох хувьсах зардал;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9  
Татгалзсан: 2  
Бүгд: 11  
81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Мөнхцэцэг:** 9.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 43.11 дэх хэсэг нэмэх.

“43.11.Энэ хуулийн 43.4.1-г заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж буй төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд олгохдоо гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн саналаар дахин санал хураалт явуулахыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8  
Татгалзсан: 3  
Бүгд: 11

Гуравны хоёроор дахин санал хураалгах санал дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Т.Доржхандын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан хариулж, тайлбар хийв.

**Г.Мөнхцэцэг:** 9.Ажлын хэсгийн гаргасан, Төсөлд доор дурдсан агуулгатай 43.11 дэх хэсэг нэмэх.

“43.11.Энэ хуулийн 43.4.1-г заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж буй төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд олгохдоо гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	10
Татгалзсан:	1
Бүгд:	11

90.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 35 минутад хэлэлцэж дуусав.*

***Нэг.Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /Засгийн газар 2021.06.24-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, Боловсрол, шинжлэх ухааны яамны Ерөнхий боловсролын бодлогын удирдлага, зохицуулалтын газрын дарга Б.Гантулга, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга Ж.Мягмар, Мэргэжлийн боловсрол, сургалтын хэлтсийн дарга А.Халиунаа, Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч А.Цолмон, шинжээч Ж.Нарантуяа, Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах шинжээч Ч.Баярмаа, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч У.Туяа, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Ш.Ариунаа, Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга З.Цогтгэрэл, Хувийн цэцэрлэгийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн А.Цэнгэл, Монголын хувийн хэвшлийн бага, дунд сургуулиудын холбооны тэргүүн Н.Номин, Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх Д.Билгүүдэй нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням танилцуулав.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг зүйл бүрээр хэлэлцэв.*

Хуулийн төслийн 1-30 дугаар зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

*Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.*

**Г.Мөнхцэцэг:** 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Амартүвшин, Ё.Баатарбилэг, Э.Батшугар, Б.Баярсайхан, Х.Булгантуяа, Х.Ганхуяг, Б.Жаргалмаа, Ц.Мөнх-Оргил, Г.Мөнхцэцэг, Ц.Мөнхцэцэг, Б.Пүрэвдорж, Ч.Ундрам, С.Чинзориг, Т.Энхтүвшин /цаашид “Ажлын хэсэг” гэх/ нарын гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж өөрчилж, 2.2 дахь хэсгийн “нэгдэн орсон” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “оюун ухаан” гэснийг “танин мэдэхүй” гэж, 3.2 дахь хэсгийн “ёс зүйтэй” гэснийг “ёс суртахуунтай” гэж, 3.3 дахь хэсгийн “Сургалтын байгууллага” гэснийг “Хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/, ерөнхий боловсролын сургууль” гэж, “захиргааны байгууллагатай” гэснийг “захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай” гэж өөрчилж, 3.3 дахь хэсгийн “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “3-5” гэснийг “2-5” гэж өөрчилж, “4.7 дахь хэсгийн “сургуульд” гэсний өмнө “ерөнхий боловсролын” гэж нэмж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“4.1.Сургуулийн өмнөх боловсролыг 4, бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшинэ гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн “танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу сургалтыг танхимын бус хэлбэрээр үргэлжлүүлэн” гэснийг “сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.3-д заасан хэлбэрээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ГУРАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “хөгжлийн онцлог” гэснийг “онцлог” гэж, 6.3 дахь хэсгийн “саналыг” гэснийг “санал, зөвшөөрлийг” гэж, 6.5 дахь хэсгийн “Энэхүү тогтоосон хугацаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байна” гэснийг “Тогтоох тохиолдолд ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөгөөр судлах хичээлийн цагийг бууруулахгүй.” гэж, 6.7, 6.9 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 6.7 дахь хэсгийн “сувилагчтай” гэснийг “сувилагч болон сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтантай” гэж өөрчилж, 6.1 дэх хэсгийн “Тайлбар”-ыг төслөөс хасаж, 6.4, 6.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Энэ хуулийн 6.3-т заасан ганцаарчилсан сургалт зохион байгуулахтай холбогдох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн дэмжлэг үзүүлэх журмыг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “монгол хэлээр” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 6.1-д заасан хэлээр” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийн “болон” гэснийг, 7.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 7.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.5 дахь хэсэг нэмэх:

“7.4.Энэ хуулийн 7.2-т заасан суралцагч Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т заасныг үндэслэн хос хэлний хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.5.Боловсролын ерөнхий хуулийн 6.6-д заасан суралцагч монгол дохионы болон бичгийн хэлээр боловсрол эзэмшинэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
-------------	---



Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “математикийн” гэсний дараа “болон цахим технологийн” гэж нэмж, 8.3 дахь хэсгийн “хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт хөтөлбөр” гэснийг “энэ хуулийн 8.2-т зааснаас гадна нэмэлт үйл ажиллагаа” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн гарчиг болон 9.1 дэх хэсгийн “сургалтын” гэснийг, 9.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Ерөнхий боловсролын агуулгыг Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т заасан агуулга болон математик-байгалийн ухааны, нийгэм-хүмүүнлэгийн, хэл-харилцааны, бие бялдрын, урлаг-гоо зүйн, цахим болон зохион бүтээх технологийн, иргэний боловсрол, амьдрах ухааны мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6  
Татгалзсан: 4  
Бүгд: 10  
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.4, 10.6, 10.8, 10.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслөөс 10.7 дахь хэсгийг хасах.

“10.1.Сургалтын хөтөлбөр нь үзэл баримтлалтай байна. Үзэл баримтлалыг Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан Үндэсний зөвлөл хэлэлцэж, Засгийн газар батална.

10.2.Сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 10.1-д заасан үзэл баримтлалд үндэслэн энэ хуулийн 8.2, 9.2-т заасан агуулгын хүрээнд боловсруулна.

10.4.Энэ хуулийн 7.4, 10.2, 10.3, 10.10-т заасан сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, Боловсролын ерөнхий хуулийн 14.8-д заасан цахим сургалтын хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6.Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөл нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах бичиг, хичээлийн жилийн бүтцийн талаар мэргэжлийн дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Зөвлөл нь багш, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангасан байна.

10.8.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрт эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой тохируулга хийж болно.

10.9.Боловсролын ерөнхий хуулийн 14.7-д заасан хугацаанд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сайжруулж болох бөгөөд сайжруулсан сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцсэн байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэснийг “3 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэж, мөн хэсгийн тайлбарын “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэснийг “Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасан цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэж, “0-2 настай” гэснийг “3 хүртэлх насны” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.11, 10.12 дахь хэсэг нэмэх:

“10.11.Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байна.

10.12.Энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн түүх, соёл, байгаль, цаг уурын онцлогийг тусгаж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3, 11.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Энэ хуулийн 10.6-д заасан мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн ерөнхий боловсролын сургалтад хэрэглэх сурах бичгийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.3.Сурах бичиг зохиоход багш, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбооны оролцоог хангаж, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, суралцагчийн төлөөллөөс санал авна.

11.9.Харааны бэрхшээлтэй болон энэ хуулийн 7.2-т заасан суралцагчид зориулан сурах бичгийг хөрвүүлнэ. Үндэстний цөөнх, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эх хэлний сурах бичгийг зохионо.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 2

Бүгд: 10

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “сурах бичиг зохиох турших, сургалтад ашиглахтай” гэснийг “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээхтэй” гэж, 11.6 дахь хэсгийн “хөтөлбөрийн хэрэгжилтийн” гэснийг “сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, 11.7 дахь хэсгийн “үнэ төлбөргүй” гэснийг “төлбөргүй” гэж, “ашиглуулна” гэснийг “ашиглуулах бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан бол сурах бичгийг худалдан авч болно.” гэж, 11.12 дахь хэсгийн “танин мэдэхүйн” гэснийг “сэтгэхүйн” гэж өөрчилж, 11.4 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмж, 11.10, 11.11 дэх хэсгийг төслөөс хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	2
Бүгд:	11

81.8 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “ахиулах зорилгоор” гэснийг “ахиулахад чиглэсэн” гэж өөрчилж, 12.1.3, 12.1.5 дахь заалт, 12.1.6 дахь заалтын “тайван амьдрах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь хэсгийн “дэг журмыг” гэснийг “дүрэм, журмыг” гэж өөрчилж, 13.1.1, 13.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.1.бие даан суралцах, хувь хүн, бүлэгтэй харилцах, хамтран ажиллах ур чадвараа хөгжүүлэх;

13.1.3.бусад суралцагчийг эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй, сурах, сургах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 14.2 дахь хэсгийн “хүүхдийн тооноос” гэснийг “хүүхдийн тоо, ялгаатай хэрэгцээнээс” гэж, мөн хэсгийн “бусад” гэснийг “холбогдох хууль тогтоомжид заасан” гэж, 14.4 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах болон холбогдох хууль тогтоомжид заасан ажилтан” гэж өөрчилж, 14.1 дэх хэсгийн “үйлчилгээний” гэснийг хасаж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эмч” гэсний дараа “номын санч” гэж, мөн доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх.

“14.6.Цэцэрлэгт сэтгэл зүйч, хоол зүйч ажиллуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ч.Ундрамын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр нар хариулж, тайлбар хийв.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “сургуулийн багш” гэснийг “ерөнхий боловсролын сургуулийн багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 15.1.1 дэх заалтын “сургалтын” гэснийг “боловсролын” гэж, 15.1.3 дахь заалтын “төлөвшил, авьяас чадварыг хөгжүүлэх, амжилттай суралцахад” гэснийг “мэдлэг, чадвар, авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд” гэж өөрчилж, 15.1.5 дахь заалтын “байгуулах” гэснийг, 15.1.1 дэх заалтын “бүрэн” гэснийг, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.2.Багш нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулан хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	6
Татгалзсан:	4
Бүгд:	10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15.1.2, 15.1.6 дахь заалт, 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.6 дахь хэсэг нэмэх:

“15.1.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хариу арга хэмжээ авахтай холбоотой бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;

15.1.6.хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө өгөх, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах.

15.5.Багш нь суралцагчийн хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.

15.6.Энэ хуулийн 27.2-г заасан суралцагчийн үнэлгээг бусдад задруулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Багш нь” гэсний дараа “дээд боловсролтой” гэж, 16.6 дахь хэсгийн “мэргэжил дээшлүүлсэн” гэсний дараа “магистр зэрэгтэй” гэж нэмж, 16.2 дахь хэсгийн “Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж, 16.7 дахь хэсгийн “түвшин” гэснийг “мэдлэг” гэж, “3-5 жил” гэснийг “3 жил” гэж өөрчилж, мөн зүйлийн гарчгийн “тасралтгүй” гэснийг, 16.5 дахь хэсгийн “үндэсний, орон нутгийн түвшинд болон ажлын байранд” гэснийг хасаж, 16.4 дэх хэсгийг 16.4, 16.5 дахь хэсэг болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“16.4.Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн, орон нутгийн, үндэсний түвшинд зохион байгуулна.

16.5.Энэ хуулийн 16.4-т заасан цэцэрлэг, ерөнхий боловсролын түвшинд зохион байгуулах багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 12.13-т заасан нэгж зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	3
Бүгд:	11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах,” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсэг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“17.1.8.боловсролын чанар, үр дүнг томилсон этгээд, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, энэ хуулийн 8 дугаар бүлэгт заасан байгууллагад хичээлийн жилд тайлагнах, хариуцах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой хэлбэрээр мэдээлэх.

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах гэрээгээр сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 3

Бүгд: 11

72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “ЗУРГААДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийн “СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА” гэсний өмнө “БОЛОВСРОЛЫН” гэж нэмж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“18.2.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, анги, бүлгийн зохион байгуулалтыг суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч уян хатан зохион байгуулах бөгөөд суралцагчийн тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

21.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “үйл ажиллагаандаа баримтлах” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 30.1.23-т заасан үлгэрчилсэн дүрэмд нийцсэн“ гэж, 18.7 дахь хэсгийн “өөрийн” гэснийг “өөрийн болон хөндлөнгийн” гэж өөрчилж, 18.1 дэх хэсгийн “хүүхдийн” гэснийг, 18.9, 18.10 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.11, 18.12, 18.13, 18.14 дэх хэсэг нэмэх.

“18.11.Ерөнхий боловсролын сургууль дотуур байртай байж болно. Дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих шаардлагыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж мөрдөнө.

18.12.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа суралцагчид зориулан энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааны хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлнэ.

18.13.Энэ хуулийн 18.12-т заасан хөтөлбөрийг Боловсролын ерөнхий хуулийн 43.1.2-т заасан хүүхдийн эрх, хамгааллын зардлаас санхүүжүүлнэ.

18.14.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь номын сантай байх бөгөөд Номын сангийн тухай хуулийн 10.3-т заасан үйлчилгээ үзүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

22.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг өөрчлөн найруулж, төсөлд 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг болгох.

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон холимог бүлгээр зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7

Татгалзсан: 4

Бүгд: 11

63.6 хувийн саналаар дэмжигдлээ.

23.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийг төслөөс хасаж, 20.14 дэх хэсгийн “энэ хуулийн 8.7-д” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 8.1-д” гэж өөрчилж, 20.4, 20.11, 20.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“20.4.Энэ хуулийн 20.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг тогтооход хөгжлийн бодлого, төлөвлөлт, хүн амын нягтаршил, газарзүйн байршил зэрэг хүчин зүйлийг харгалзана.

20.11.Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжсэн, ажил мэргэжлийн чиг баримжаатай болоход чиглэсэн хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.

20.16.Энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааг үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэдтэй хамтран зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

24.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.17 дахь хэсэг нэмэх.

“20.2.3.1-12 дугаар ангитай, эсхүл 6-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль;  
20.2.4.10-12 дугаар ангитай ахлах сургууль.

20.17.Энэ хуулийн 20.11-д заасан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 6

Татгалзсан: 4

Бүгд: 10

60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

25.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2 дахь заалтын “сургалт” гэсний дараа “, үйл ажиллагаа” гэж нэмж, 21.1.2 дахь заалтын “дэмжигч /явуулын/ багшийн” болон “нүүдлийн бүлгийн” гэснийг “хувилбарт” гэж, 21.3 дахь хэсгийн “боловсролын болон санхүү, төсвийн” гэснийг “боловсролын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 21.4 дэх хэсэг нэмэх:

“21.4.Хувилбарт сургалт нь энэ хуулийн 5.1-д заасан хугацаанд хамаарахгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

26.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн заах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8 дахь хэсэг нэмэх.

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргаж, энэ хуулийн 22.8.1-д заасан журмын дагуу 1-3 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг хүүхдэд гэрээр эзэмшүүлж болно.

22.8.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдэд гэрээр боловсрол эзэмшүүлэхэд тавих шаардлага, эрх, үүрэг, хариуцлага, сурлагын амжилтыг үнэлэх, баталгаажуулах журмыг Засгийн газар батлах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	5
Татгалзсан:	5
Бүгд:	10

50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

*Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.17-д заасны дагуу дээрх саналаар 3 удаа санал хураалт явуулав.*

**Г.Мөнхцэцэг:** Дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3



Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Мөнхцэцэг:** Нэг дэмжигдэж, нэг дэмжигдээгүй тул дээрх саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Мөнхцэцэг:** 27.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Боловсролын ерөнхий хуулийн 39.2-т заасан” гэж нэмж, 23.2.1 дэх заалтын “ хөгжил, бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад санал, дүгнэлт гаргах” гэж өөрчилж, 23.2.5 дахь заалтын “бүх талын оролцоог хангах” гэснийг, 23.2.4 дэх заалтыг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.8, 23.2.9 дэх заалт нэмэх:

“23.2.8.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийг эрэмбэлэх, шийдвэрлүүлэх, санал өгөх;

23.2.9.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

28.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.3 дахь заалтыг нэгтгэн 23.2.2 дахь заалт болгон өөрчлөн найруулж, мөн зүйлийн 23.2.6, 23.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“23.2.2.суралцагчийн хөгжил, төлөвшлийг дэмжих, сурлагын хоцрогдол үүсэхээс сэргийлэх, сурлагын ахиц гаргах, эрүүл, сургалтын аюулгүй орчин бүрдүүлэхэд санхүүгийн болон оролцооны дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг энэ хуулийн 18.8-д заасан байгууллагатай хамтран зохион байгуулах;”

23.2.6.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд аливаа дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтээс сэргийлэх, хүүхэд хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх;

23.2.7.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан гэрээнд тусгах саналыг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захиралд хүргүүлэх, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

29.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.4 дахь хэсэг нэмэх:

“25.4.Багшийн мэргэшүүлэх сургалт, үйл ажиллагааг энэ хуулийн 16.5-д заасан нэгжтэй хамтран зохион байгуулна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

30.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн мэргэжлийн” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан” гэж, 26.6 дахь хэсгийн “18.8-д заасан өөрийн” гэснийг “18.7-д заасан” гэж, 26.7 дахь хэсгийн “боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн санд” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага боловсролын цахим мэдээллийн санд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

31.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “1-2” гэснийг “1-3” гэж, 27.4 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 33-т заасан орон нутгийн” гэж, 27.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“27.6.Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг үндэслэн давтан сурах боломжийг суралцагчид олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

32.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг төслөөс хасаж, 28.3 дахь хэсгийн “заавал хамруулах үүрэг хүлээнэ” гэснийг “хамруулахад захиргааны дэмжлэг үзүүлнэ” гэж, 28.6 дахь хэсгийн “мэдээллийн” гэснийг “цахим” гэж өөрчилж, 28.4 дэх хэсгийн “орон нутгийн” гэсний дараа “цэцэрлэг” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.10, 28.11 дэх хэсэг нэмэх.

“28.10.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга түүнийг томилсон этгээд хооронд байгуулсан гэрээнд харьяа нутаг дэвсгэрийн хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хамруулах, боловсролын чанарын үзүүлэлтийг ахиулах талаар тусгана.

28.11.Ерөнхий боловсролын сургуульд суурилсан суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалт, бүртгэлийг бүрдүүлж, тодорхой насны давтамжтайгаар урьдчилан

сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

33.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7  
Татгалзсан: 3  
Бүгд: 10  
70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан, Төслийн 4.7-д хөдөө аж ахуйн салбарт ажилладаг өрхийн хүүхэд болон хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүүхдийг 7 настайд нь элсүүлж болно гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2  
Татгалзсан: 8  
Бүгд: 10  
20.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 12 цаг 12 минутад хэлэлцэж дуусав.*

***Гурав.Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайдын мэдээлэл сонсох***

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын дарга Ш.Алтангэрэл, мөн газрын ахлах мэргэжилтэн Н.Амарбаяр, Б.Амарзаяа, ахлах инженер Г.Цэрмаа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Р.Болормаа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих

ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан мэдээлэл хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан, Б.Жаргалмаа, С.Чинзориг нарын тавьсан асуултад Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсролын ерөнхий газрын дарга Т.Ням-Очир, мөн газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт, зохицуулалтын газрын ахлах инженер Г.Цэрмаа нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Баярсайхан үг хэлэв.

Байнгын хорооны гишүүд Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц, үр дүнгийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн мэдээллийг сонсов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 3 цаг 40 минут үргэлжилж, 16 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 68.7 хувийн ирцтэйгээр 13 цаг 17 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА

Г.МӨНХЦЭЦЭГ

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**  
2023 оны 06 дугаар сарын 20-ны өдөр,  
Мягмар гараг Төрийн ордон “Жанжин  
Д.Сүхбаатар” танхим 09 цаг 27 минут

**БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Мөнхцэцэг:** Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы 6 дугаар сарын 20-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны хуралдааны ирц бүрдсэн тул нээснийг мэдэгдье. Хуралдааны дэгийн дагуу ирцийг танилцуулъя. Ирцийн мэдээг сонсоё. Өнөөдрийн хуралдаанд Байнгын хорооны ирвэл зохих гишүүдээс ирц бүрдсэн байна.

Ингээд Амгалангийн Адыасүрэн орон нутагт ажиллаж байгаа юм байна. Пүрэв-Очирын Анужин ирсэн байна. Телуханы Аубакир чөлөөтэй байгаа юм байна. Ёндонпэрэнлэйн Баатарбилиг чөлөөтэй, Балжиннямын Баярсайхан ирсэн байна. Энхбаярын Батшугар ирсэн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн одоогоор тодорхойгүй байна. Гонгорын Дамдинням гишүүн ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа гишүүн ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн өвчтэй байна. Чинбатын Ундром гишүүн ирж байгаа. Ням-Очирын Учрал гишүүн тодорхойгүй байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн гишүүн ирсэн байна. Содномын Чинзориг гишүүн ирсэн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн ирсэн байна. Ирцийн мэдээг танилцууллаа.

Өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

3 асуудал хэлэлцэнэ.

Нэгдүгээрт Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд байгаа. Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Хоёрдугаарт Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл байгаа. Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Гуравдугаарт төрийн өмчийн ЕБС цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц үр дүнгийн талаар Боловсрол шинжлэх ухааны сайдын мэдээллийг сонсохоор байгаа. Ингээд ийм 3 асуудлыг өнөөдрийн хуралдаанаараа хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гиш гишүүн байна уу? Баярсайхан гишүүн. Баярсайхан гишүүний микрофоныг өгье.

**Б.Баярсайхан:** Байнгын хорооны гишүүддээ өглөөний мэнд хүргэе.

Өнөөдрийн хэлэлцэх асуудлын дараалалд нэмж оруулах бол санал байхгүй.

Хэлэлцэх асуудлын 3 дугаарт байгаа Ерөнхий боловсролын сургуулийн болоод цэцэрлэг, дотуур байрны модон жорлонг орчин үеийн ус ариун цэврийн байгууламжаар солих энэ ажлын дэд хэсгийн танилцуулгыг одоо 1 дүгээрт хэлэлцэж өгнө үү. Яагаад гэвэл өмнөх Байнгын хорооны хурлуудаар яг хууль хэлэлцээд л араас нь одоо яг ийм чухал асуудлууд дээр 1 дүгээрт гишүүдийн ирц хангалтгүй байна. Жорлонгийн асуудал бол өнөөдөр бас улс орны хэмжээнд тулгамдсан асуудал байгаа. Одоо барилгын цөвхөн хоног үлдэж байна.

Гишүүдээ бүрэн ирцтэй өглөө ийм сайхан сэргэлэн цовоо байгаа дээр нь энэ жорлонгийн ажлынхаа талаар сонсчихмоор байна. Тэгээд энэ асуудлыг дэмжиж өгнө үү гэж хүсэж байна. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Баярсайхан гишүүн хэлэлцэх асуудлын дараалалд өөрчлөлт оруулж өгнө үү гэсэн санал гаргалаа.

Тэгээд дэгийнхээ дагуу Монгол Улсын Их Хурлын чуулганы хурлын дэгийн тухай хуулийн 4.1.3-д Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал журмын талаар гаргасан саналыг хэлнэ гээд ингээд дэгтэй.

Тийм учраас энэ дээр санал хураалт явуулах ёстой. Тэгээд бас одоо Баярсайхан гишүүний гаргасан саяын одоо дараалал өөрчилж гэдэг санал дээр санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Энэ санал дэмжигдсэнгүй.

Хэлэлцэх асуудалдаа оръё.

Ер нь бол ерөнхий хуулиа одоо эцэслэж байгаа учраас энийгээ эхэлж явуулаад тэгээд явчихъя. Боловсролын ерөнхий хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Дэгийн тухай хуулийн 42.1.1-д нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэгийг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг тараасан болно.

Ингээд ажлын хэсгээ оруулъя. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Ажлын хэсэгт ирсэн гишүүдийг танилцуулъя. Лувсанцэрэнгийн Энх-

Амгалан Боловсрол, шинжлэх ухааны сайд, Ганболдын Ганбаяр Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд, Төмөр-Очирын Ням-Очир Боловсролын ерөнхий газрын дарга, Ононгийн Хуягцогт Боловсрол, шинжлэх ухаан яамны Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга. Алтаньямын Мөнх-Оргил БШУЯ-ны Санхүүгийн хэлтсийн дарга, Жадамбын Мягмар БШУЯ-ны Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн дарга, Жамцын Нарантуяа БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын шинжээч, Пүрэвдоржийн Бат-Эрдэнэ Сангийн яамны Төсвийн зарлагын хэлтсийн дарга, Ухнаагийн Туяа Боловсрол, шинжлэх ухааны судалгааны үндэсний хүрээлэнгийн секторын эрхлэгч, Төмөрпүрэвийн Намнан ШУТИС-ийн захирал, Шажинбатын Ариунаа Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэнгийн Эрдэм шинжилгээний ажилтан, шинжлэх ухааны доктор профессор. Манайхан босоод өөрсдийгөө нэрийг нь хэлэхээр танилцуулаад байгаарай. Чимэдрэгзэнгийн Баярмаа БШУЯ-ны Хууль эрх зүйн хэлтсийн шинжээч, Арьяагийн Цолмон БШУЯ-ны Боловсролын нэгдсэн бодлого төлөвлөлтийн газрын ахлах шинжээч, Авирмэдийн Халиунаа БШУЯ-ны Мэргэжлийн боловсрол сургалтын хэлтсийн дарга, Дарьсүхбаатарын Билгүүдэй Боловсрол, шинжлэх ухааны сайдын орон тооны бус зөвлөх, Замбалын Цогтгэрэл Монголын боловсрол, шинжлэх ухааны үйлдвэрчний эвлэлийн холбооны дарга, Наранцэцэгийн Номин Монголын хувийн хэвшлийн бага дунд сургуулиудын холбооны тэргүүн, Алтангэрэлийн Цэнгэл Хувийн цэцэрлэгүүдийн үүсгэн байгуулагчдын холбооны тэргүүн, Ганхуягийн Анударь Монголын оюутны холбооны ерөнхийлөгч, Дондогдуламын Тунгалаг Бүх нийтийн боловсролын төлөө Иргэний нийгмийн үндэсний эвслийн ерөнхий зохицуулагч ийм бүрэлдэхүүнтэй өнөөдрийн хуралдаанд оролцож байна.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх танилцуулгыг ажлын хэсгийн

ахлагч Улсын Их Хурлын гишүүн Дамдинням танилцуулна.

Дамдинням гишүүний микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Боловсролын ерөнхий хуулийн төслийн талаарх одоо Улсын Их Хурлын анхдугаар хэлэлцүүлэг зарчмын зөрүүтэй 70 гаруй саналууд хураагаад өнгөрсөн 7 хоногт явсан. Энэ одоо хэлэлцүүлгийн үед Улсын Их Хурлын гишүүдээс санал гаргасны дагуу 6 одоо зарчмын зөрүүтэй санал дээр чиглэл өгөгдсөн байгаа. Санал хураалгүйгээр. Улсын Их Хурлын дэгийн тухай хуулиараа санал хураагдчихсан одоо саналууд дээр чиглэл өгөх нь одоо хориотой учраас санал хураагдаагүй байгаа одоо 6 санал дээр бид одоо ажлын хэсэг хуралдаж зарчмын зөрүүтэй саналууд дээрээ шийдвэрээ гаргасан байгаа. Тэгээд эрхэм гишүүд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаанд хэлэлцэхэд бэлэн болсныг илэрхийлье. Баярлалаа. дэмжиж өгөхийг хүсье.

**Г.Мөнхцэцэг:** Улсын Их Хурлын даргын гүйцээн боловсруулах чиглэлийн дагуу зарчмын зөрүүтэй 6 саналын томъёоллоор одоо санал хураалт явуулахаар ингээд бэлтгэсэн байгаа.

Ингээд санал хураалтдаа оръё.

Танилцуулгатай холбоотойгоор өөр одоо асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна санал хураалтдаа оръё.

Санал хураалт.

Боловсролын ерөнхий хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1-д заасны дагуу Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаас гүйцээн боловсруулах чиглэл

өгсний дагуу боловсруулсан зарчмын зөрүүтэй саналын томъёолол.

1.Төслийн 12 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“12 дугаар зүйл.Багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн тогтолцоо**

12.1.Багш, ажилтан нь боловсролын хууль тогтоомж Хөдөлмөрийн тухай хуулийн 17.6-д заасан ажил мэргэжлийн стандарт болон албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

12.2.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлж, амжилттай төгсөгчийг багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагад элсэн суралцахад нь төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.2.1.энэ хуулийн 12.2-т заасан дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална.

12.2.2.энэ хуулийн 12.2-т заасан багш мэргэжлийн сонгон бүлэг хичээллүүлэх журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.3.Багш ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааны журам, сургалтын хөтөлбөрт тавих шаардлагыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.4.Багшийг дээд боловсролын сургалтын байгууллагын магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрөөр бэлтгэх бөгөөд багшаас бусад мэргэжилтэй иргэн багш бэлтгэх хувилбарт сургалтад хамрагдан багшаар ажиллаж болно.

12.5.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөр нь энэ хуулийн 5.1.4-т заасан зарчимд үндэслэсэн, Хөдөлмөрийн тухай

хуулийн 16.7-д заасан ажил мэргэжлийн стандартад нийцсэн байна.

12.6.Багш бэлтгэх сургалтын хөтөлбөрөөр амжилттай суралцсан суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дэмжлэг төрөөс үзүүлнэ.

12.7.Сургуулийн өмнөх, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш нь багшлах эрхийн гэрчилгээтэй байна.

12.8.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 8.5-д заасан багшлах эрхийг энэ хуулийн 12.7-д заасан багшлах эрхийн гэрчилгээтэйд тооцно.

12.9.Аймаг, сум, дүүргийн захиалга эсхүл өөрөө хүсэлт гаргаж багш хүрэлцээгүй төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд 3 буюу түүнээс дээш жил мэргэжлээрээ ажиллах гэрээ багшид төрөөс дэмжлэг үзүүлнэ.

12.10.Багшийн мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг үндэсний болон орон нутгийн түвшинд багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагыг түшиглэн тухайн түвшний боловсролын сургалтын байгууллага боловсролын харилцаанд оролцогч талуудтай хамтран зохион байгуулна.

12.11.Багшийн мэргэжлийн хөгжлийн цахим системтэй байна.

12.12.Багшийн хөгжлийг дэмжих тухай хуулийн 3.1.3-т заасан төв нь багш, ажилтны мэргэжлийн хөгжлийн үйл ажиллагааг тухайн боловсролын байгууллагын түвшинд зохион байгуулах чиг үүрэг бүхий бие даасан нэгжтэй байх бөгөөд нэгжийн жишиг бүтэц, орон тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.13.Төрийн болон орон нутгийн өмчийн сургуулийн өмнөх, ерөнхий

боловсрол, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтныг өөртэй нь тохиролцсоны дагуу хамран сургах тойргийн болон сум дахь боловсролын сургалтын байгууллагын адил чанарын өөр ажилд шилжүүлэн ажиллуулж болно.

12.14.Энэ хуулийн 12.13-т заасан багш, удирдах ажилтныг шилжүүлэн ажиллуулах хугацаа, журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

12.15.Багш хүрэлцээгүй цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд багш бэлтгэх дээд боловсролын сургалтын байгууллагын төгсөх ангийн суралцагчийг Хөдөлмөрийн тухай хуулийн 62 дугаар зүйлд заасан дагалдан багшаар ажиллуулж болно.

12.16.Багш нь үндсэн ажлын цагаас бусад цагт өөр ажил олгогчтой зэрэгцсэн хөдөлмөрийн гэрээ байгуулж, нэмэлт орлого олж болно. Энэ харилцааг Хөдөлмөрийн тухай хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

80 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 13 дугаар зүйлийн 13.2.11 дэх заалтын “ажил хаялт” гэснийг “суралцагчийн эрхийг зөрчих” гэж өөрчилж, мөн заалтын “удирдах ажилтан” гэсний өмнө “багш,” гэж, 13.2.12 дахь заалтын “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж, 13.3.3 дахь заалтын “нийгмийн ажилтан” гэсний дараа “хоол зүйч, сэтгэл зүйч,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 13.2.17, 13.2.18, 13.2.19, 13.3.7, 13.3.8 дахь заалт, 13.9 дэх хэсэг нэмэх:

“13.2.17.суралцагч болон сургалтын мэдээллийг цахим мэдээллийн санд хугацаанд нь бүртгэх, тайлагнах;



### 13.2.18.ажлын

гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдах, үр дүнд үндэслэн мэргэжлийн хөгжлийн хэрэгцээг тодорхойлж, төлөвлөх, хэрэгжүүлэх;

13.2.19.суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй хамтран ажиллах, зөвлөн туслах;

13.3.7.дээд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтанд өндөр насны тэтгэвэр тогтоолгоход Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу I удааагийн буцалтгүй тусламжийг тухайн боловсролын сургалтын байгууллагаас олгох;

13.3.8.төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежид 15-аас доошгүй жил тасралтгүй ажилласан багш, ажилтны нэг хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагад үнэ төлбөргүй, хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.

13.9.Багшаар боловсролын болон хөдөлмөрийн хууль тогтоомжид зааснаас бусад ажил үүрэг гүйцэтгүүлэхийг хориглоно.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт явуулъя.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

Дамдинням гишүүн Чинбүрэн гишүүдийн техник ажиллаагүй байна.

Энийг протоколоор дэмжсэн тооцоод оруулъя. Жаргалмаа гишүүн.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ж.Чинбүрэн нарын “дэмжсэн” санал “эсрэг” гарсан тул

дэмжсэнээр тооцож, 80 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Төслийн **“ГУРАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА”** гэж өөрчилж, 17 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, 19, 20 дугаар зүйлийг төслөөс хасах.

“17.1.Боловсролын байгууллага нь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн, үнэлгээний, чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага, насан туршийн суралцахуйн төв болон сургалтын байгууллагаас бүрдэнэ.

17.2.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бодлогын суурь болон хавсарга судалгаа, шинжилгээ, инновац, арга зүйн сургалтын ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий байгууллага байна.

17.3.Энэ хуулийн 17.2-т заасан байгууллагыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд заасны дагуу байгуулна.

17.4.Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сургалтын арга зүй, үнэлгээ, сурах бичгийн тохируц, нийцлийг шалган турших түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуультай байж болно.

17.4.1.энэ хуулийн 17.4-т заасан түшиц цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага сонгож, туршилт зохион байгуулах;

17.5.Насан туршийн суралцахуйн төв нь иргэний албан, албан бус сургалтаар боловсрол эзэмших, бие даан суралцахад мэдээллээр хангах, зөвлөн туслах, удирдан зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Насан туршийн суралцахуйн төв нь боловсролын асуудал

эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяанд байна.

17.6.Энэ хуулийн 17.5-д заасан төв нь бичиг үсгийн болон ерөнхий боловсрол нөхөн эзэмшүүлэх сургалтыг төлбөргүй зохион байгуулна.

17.7.Энэ хуулийн 17.5-д заасан төв нь танхимын сургалтад хамрагдах боломжгүй хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол, эрүүл мэнд, нийгмийн халамжийн цогц үйлчилгээг Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд заасан түншлэлийн гэрээгээр хэрэгжүүлж болно.

17.8.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрүүл мэнд болон хөдөлмөр, нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүний боловсрол эзэмшихэд дэмжих төв ажиллуулж болно.

17.9.Энэ хуулийн 17.8-д заасан дэмжих төвийн үйл ажиллагааны зардлыг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран хэрэгжүүлнэ.

17.10.Боловсролын үнэлгээ, арга зүйн байгууллага нь боловсролын бүх түвшиний үнэлгээ, элсэлтийн шалгалт зохион байгуулах, хүний мэдлэг, чадвар, чадамжийг үнэлэх, хүлээн зөвшөөрөх, баталгаажуулах, үнэлгээний хөгжлийг хангах чиг үүрэгтэй байна.

17.11.Энэ хуулийн 17.10-т заасан үнэлгээ, элсэлтийн шалгалтын журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

17.12.Боловсролын чанарын баталгаажуулалт-магадлан итгэмжлэлийн байгууллага нь боловсролын сургалтын байгууллага, сургалтын хөтөлбөрийн чанарыг эрх

бүхий байгууллагын баталсан стандарт, шаардлагын дагуу магадлан итгэмжлэх, чанарын баталгаажуулалтыг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, арга зүйгээр хангах, мэргэшлийн үндэсний шаталсан бүтцийн асуудлыг хариуцсан чиг үүрэгтэй байна.

17.13.Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага нь магадлан итгэмжлэл хийх эрхийг дотоодын байгууллагад олгох, гадаадын хуулийн этгээдэд Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 7.9-д заасны дагуу тусгай зөвшөөрөл олгох гадаадын болон олон улсын эрх бүхий байгууллагатай хамтарсан магадлан итгэмжлэл хийх, олон улсад магадлан итгэмжлүүлсэн хөтөлбөрийг бүртгэх, баталгаажуулах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

17.14.Энэ хуулийн 17.12-т заасан байгууллага олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу боловсролын баримт бичиг, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх судалгаа, үнэлгээ хийх, баталгаажуулах сантай байна.” Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

Санал хураалт санал хураалтыг цуцалъя. Ундром гишүүн асуултаа асууя.

Ажлын хэсэг дээр бид нар баахан ярьчихсан л даа. Ундром гишүүний микрофоныг өгье.

**Ч.Ундром:** Энэ Боловсролын ерөнхий хууль дээр энэ элсэлтийн шалгалтын журмыг одоо боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална гээд эрхийг нь бол Засгийн газрын гишүүнд өгчхөж байгаа юм. Тэгээд яг энэтэй холбоотойгоор яг өнөөдөр нийгэмд бас нэлээн олон одоо асуудлууд бухимдал бас үүсээд байна л даа.

Нэгдүгээрт энэ элсэлтийн ерөнхий шалгалтыг олон удаа авдаг болъё гэж байгаа юм. Тэгээд яг нөгөө бодитоор олон удаа авч бид нар чадаж байна уу? Цаашид

ер нь хэдэн удаа авдаг болох юм бэ?  
Нэгдүгээрт.

Хоёрдугаарт энэ агуулга арга зүйг нь бид нар шинэчлэхгүй бол одоо хэмжээст оноо энэ тэр гээд зөндөө бас маргаанууд нийгэмд яваад байна л даа. Тэгэхээр энэ элсэлтийн шалгалтынхаа агуулгыг сайжруулах үнэлгээний арга зүйг нь сайжруулах тал дээр ямар арга хэмжээ яамнаас авч байгаа вэ?

Гуравдугаарт элсэлтийн ерөнхий шалгалтыг хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдэд илүү нээлттэй болгомоор байна. Энэ хүүхдүүдэд одоо шалгалтдаа зарцуулах цагийг нь уртасгах мөн одоо янз бүрийн бэрхиээлд нь тохируулж тийм тохируулгууд хийх шаардлагатай байна гэсэн ийм хүсэлтүүдийг эцэг эхээс ирүүлж байна. Тэгэхээр энэ дээр ямар арга хэмжээ авч байгаа вэ? Яг нөгөө цаг үеийн асуудал учраас би энэтэй уялдуулж асуугаад байгаа юм шүү.

**Г.Мөнхцэцэг:** Цаг үеийн асуудал тэгээд хуульд бас зүйл заалтаар орж байгаатай холбогдуулаад Ундрам гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулья.

**Л.Энх-Амгалан:** Ундрам гишүүн энэ элсэлтийн ерөнхий шалгалтын өмнө бид нар энэ тогтолцоо талаас нь бас нэлээн өөрчлөлтүүд хийе гэж бид нар төлөвлөж байгаа. Тэгээд өнгөрсөн жилээс та бүхэн анзаарсан байх. Жилд 2 удаа элсэлтийн ерөнхий шалгалтыг өгүүлдэг болсон шүү дээ. Жилд 2 удаа энэ бол хүүхдүүдэд илүү их тийм боломж олгож байгаа ийм тогтолцоо байгаа, нэгд.

Хоёрт бол хойтон жилээс бид нар ерөнхийдөө энэ элсэлтийн ерөнхий шалгалт өгч байгаа энэ хичээлүүдийг жаахан дотор нь задлаад түвшин бүр дээр одоо жишээ нь математикийн хичээлийн юуг бол яг түвшин, А, М, С гэдэг түвшин дээр бас 3 хуваасан. Ийм түвшин дээр болгоё гэж яаж байгаа?

Яагаад гэвэл одоо математикаар цаашаа гүнзгийрүүлж суралцах хүүхдүүдийн одоо босго оноо нэг өөр байх одоо яг зөвхөн одоо нягтлан бодох болно гэдэг юм уу математик заавал ч үгүй суурьтай биш математикийн хичээл орох тэр нөгөө бакалаврынх нь сургалтад нь орох хүүхдүүдийнх нь түвшин өөр байдаг учраас бол түвшин түвшинд нь бид нар нэг задалъя гэж бодож байгаа.

Гуравдугаар асуудал бол бид нар ерөнхийдөө цаашидаа SAT-ын одоо зарчим руу шилжүүлбэ. Энэ нь бол илүү одоо зөв улс оронд одоо хүлээн зөвшөөрөгдсөн ийм юу учраас бол бид нар SAT-ын зарчмаар одоо явуулна гэсэн ийм өөрчлөлт шинэчлэлтүүдийг бид нар бас нэлээн төлөвлөж хийж байгаа гэдгийг би одоо хэлчихье. Хариуцлагатайгаар.

Хоёрт нь ерөнхийдөө энэ хөгжлийн бэрхиээлтэй хүүхдүүдийг одоо энэ элсэлтийн ерөнхий шалгалтад оруулах, энэ чиглэл рүү одоо бид нар тэгш хамран сургах одоо энэ зарчим манай Боловсролын ерөнхий хууль дээр энэ зарчим хамгийн том зарчим болж орж ирж байгаа учраас бол энэ дээр хөгжлийн ялгаатай хэрэгцээтэй хүүхдүүд тэгш хамран сурах зарчмаар бол хүүхдүүддээ энэ боломжуудыг олгох энэ тогтолцоогоо бид нар хийгээд явна. Энэ хуулиар бол энэ юунууд нь одоо зарчмууд нь тусгагдаад явж байгаа гэж ойлгож болно.

**Г.Мөнхцэцэг:** Хариулт хангалттай.

Санал хураалт явуулья.

Энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

4.Төслийн 21-26 дугаар зүйлийг 21-24 дүгээр зүйл болгон, доор дурдсанаар өөрчлөн найруулах:

**“21 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

21.1.Боловсролын сургалтын байгууллагыг энэ хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлага хангасан этгээд байгуулж болно.

21.2.Боловсролын сургалт эрхлэх үйл ажиллагаатай холбоотой зөвшөөрлийг эрх бүхий этгээд Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу олгоно.

21.3.Орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийг байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

21.4.Зөвшөөрөл олгосон эрх бүхий этгээд нь Зөвшөөрлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг түдгэлзүүлж хүчингүй болгоно.

21.5.Гадаад улсад Монгол Улсын үндэсний хөтөлбөрөөр боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх асуудлыг тухайн улсын эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа Дипломат төлөөлөгчийн газар, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Санал хураалт.

Энэ санал 63.6 хувиар дэмжигдлээ.

## **22 дугаар зүйл.Зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичиг түүнд тавих шаардлага**

22.1.Энэ хуулийн 21.1-д заасан этгээд зөвшөөрөл авахдаа Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах баримт бичгийг сургалтын үйл

ажиллагаа эхлэхээс б-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ:

22.1.1.боловсролын сургалтын байгууллага байгуулах тухай хүсэлт, шийдвэр, дүрэм, үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдийн гэрээ, танилцуулгын хамт;

22.1.2.сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, багшлах хүний нөөц, боловсролын түвшин, зэрэг, цолны судалгаа, баримт бичгийн хуулбар, хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа;

22.1.3.стандарт, техникийн зохицуулалтад заасан шаардлагыг хангасан зориулалтын хичээлийн байр, номын сан, лаборатори, дадлагын газар, тоног төхөөрөмж, биений тамирын заал, талбай, хоол үйлдвэрлэлийн байр, ном, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн, тэдгээрийн баталгаа, зураг, дадлагын газар, сургалтын орчин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалт;

22.1.4.санхүүгийн эх үүсвэр, хүчин чадал, тооцоо, түүний баталгаа, нэг суралцагчид ногдох зардал, мэргэжлийн өртгийн тооцоолол;

22.1.5.боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаанд зориулан гаргасан мөнгөн болон бусад хөрөнгийн жагсаалт, хэмжээ, баталгаа, боловсрол сургалтын байгууллагын эзэмшил газрын зөвшөөрөл;

22.1.6.шашны сургалт, зан үйл, түүнтэй холбоотой үйл ажиллагааг зохион байгуулахгүй талаарх баталгаа;

22.1.7.ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөр хэрэгжүүлэхийг батламжилсан баримт бичиг, сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын байгууллага нийт багшийн 90-

ээс доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг, мэргэжлийн боловсрол, техникийн болон дээд боловсролын сургалтын байгууллага нийт багшийн 80-аас доошгүй хувийг мэргэжлийн үндсэн багш ажиллуулахыг нотолсон баримт бичиг;

22.1.8.цэрэг, цагдаа, төмөр замын мэргэжлийн чиглэлээр сургалтын үйл ажиллагаа эрхлэх, шинэ мэргэжлээр сургалт эрхлэх тохиолдолд холбогдох төрийн захиргааны төв байгууллагын санал;

22.1.9.боловсролын сургалтын байгууллагад гадаадын харьяат багш, удирдах ажилтан ажиллах тохиолдолд багшийн мэргэжлийн үнэмлэхийн хуулбар, ял шийтгэл хүлээж байсан эсэх талаар эрх бүхий байгууллагын тодорхойлолт;

22.1.10.татвар, нийгмийн даатгалын өр төлбөргүй талаарх тодорхойлолт, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, сургалт эрхлэх зөвшөөрөлтэй тохиолдолд түүний хуулбар.

22.2.Зөвшөөрөл олгох эрх бүхий этгээд зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох эрхээ Зөвшөөрлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага бусад байгууллагад шилжүүлж болно.

22.3.Энэ хуулийн 22.2-т заасан үндэслэлээр эрх хүлээн авагч тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу шийдвэрлэж эрх шилжүүлсэн байгууллагад тайлагнана.

22.4.Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дэх заалтын 7.9-д заасан тусгай зөвшөөрлийг олгох, сунгах,

түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох асуудлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэнэ.

22.5.Мэргэжлийн боловсрол болон дээд боловсролын шинэ мэргэжлээр сургалт эрхлэх магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, Зөвшөөрлийн тухай хуульд заасан баримт бичгээс гадна энэ хуулийн 22.1.3-22.1.9-д заасан баримт бичиг, шинээр эрхлэх үйл ажиллагааны танилцуулга, тооцоог сургалтын үйл ажиллагаа эхлэхээс 5-аас доошгүй сарын өмнө зөвшөөрөл олгох эрх бүхий этгээдэд цахимаар ирүүлнэ.

22.6.Энэ хуулийн 21.1-д заасан этгээд зөвшөөрлийн шаардлагыг бүрэн хангасны дараа хүсэлт, холбогдох баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж эрх бүхий байгууллагад ирүүлнэ.

22.7.Тэргүүлэх мэргэжлийн чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэх, шинэ техник, технологи нэвтрүүлэх, олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх тохиолдолд шинэ мэргэжлээр сургалт эрхлэх хүсэлтийг шийдвэрлэхэд энэ хуулийн 22.5-д заасан хугацаа хамаарахгүй.

Санал хураалт.

Энэ санал хураалтыг цуцалъя. Чинзориг сайд уг авъя гэсэн. Чинзориг сайдын үгийг сонсьё.

**С.Чинзориг:** Энэ нөгөө зөвшөөрөл олгохтой холбоотойгоор л баахан юм орж ирж байгаа юм байна даа. Зөвшөөрлийн хууль батлагдаад энэ оны нэг сараас хэрэгжиж эхэлж байгаа. Зөвшөөрлийн хуулиар чинь бол Зөвшөөрлийн хуульд зааснаас бусад одоо өөр материал шаардахыг нь бол бас хязгаарласан ийм хууль батлагдсан даа. Энийг одоо яаж зохицуулах юм бол.

Хоёр дахь асуудал нь Зөвшөөрлийн энэ олгохтой холбоотой асуудлаа Зөвшөөрлийнхөө тухай хуульд нийцүүлж байгаа юм уу? Зөвшөөрлийнхөө тухай хуулиар зохицуулахгүй ингээд салбарынхаа одоо хуулиар зохицуулж болж байгаа юм уу? Хир одоо оновчтой юм бэ?

Гурав дахь асуудал нь Зөвшөөрлийн тухай хуульд чинь өөрчлөлт ороод Зөвшөөрлийн асуудал эрхэлсэн үндэсний хороо гээд байгуулагдсан. Тэгээд Зөвшөөрлийн тухай хуульд өөрчлөлт орохоор бол тэр зөвшөөрлийн асуудал эрхэлсэн Үндэсний хороо буюу Ерөнхий сайд ахалсан нэг хороо байгуулахаар болчихсон юм шүү дээ. Тэр хороогоор хэлэлцүүлж байж тэр Үндэсний хорооны саналыг одоо авч байж Зөвшөөрлийн хуульд өөрчлөлт орно энэ тэр гээд ийм нэг зохицуулалтууд нэлээн хязгаарлалтууд Зөвшөөрлийн хуульд орчихсон юм даа.

Тэгээд энэ маань тэр зөвшөөрлийнхөө одоо хуулиудтай нийцэж байгаа юм болов уу даа. Ажлын хэсгийн дарга хариулах байх даа.

**Г.Мөнхцэцэг:** Чинзориг сайдын асуултад Энх-Амгалан сайд хариулах юм уу? Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн хариулъя.

**Г.Дамдинням:** Чинзориг гишүүн их чухал юм асууж байна. Тэгээд яах вэ Зөвшөөрлийн тухай хууль Улсын Их Хурлаас батлагдаад гарсан 1600 орчим байсан зөвшөөрлийг 300 гаруй руу аваачиж бас энэ хүнд суртлыг арилгах чиглэлийн их том дэвшил гарсан. Энэ дэвшилтэй Боловсролын ерөнхий хууль зөрчилдөх зүйл ерөөсөө байхгүй байгаа. Зөвшөөрлийн ерөнхий хуулийг ахалж ажилласан Улсын Их Хурлын гишүүн Ганхуяг, мөн бас тэр хууль дээр ажилласан хууль, эрх зүйн газрын референтүүд бас Ундром гишүүн гээд. Ингээд энэ гишүүдтэй хамтарч Боловсролын ерөнхий хуулийнхаа төслийг танилцуулаад тэгээд бас зөрчил элдэв

одоо нэмэлт зүйлгүйгээр гаргасан байгаа. Бүх зүйл Зөвшөөрлийн хуультай уялдаж нийцсэн зохицуулалттай байгаа гэж хэлье.

**Г.Мөнхцэцэг:** Санал хураалтдаа оръё. Түрүүчийн одоо хураалгасан 22 дугаар. Учрал гишүүн асуух юм уу? Чинзориг гишүүний асуулт дээр нэмж хариулах гээд байгаа юм уу? Учрал гишүүн санал хэлье.

Учрал гишүүний микрофоныг өгье.

**Н.Учрал:** Энэ маргааш Засгийн газрын хурлаар тэр нөгөө макро эдийн засгийг тогтворжуулах талаарх тэр тогтоол гарах юм байна лээ. Тэр тогтоол дээр яг энэ зөвшөөрөлтэй холбоотой нөгөө зөвшөөрлийн хуульд заасны дагуу зөвшөөрлийг 8 сарын 1-нээс өмнө бүгдийг нь цахимжуул гээд ийм тогтоол гарч байгаа шүү дээ. Тэгээд тэр тогтоолын дагуу гол концепц нь болохоор ерөөсөө энэ Зөвшөөрлийн хуульд зааснаас бусад тохиолдолд нэмэлт шаардлага тавиад ямар нэгэн одоо сайдын тушаал бодлого чиглэл Засгийн газрын тогтоол гаргах ийм бололцоогүйгээр л энэ тогтоолыг гаргаад хааж байгаа байхгүй юу.

Тэгэхээр тэр 360 зөвшөөрлөөс чинь зарим нь хүн хамаарахгүйгээр шууд эргээд тэр хариуг нь цахимаар өгчихдөг энэ тогтолцоог бүрдүүлэх гээд л ингээд оролдоод байгаа юм.

Тэгэхээр яг энэ зөвшөөрөл авах баримт бичиг гэсэн энэ 22 дугаар зүйл дээр жишээ нь Зөвшөөрлийн тухай хуульд зааснаас гадна дараах бичиг баримтыг бүрдүүлнэ ээ. Зөвшөөрлийн хуульд зааснаас гадна гэдэг ийм 2 зүйл, заалт яваад байгаа байхгүй юу. Тэгээд яг Чинзориг гишүүний хэлээд байгаа чинь үнэн л дээ. Ингээд бүх хууль орж ирэхдээ Зөвшөөрлийн хуульд зааснаас гадна тийм тийм шаардлага бүрдүүлнэ гэвэл нөгөө зөвшөөрлийн хуулийн концепц бол бүрэн алдагдана шүү дээ.

Нэгэнт Зөвшөөрлийн хууль гарчихсан юм чинь тэр хуулийнхаа дагуу л зөвшөөрлөө аваад явах эрх үүрэг нь байгаа. Тэр хороогоороо хуралдаад л тэр жагсаалтууд нь бүүр ингээд Зөвшөөрлийн хууль дээр чинь ард нь ямар байгууллага олгох юм ямар зөвшөөрөл олгох юм гээд бүгд нээлттэй байгаа шүү дээ.

Одоо энэ фантам дээр олон ТҮЦ ажиллаад олон ингээд хоолны газар байгуулагдаад ингээд үйлчилгээ яваад байгаа чинь энэ Зөвшөөрлийн хуулийн л буян шүү дээ. Ямар нэгэн зөвшөөрөл авахгүй байгаа учраас ингээд л нэг жижиг жижиг хоолны газар үйлчилгээ ажиллуулаад л ингээд яваад байгаа шүү дээ. Гэтэл та нар Зөвшөөрлийн хуулийнхаа нөгөө яг үндсэн концепцыг эвдээд Зөвшөөрлийн хуулиас гадна тийм тийм юм бүрдүүлнэ гээд ингээд эхэлбэл цаашидаа ер нь бүх хууль дээр Зөвшөөрлийн хуулиа давж ороод ирвэл нөгөө 360 чинь буцаад л нэмэлт шаардлагыг бол ингэж давхар тавьж бол болохгүй л дээ. Энэ чинь дабль стандарт шүү дээ. Нэгэнт Зөвшөөрлийн хууль чинь зөвшөөрлийн хуулиар заагдаагүй бол бүртгүүлээд л ажлаа хий гэж байгаа шүү дээ. Мэдээж энэ бол тусгай зөвшөөрөл. Энэ боловсролын асуудал.

Тэгэхээр энэ бол мэдээж зөвшөөрөлтэй хуульдаа ч заачихсан. Гэтэл дахиад нэмэлт шаардлага тавиад байх чинь боломжтой юм уу? Дамдинням гишүүн бол өөрөө энэ Зөвшөөрлийн хуулийг одоо гол дэмжигч энэ хуулиараа их бахархаж явдаг хүн шүү дээ. Одоо энэ хуулиа одоо өөрөө ингээд эвдээд суугаад байна л даа.

**Г.Мөнхцэцэг:** Учрал гишүүний саяын хэлээд байгааг бас энд анхаарах шаардлагатай байгаад байна аа. Тэгэхээр энэ эхлээд Дамдинням гишүүн яачихъя ажлын дэд хэсгийнхнийг. Ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн.

**Г.Дамдинням:** Тэгэхээр Учрал гишүүн ээ ийм байгаа юм аа. Зөвшөөрлийн

хуулийн үндсэн санаа нь ерөөсөө л зөвшөөрлийг олгох, сунгах, цуцлахтай холбоотой бүхий л төрлийн харилцааг зохицуулж байгаа юм. Зөвшөөрлийн хууль дээр боловсролын салбартай холбоотой асуудлуудыг бас бүтэн хэмжээнд байхгүй байгаа учраас бид нар Зөвшөөрлийн хуулийг боловсруулсан ажлын хэсэгтэй, дэд хэсэгтэй Хууль зүйн байнгын хороотой ахалсан гишүүдтэй нь уулзаж эрх зүйн гаргалгаа бол бид нар хийсэн. Тийм энэ дээр бол одоо боловсрол бол бас онцгой салбар байгаа учраас бид нар одоо салбарынхаа онцлогоос хамаараад шаардагдах баримт бичгийн нөхцөлийг л бол өөрийнхөө хууль дээр суулгаж явахаас өөр аргагүй юм байна лээ. Тэгэхгүй бол бид нар одоо ямар ч шаардлага байхгүй. Одоо тийм байгууллагууд л үүсэх болчихоод байгаа юм. Зохицуулалтгүй гэсэн үг. Ямар ч эрх зүйн зохицуулалтгүй үүрэг хариуцлагагүй ийм одоо сургууль цэцэрлэгийн байгууллагууд руу л орчих гээд байгаа юм.

Тэгэхээр ахиад би хэлье зөвшөөрлийн хууль бол зөвшөөрлийг олгох, сунгах, цуцлахтай холбоотой харилцааг зохицуулна. Манай хууль дээр бол тавигдах шаардлагатай холбоотой асуудлууд л яригдаж байгаа юм. Тэгээд одоо зохицуулалттай болгож явах асуудлыг өөрийнхөө хууль дээр тусгаад явах эсвэл Зөвшөөрлийн хуульд оруулах тусгай эрх аваагүй ийм байгаа учраас бид нар энэ дээр одоо бид юу гэдэг юм хүндрүүлсэн, чирэгдүүлсэн, нэмэгдүүлсэн зүйл бол ерөөсөө байхгүй байгаа шүү Учрал гишүүн. Аль болох л хөнгөвчилж болгох одоо чиглэл рүү нь л хийсэн байгаа.

**Г.Мөнхцэцэг:** Тийм 22 дугаар зүйл дээр асуулт асууж бас одоо хариулт өглөө. 23 дугаар зүйл, 24 дүгээр зүйлийг уншиж танилцуулаад санал хураалт нэгдсэн санал хураалт явах ёстой.

**23 дугаар зүйл. Зөвшөөрлийн хугацаа, түүнийг сунгах**

23.1. Сургуулийн өмнөх, мэргэжлийн, техникийн, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацаа Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанаас доошгүй байна. Ерөнхий боловсролын сургууль байгуулах зөвшөөрлийн хугацаа 12 жил байна.

23.2. Зөвшөөрлийн хугацааг Зөвшөөрлийн тухай хуульд заасны дагуу сунгана.

23.3. Энэ хуулийн 22.1.10-т заасан татвар, нийгмийн даатгалын өр төлбөртэй тохиолдолд зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзана.

## 24 дүгээр зүйл. Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах

24.1. Боловсролын сургалтын байгууллагыг дараах тохиолдолд татан буулгана:

24.1.1. үүсгэн байгуулагчийн шийдвэрээр;

24.1.2. зөвшөөрлийг хүчингүй болгосон;

24.1.3. татан буулгах тухай шүүхийн шийдвэр гарсан;

24.1.4. нийт суралцагчийг боловсролын сургалтын өөр байгууллагад шилжүүлсэн;

24.1.5. хуульд заасан бусад үндэслэл.

24.2. Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгахтай холбогдон үүсэх эд хөрөнгийн харилцааг Иргэний хууль, тогтоомжид заасны дагуу зохицуулна.

24.3. Татан буугдсан боловсролын сургалтын байгууллага нь сургалтын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох баримт бичгийг орон нутгийн болон үндэсний төв архивд хүлээлгэн өгнө.

24.4. Боловсролын сургалтын байгууллагыг татан буулгах шийдвэрийг тухайн хичээлийн жилтэй уялдуулж суралцагчийн сурах эрхийг хөндөхгүйгээр эрх бүхий этгээд шийдвэрлэнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

81.8 хувиар дэмжигдлээ.

Түрүүчийн энэ Зөвшөөрлийн хуультай холбоотой энэ Учрал гишүүний гаргаад байгаа Чинзориг гишүүний хэлээд байгаа энэ зүйл заалтуудтайгаар дахиад цаашаа бас гүйцээн боловсруулаад найруулга дээр нь анхаараад ингээд явъя.

Найруулгаа засчхаарай. Цаашаа явъя. Хууль хоорондын зохицуулалт юмнуудыг нь анхаараад.

5.Төслийн 33 дугаар зүйлийн 33.1.4, 33.1.6, 33.1.7, 33.1.9 дэх заалт, 33.3, 33.4 дэх хэсэг, 33.5.3, 33.6.3 дахь заалтыг хасаж, 33.1.5 дахь заалтын “боловсролын” гэсний дараа “сургалтын” гэж, 33.1.12 дахь заалтад доор дурдсан агуулгатай тайлбар, 33.1.19 дэх заалт, 33.7, 33.8, 33.9 дэх хэсэг нэмж, 33.5.1, 33.6.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

33.1.19. зайн болон цахим сургалтын чанар, үр дүнг сайжруулах үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

33.7. Аймаг, нийслэлийн боловсролын газрын дарга сонгон шалгаруулалтын дүнг үндэслэн харьяа нутаг дэвсгэр дэх төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захирлыг томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.8. Нийслэлийн боловсролын газрын дарга, дүүргийн боловсролын хэлтсийн даргыг сонгон шалгаруулалтын



дүнг үндэслэн томилж, хуульд заасан үндэслэлээр чөлөөлнө.

33.9.Боловсролын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас баталсан аргачлалын дагуу хамран сургах тойргийг боловсролын асуудал эрхэлсэн орон нутгийн байгууллага тогтооно.

33.5.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл, нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан, магистраас доошгүй боловсролын зэрэгтэй байх;

33.6.1.боловсролын сургалтын байгууллагад 10-аас доошгүй жил, үүнээс боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах эсхүл, нийгмийн ажилтнаар 5-аас доошгүй жил ажилласан байх;" Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

90.9 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 43 дугаар зүйлийн 43.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, энэ хэсэгт доор дурдсан тайлбар нэмэх.

“43.2.Хувьсах зардлын хэмжээ, бүрэлдэхүүнийг сургуулийн байршил, мэргэжлийн чиглэл, сургалтын хөтөлбөр, суралцагчийн ялгаатай хэрэгцээг харгалзан суралцах тэгш боломжийг хангах зорилгоор боловсролын сургалтын байгууллагын түвшин бүрээр тогтоох бөгөөд санхүүжүүлэх журмыг Засгийн газар батална.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Энэ санал хураалтыг цуцалъя. Чинзориг сайд үг хэлье үг авъя гэж байна.

**С.Чинзориг:** Энэ юутай холбоотой юм бол. Нөгөө нэг хуулиар чинь бол үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэрэглээд л байгаа л даа. Тийм миний нэг яриад байдаг юм бол нөгөө алслагдсан сум, хүн амын тоо цөөтэй, сурагчийн тоо цөөтэй бол бас энэ чинь болохгүй байна. Ялангуяа багийн сургуулиуд дээр хүн ам цөөтэй, хүүхэд цөөтэй сургуулиуд дээр энэ чинь болохгүй байна гээд л яриад л байдаг байсан. Тэгээд тэрэнтэй холбоотой хувьсах зардлыг нь санхүүжүүлэх асуудал гэж ойлгож байгаа тийм үү?

Сургуулийн байршил, сургуулийн байршилтай холбоотой, хүүхдийн тоотой холбоотой асуудлаар тэгэхээр энэ дотор харин тэр байриллаасаа гадна тэр нөгөө суралцагчийн тоо хамаарна гэсэн юм байхгүй юм уу? Уг нь би бол тэгж л ойлгоод байгаа юм л даа. Яг тэр утгаар бол энэ бол болж байна. Манай хөдөөгийнхөн бол байнга л яриад байгаа юм л даа. Энийг бас л жаахан хүндрээд байна гээд л тэгж яриад байгаа юм.

**Г.Мөнхцэцэг:** Чинзориг гишүүний гаргаад байгаа саяын энэ тийм саналууд дээр ер нь бол бас хөдөө орон нутгуудад нэлээн бас одоо яригдаж байгаа ийм одоо саналууд байгаад байгаа. Тэгээд энэ дээр одоо яаж туссан юм энэ чиглэлийнх нь дагуу ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн тайлбар, хариулт өгчихье.

**Г.Дамдинням:** Тийм манай Чинзориг гишүүн тэгээд ялангуяа энэ хөдөө орон нутгаас сонгогдсон Их Хурлын гишүүд бүгдээрээ л энэ дээр санаа тавьж Боловсролын хууль дээр саналаа өгцгөөсөн. Тэгээд энэ үр дүнд суурилсан санхүүжилтийн системийг одоо боловсролын салбарт оруулж ирээд ер нь боловсролын реформын хамгийн том нэг багана нь өөрөө үндсэндээ энэ хэрэгжих үндсэн шалтгаан нь бол санхүүжилтийн хэсэг байхгүй юу.

Тэгэхээр бидний Боловсролын хуулийг боловсруулсан үндсэн концепт бол

тэгш боломжийг олгох Улаанбаатар хотын захын дүүрэгт байна уу? Эсвэл одоо Өвөрхангай аймгийн аль нэг одоо захын суманд байна уу, эсвэл Дорнод аймагт байна уу, Дорноговь аймагт байна уу хамаагүй. Бүгд тэгш боломжоор хангагдана. Тэгэхээр зарим хөдөөгийн сургуулиуд бол цөөхөн сурагчтай байдаг. Цөөхөн сурагчтай хэрээрээ бага, одоо хувьсах зардлаар санхүүжилт авдаг. Энэ хэрээрээ боловсролын чанар нь унаж байдаг.

Зарим газар бол жишээ нь төвөөс их алслагдсан байдалтай байгаад байгаа юм. Тэгэхээр энэ бүгдийг зохицуулах боломжийг л одоо энэ хуулиар гаргаж өгч байгаа. Өөрөөр хэлбэл орон нутагт алслагдсан байвал. Эсвэл цөөхөн суралцагчидтай байвал, эсвэл одоо тусгай хэрэгцээтэй хүүхдүүд байгаа бол, эсвэл дадлагын материал нь өөр хэмжээгээр хэрэгцээтэй байдаг бол хувьсах зардлыг өөрөөр тооцож болно гэдгийг л энэ хуулиар бид нар нээж өгч байгаа юм. Тийм тэгээд Чинзориг гишүүний санаа тавиад байгаа бас манай орон нутгаас сонгогдсон гишүүдийн санаа тавиад байгаа асуудал бол энэ зүйл заалтаар ишийдэгдэж байгаа шүү.

**Г.Мөнхцэцэг:** Баярлалаа. Энэ ер нь бол түвшин бүрээр нь тогтоох санхүүжилтийн журмыг Засгийн газар батална гээд түвшин бүрээр гээд ингээд онцгойлон тусгайлаад заагаад өгчихсөн учраас энэ одоо заалт бол ойлгомжтой гэж ингэж бодож байна. Ингээд санал хураалт.

Энэ санал 90.9 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Дараагийн санал дээр Чинбүрэн гишүүн зарчмын зөрүүтэй санал гаргаж байгаа байх.

Чинбүрэн гишүүний микрофоныг өгье.

**Ж.Чинбүрэн:** Баярлалаа. Та бүхний энэ өглөөний мэнд хүргэе. Би энэ зарчмын зөрүүтэй саналын томъёолол гаргаж энэ дээр санал хураалгах гэсэн юм. Энэ санал маань Их Хурал дээр чуулган дээр бол одоо уначихсан. Тийм учраас эрхэм гишүүдийг нэг анхааралтай сонсоод өгөөч гэж хүсэх гэсэн юм.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж 6 дугаар зүйл доор дурдсан агуулгатай 6.5, 6.6 дахь хэсэг нэмэх:

6.5.Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна гээд,

6.6.Боловсролын сургалтын байгууллагууд судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна гээд.

Тэгээд би энэ дээр бас нэг тодруулж хэлмээр санагдаж байна. Ер нь бид бас энэ 6 дугаар зүйл дээр судлах хэл гэдэг дээр бол бид шууд Англи хэл гэж тавих нь. Ер нь бол Монгол Улсын бас үндэсний аюулгүй байдал, геополитикийн энэ нөхцөл байдалтай холбоотойгоор бид бас заавал энд хуульдаа үндсэн органик хуульдаа хэл гэж зааж өгөхгүйгээр харин одоо Боловсролын сургалтын байгууллага өөрөө сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалдаа тулгуурлаад хэлээ сонгоод явна. Мэдээж бид бүгд ойлгож байгаа. Өнөөдөр дэлхий даяар глобалчилсан хэл бол одоо Англи хэл. Тэр битгий хэл би одоо бас Боловсролын сайд энд байж байна. Анагаахын сургуулийн сургалтын төгсөгчдийн одоо англи хэлний мэдлэг бол бүүр дээд хэмжээнд байх ёстой. Англи хэлээр одоо анагаахын боловсрол олгодогтой ч холбоотой. Гэхдээ бид бас нэг заавал одоо нэг Күнзийн сургаал байдаг шүү дээ. Нэг хийх гэж байгаа зүйлээ бүгдийг л зарлаад задлаад байх шаардлагагүй. Зарим

зүйлийг бас нэг хар хайрцгийн бодлоготой уялдуулаад явчих. Түүнийгээ бас одоо нэг зарлахгүйгээр энэ бас одоо геополитикийн нэг ийм бодлого байвал их чухал байна тэгээд тэр утгаараа 6.6 дахь зүйл дээр бас та бүгдийг онцгой анхаараасай гэж хүсэж байна.

**Г.Мөнхцэцэг:** Чинбүрэн гишүүний гаргаж байгаа энэ 6.7 дээр бид бол 3-ны 2-оор ингээд санал хураалт явуулах ёстой.

Тэгээд хурлын дэгийг бас уншаад танилцуулчихъя.

42.2.1 дээр бол ингэж заачихсан байж байгаа юм. Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг 42.2.3 дээр ингэж заасан байгаа юм Дэгийн тухай хууль дээр.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд одоо 3-ны 2-оор энэ санал хураах ийм одоо дэгтэй юм байна.

Тэгэхээр энэ тийм эхлээд 3-ны 2-оор санал хураана. Тийм учраас одоо Чинбүрэн гишүүний гаргасан энэ зүйл заалтууд дээр санал хураана. 3-ны 2-оор санал хураана.

Энэ саналтай холбогдуулаад ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн үг хэлнэ.

**Г.Дамдинням:** Боловсролын үндсэн одоо буюу одоо хамгийн түрүүнд судлах ёстой гадаад хэлтэй холбоотой асуудлаар маш их үйл явдлууд өрнөж байгаа. Тэгэхээр би бол Боловсролын ерөнхий хуулийг түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэхдээ ажлын хэсгийн зүгээс Монгол Улсын Засгийн газраас

өгсөн одоо үзэл баримтлалын хүрээнд бүх Монголын ирээдүй болох гэж байгаа хүүхдүүдэд тэгш боломжийг олгох чиглэлээр л бид нар ажиллаж байгаа.

Өнөөдөр Монголын одоо ард иргэдийн дунд Боловсролын зээлийн сантай холбоотой дуулиан ид мандаж байна. Боловсролын зээлийн сангийн зээлийг хэн авсан байна англи хэлтэй л хүүхдүүд авчихсан байгаа.

Англи хэлтэй хүүхдүүд нь хэний хүүхдүүд байна боломжтой англи хэл сурах боломжтой айлын хүүхдүүд л явж байгаа юм дийлэнх нь. Энэ хүүхдүүдийн ерөөсөө ч буруу байхгүй. Манай систем өөрөө ийм эвдэрхий байгаад байгаа юм. Тэгш боломжийг байхгүй болгочоод байгаа юм. Бид ардын хүүхдээс англи хэлийг харамлаж болохгүй байхгүй юу даа. Аль болох олон аавын хүүхдүүд Дарханы гудамжинд явж байгаа хүүхдүүд, Өвөрхангайн гудамжинд, БЗД-ийн гудамжинд алхаж яваа хүүхдүүд хөдөөгийн тосгонд байгаа хүүхдүүд, сумдад байгаа хүүхдүүд англи хэлээр ерөнхий боловсролоо 2 дугаар хэлээрээ авч явж байж олон улсад өрсөлдөх чадвартай иргэн болж төлөвшиж гарч ирэх юм.

Тийм учраас бид нар бол одоо Монгол Улсын Засгийн газраас өргөн баригдсан төсөл дээр байгаа Засгийн газрын төсөл шүү. Кабинетаараа хэлэлцээд оруулж ирсэн төсөл дээрээ байгаа. Англи хэлийг одоо үндсэн хэл байлгана гэсэн энэ зүйл заалтыг авч үлдэх хэрэгтэй байна.

Өөрөөр хэлбэл Байнгын хорооны эрхэм гишүүд та бүхэн энэ зарчмын зөрөөтэй саналыг дэмжихгүй байхыг хүсье. Тэгш боломж ард иргэд, тэгш боломж, тэгш хүртээмж, тэгш боловсрол, тэгш ирээдүйг хүсэж байгаа. Тэгш боломж, тэгш ирээдүй, тэгш сайн сайхныг бид нар төрөөс энэ боломжийг олгож өгч байж л өгнө. Боловсролын ялгарал хэрээс хэтэрсэн байна. Боловсролын ялгарлыг бид нар арилгахын

тулд энэ хуулийг хийсэн. Боломжтой хэсэг нь улам тасраад дэлхийн хэмжээнд хүрсэн байна. Боломжгүй хэсэг нь нөгөө ярьдаг уландаа үлдэж байна. Бид ард иргэдээ ингэж ялгах бодлогыг хийж болохгүй. Монгол Улсын Их Хурлаар анхдугаар хэлэлцүүлэгт Боловсролын ерөнхий хуулийн анхдугаар хэлэлцүүлэг ороод манай Улсын Их Хурлын эрхэм гишүүд дэмжээд баталчихсан заалт.

Их хурлын дэгийн тухай хуулиараа одоо бид нар энд Байнгын хороон дээрээ 3-ны 2-оороо энэ асуудлыг өөрчилье гэдэг санал өгөх л юм бол энэ асуудал яригдана. Хэрвээ энэ асуудал 3-ны 2-оор дэмжигдэхгүй бол эцсийн хэлэлцүүлэг дээр орно оо. Явж явж Боловсролын ерөнхий хуулиас энэ боловсролын одоо 33 жилийн түүхэн дэх ардчилсан улсынхаа энэ түүхэнд боловсролын реформ хийж байгаа сургуулийн өмнөх боловсролоос, ерөнхий боловсрол, дээд боловсрол, мэргэжлийн боловсрол, насан туршийн боловсрол гээд энэ бүх боловсролын тогтолцооны хүрээнд бид нар анх удаагаа авч үзэхдээ 10 жилийн дараа, 12 жилийн дараа сургууль төгсөх хүүхдүүдэд үлдээж байгаа хамгийн том өв нь дэлхийтэй нийлж дэлхийтэй хөл зэрэгцэн алхах энэ боломжийг олгох хэлний энэ өөрчлөлт байх болов уу л гэж би ажлын хэсгийн даргын хувьд харж байгаа.

Ардын хүүхэд сурч болдоггүй англи хэл гэж одоо байдаг юм болов уу л гэсэн асуултыг эрхэм гишүүддээ тавимаар байна.

Ард түмнийхээ талд байгаа бол та бүхэн энэ саналыг битгий дэмжээрэй гэж хүсье. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Түрүүн, бас ер нь Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42.2.3-д заасныг танилцуулсан 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд энэ энэ санал бас саналын томъёоллоор бид нар санал хураах ёстой. Тийм учраас бол

дэгд заасныхаа дагуу 3-ны 2-оор гэдэг дээр эхлээд санал хураалт тийм ээ.

Дараа нь энэ дэмжигдэх юм бол Чинбүрэн гишүүний одоо гаргасан саналын томъёолол дээр санал хураалт явуулна. Тэрэнтэй холбогдуулаад Чинбүрэн гишүүн бас одоо саналаа танилцуулж бас болно.

Тэгэхээр одоо 3-ны 2-оор дэмжье гэдгээрээ саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалт.

Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

Ингээд Чинбүрэн гишүүний гаргаж байгаа энэ 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт дахь өөрчлөлт оруулж байгаа энэ саналыг уншиж хураана тэ уншиж танилцуулна.

Би энэ саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Анхаарлаа хандуулаарай. Чинбүрэн гишүүний саналыг танилцуулъя.

Төслийн 6 дугаар зүйлийн 6.2.1, 6.2.2, 6.2.3 дахь заалт, 6.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.5, 6.6 дахь хэсэг нэмэх:

“6.5. Сонсголгүй суралцагчийн боловсрол эзэмших сургалт үйл ажиллагааны хэл нь Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан хэл байна.

6.6. Боловсролын сургалтын байгууллагад судлах гадаад хэл нь сургалтын үндэсний хөтөлбөрийн үзэл баримтлалд заасан хэл байна”

Чинбүрэн гишүүн саналаа тайлбарлая. Дээр нь Учрал гишүүн үг авч байна. Ундрал гишүүн Дамдинням гишүүн Энх-Амгалан гишүүнээр тасаллаа.

Чинбүрэн гишүүний микрофоныг өгье.

Чинбүрэн гишүүн саналаа тайлбарлая. Чинбүрэн гишүүний микрофоныг өгөөрэй. Техник дээр жоохон шинэ хүмүүс ажиллаж байгаа гээд байгаа юм байна. Чинбүрэн гишүүний микрофоныг өгье.

**Ж.Чинбүрэн:** Дамдинням гишүүний, ажлын хэсгийн ахлагчийн би бас үзэл санаа зорьж байгаа зүйлийг ойлгож байгаа. Энд бид англи хэлийг бусдад олгохгүй ялгаатай хандах гэж байгаа зүйл ерөөсөө байхгүй. Ерөөсөө байхгүй. Ер нь бол Монгол Улс гэдэг энэ тусгаар улсын бас нэг хар хайрцгийн бодлого гэж байх ёстой. Тэр утгаар бол бид энэ Монгол Улсынхаа тусгаар тогтнолоо хамгаалах бие даасан байдлыг хадгалах нь өөрөө Монгол Улсын том хар хайрцгийн бодлого. Тэгэхлээр бид ганц нэг хуулиараа одоо юу гэдэг юм одоо бусдад илүү нөхцөлийг бий болгож байна гэж хэлэн эх орныхоо одоо тусгаар тогтнолд ямар нэгэн гай тарих нь өөрөө онцгүй. Би бол одоо Боловсролын сайд өөрөө үгээ хэлэх байх гэж бодож байна. Энэ одоо төлбөртэй болон төлбөргүй сургуулиуд дунд англи хэлийг үзүүлэхийг та бол хорих гэж байгаа ямар нэгэн бодлого байхгүй гэж бодож байна. Эсрэгээр илүү их дэмжих байх. Яг одоо Дамдинням гишүүний хэлсэнчлэн бүх улсын санхүүжилттэй сургуулиуд англи хэлийг үздэг болох энэ асуудал бол үнэхээр одоо Их Хурлын гишүүдийн бүгдийнх нь дэмжиж байгаа асуудал. Гэхдээ бид энийг томъёолохдоо бас одоо зөв томъёолох нь чухал. Бид энэ үндэсний хөтөлбөр гэж оруулаад тэр дотор нь хэрэгжих хэлийг нь одоо дэмжиж сургана гэдэг заалт л оруулж болохоос түүнээс хүүхдүүдийг сургахгүй гэдэг асуудал байхгүй. Тийм учраас бид илүү их тийм ялангуяа төрд зүтгэж байгаа бид нар энэ төрийн тогтвортой дэлхийн одоо бодлоготой бас нэг зэрэгцэж их ухаалаг байх нь чухал

болов уу л гэж харж байгаа. Тэр өнцгөөс ярьж байгаа шүү.

**Г.Мөнхцэцэг:** Учрал гишүүн үг хэлье. Учрал гишүүний микрофоныг.

**Н.Учрал:** 2018 оны 6 дугаар сарын 27-нд энэ Багийн хөгжлийг дэмжих тухай хуулийг баталсан Их Хурал. Багийн хөгжлийг дэмжих тухай хуульд нэг маш сайн заалт орсон юм. Тэр нь юу вэ гэхээр энэ бага ангид одоо туслах багийн орон тоог бий болгоно гээд. Тэгэхгүйгээр өнөөдөр 50 хүүхэдтэй ангид багш туслах багшгүйгээр ажиллах гэхээр хүүхэд болгонд хүрэхгүй байна. Туслах багийн бий болгоё оо гээд заасан. Гэтэл өнөөдөр яг бага ангид туслах багш байна уу? Тэгэхээр бид нар бол заавал төсөвтэйгөө уялдаад л ингээд л асуудалд ийм байдлаар ханддаг буюу хуульд гоё үг бичдэг амьдралд хэрэгждэггүй л нөхцөл байдалтай байгаа шүү дээ.

Тийм учраас ямар ч реформ бол эдийн засаг төсөвтэйгөө хамт явж байж илүү их амилдаг. Тэр ч утгаараа өнөөдөр энэ англи хэлний боловсрол бол асар их чухал юм. Дамдинням гишүүн бид нар бол энэ Кембриджийн хөтөлбөрийг дэмжье гээд лобби бүлэг хүртэл байгуулсан. Ингээд улсын төсвөөс мөнгө төгрөг олох гээд дэмжүүлэх гээд янз бүрээр л одоо бичиг сачгаа явуулаад илгээгээд дийлээгүй. Тэгээд Батшугар бид 2 бол сая Сонгинохайрхан дээр энэ Кембриджийн хөтөлбөрийн сургууль байгуулаад өөрсдийнхөө зардал мөнгөөр шийдээд ингээд нээлтээ хийсэн.

Одоо энэ сургууль бол Кембриджийн албан ёсны боловсролын төвөөс сертификатаа аваад ажиллаж байна. Гэтэл одоо бид нарт ямар асуудал үүсэж байгаа вэ гэхээр яг Зүүн салааны тэр сургуульд IELTS-ийн өндөр оноотой тэр англи хэл заах чадамжтай багш 1 сая төгрөгийн цалингаар ирэх үү гэдэг асуудал дахиад л яригдаж байдаг. Гоё үг бичиж болно, болно, болохгүй юм байхгүй. Тэгэхдээ сумын сургуульд хэн очиж

багшлах вэ. Тэр зүүн салааны сургуульд хэн багшлах вэ гээд асуудал үүсдэг.

Тэгэхээр би ямар зарчмын зөрүүтэй ийм санал байна вэ гэхээр хэдүүлээ ер нь боловсролын хуульдаа жил бүр улсын төсөвт англи хэлний багш нарын одоо цалинг нэмэгдүүлнэ гээд бараг биччихмээр байх юм. Бараг шулуун. Англи хэлний багш нарын цалинг жил бүр 1 сарын 1-нд одоо 20 хувь нэмэгдүүлнэ. Эсвэл англи хэлний багш нарын цалин одоо тийм нэмэгдэлтэй байна ч гэдэг юм уу заачихвал хэдэн сайн англи хэлний багш нар энэ хөдөө орон нутаг руу манай энэ хотын захын дүүргүүд рүү явуулмаар байна. Үнэхээр энэ боловсролын тэгш боломж алдагдсан. Гэхдээ англи хэл 1 дүгээр хэл байна гэж бичлээ гээд Энх-Амгалан сайд одоо тэр өнөөдрийн улсын төсөвт тааруулаад тэр цалин хөлсийг нь ишийдээд явна гэдэг маш хэцүү байхгүй юу.

Тэгэхээр бид нар нэг тийм англи хэлийг буруу гэж хэлж байгаа нэг ч хүн энд алга. Англи хэлний боловсролыг тэгш явуулах ёстой бүгд Кембриджийн сургуульд сурах ёстой гэж бүгдээрээ үздэг. Одоо би бол энэ Кембриджийн лобби бүлгийг байгуулахдаа ч анх хэлж байсан. Ерөөсөө л энэ хөтөлбөрийг анх 3 сургууль дээр туршичихаад 2018 он гэхэд бүх сургуульд хэрэгжүүлнэ гэж хэлчхээд дундуур нь боловсролын салбарын улс төржилтөөс болоод аль тэр тухайн сайд нь хаана төгссөнөөс шалтгаалаад боловсролын салбарын бодлого өөрчлөгдөж байна.

Би Японд төгссөн бол Япон байх ёстой, би Англид төгссөн бол Англи байх ёстой. Дуртай болгоноо ярьж боловсролын салбарыг улс төржүүлсний хор гай бол энэ тогтвортой бодлого чинь алдагдсанаас болсон. Тэрнээс биш аль 2011 онд Батболд даргын Засгийн газрын үеийн тэр Англитай байгуулсан Кембриджийн хөтөлбөр чинь өнөөдөр хэрэгжчихсэн байсан бол сургууль болгон Кембриджтэй болоод түүнийгээ дагаад төсөв мөнгө нэмэгдээд нэг гараанаас

өрсөлдөх бололцоо нэмэгдэх л байсан шүү дээ. Гэтэл өнөөдөр буруу зөв гэж нэг ийм 2-ын хооронд юм ярьж сууж байхын оронд хэдүүлээ энэ англи хэлнийхээ багш нарын цалин хөлсийг нэмэгдүүлж, дунд сургуульд нэг хэдэн багш яаж олж ирэх вэ ганц сургуулийг ч гэсэн яаж Кембриж болгох вэ гээд дор дороо зүтгэцгээе л гэж би одоо уриалмаар байна.

**Г.Мөнхцэцэг:** Учрал гишүүн үг хэллээ. Ундрам гишүүн.

**Ч.Ундрам:** Би энэ хуулийг батлагдаад ингээд гараад олон жил хэрэгжинэ гэж харж байгаа. Олон жил хэрэгжих учраас бид нар маш урт хугацаанд одоо нөхцөл байдлаа харж, хийх ажлаа харж энэ хуульд тусгах ёстой гэж харж байгаа. Тийм учраас одоо Монгол хэл бол мэдээж манай үндэсний хэл энийгээ заана. Бүх одоо хичээлүүд Монгол хэл дээрээ явна. Гадаад үндсэн хэлээ англи хэл болгоё гээд энэ хууль дээр оруулчих юм бол сая нөгөө Учрал гишүүний хэлдэг шиг нэг сайд ирэхээрээ л хамаг юмыг өөрчилчихдөг гэдэг зүйл байхгүй болох ю.

Өнөөдөр энэ англи хэлийг бол Энх-Амгалан сайд дэмжээд энийг одоо энэ хуульд тусгасан тусгаагүй хэрэгжүүлээд явах нь тодорхой. Маргааш энэ дээр чинь шал өөр одоо өөр улс оронд төгссөн сайд хүрч ирээд үгүй бид нар заавал Орос хэлийг, заавал Хятад хэлийг заана гээд энэ хуульд тусгахгүй бол тэр боломж нь ингээд нээлттэй болчихож байгаа байхгүй юу. Тэгээд л нэг сайд хаана төгссөн ямар үзэл бодолтойгоосоо хамаараад л ингээд л хүүхдүүдийн амьдралаар тоглоод. Өнгөрсөн хугацаанд одоо энэ хувийн сургуулиудын хамгийн их том олгож байгаа давуу тал нь юу юм бэ гэхээр ерөөсөө хэлний боловсрол байна гэдэг судалгаа гарчихсан байгаа шүү дээ.

Тэгэхээр бид нар хүүхдүүдээ өнөөдөр дэлхийн мэдлэгээс юм олж авч мэддэг болгоё оо гэх юм бол Англи хэлийг заавал оруулах шаардлагатай. Тэгээд энэ

тогтворгүй одоо улс төрийн нөхцөл байдлаас болж энэ хүүхдүүдийн боловсролд ямар нэгэн одоо өөрчлөлт гаргахгүйн төлөө бид нар энэ хууль дээр заавал оруулж өгөх ёстой гэж харж байгаа юм. Яагаад манай хүүхдүүдэд гадаад ямар хэл заах вэ гэдгийг бусад улс орон мэдэх ёстой юм. Яагаад тэр нь бусад улс орон боловсролдоо юу орох ёстой гэдэгт нь нөлөөлөх ёстой юм. Тэгж болохгүй шүү дээ.

Одоо жишээлбэл манай хөрийн БНХАУ Англи хэлийг үндсэн гадаад хэл болгочихсон одоо заагаад явж байгаа шүү дээ. Яагаад бид нар тэгж болохгүй юм. Энэтхэг одоо таньдаг хүмүүсээсээ та нар 1 дүгээр ангиасаа англи хэл үзсэн үндэсний хэлээ энэнээс болоод мартсан уу гээд асуусан чинь ерөөсөө тийм юм байхгүй бид нар төрөөд л гэртээ үндэсний хэлээрээ яриад л ирсэн. Тэгээд 1 дүгээр ангиасаа мэдээж бүх хичээлээ үндэсний хэлээрээ үзээд хажуугаар нь англи хэлийг нэгээсээ үзсэн. Ерөөсөө бид нарт шууд ингээд л англи хүн шиг болоод явчихсан юм байхгүй. Хэдийгээр колони одоо олон жил явсан ч гэсэн гээд л ярьж байна лээ.

Сингапур улс өнөөдөр англи хэлийг үндсэн гадаад хэл болгосон маш өндөр хөгжилтэй явж байна шүү дээ. Яагаад бидний хүүхдүүд англи хэлтэй болоод хөгжөөд дэлхийн хэмжээний боловсон хүчин болоод дэлхийд өрсөлдөх компаниуд байгуулаад явж болохгүй. Яагаад тэрэнд гадаад улс болохгүй гээд манай бодлогод оролцох ёстой юм бэ? Тэгээд бид нар тэрнээс нь айгаад энд сууж байх ёстой юм уу? Айгаад байна шүү дээ эндээ оруулчихъя л даа. Тэгэхгүй бол дараагийн Энх-Амгалан биш өөр нэг Дорж гэдэг өөр улсад сурсан сайд ирээд үгүй англи хэл биш гээд суух гэж байна шүү дээ.

Би энд өөрийнхөө өөрийнхөө одоо үг хэлэх эрхээ эдлээд үгээ хэлж байна л даа. Өөрийнхөө цагт. Та нар над руу дайраад байх шаардлагагүй. Тэгэхээр хуульд орохгүй бол сайдаас хамаардаг ийм

зүйлийг л бид нар өнөөдөр хийх гэж байна шүү гишүүдээ.

**Г.Мөнхицэг:** Ундрам гишүүн үг хэллээ. Энх-Амгалан сайд үг хэлье.

**Л.Энх-Амгалан:** Гишүүдээ энэ танхимд хэлж байгаа үг бүхэн үнэ цэнтэй, үг бүхэн бас тодорхой үр дагавар дагуулдаг гэдгийг бид нар их ойлгох хэрэгтэй.

Тэгэхээр өнөөдөр одоо ингээд нэг англи хэлийг нэг хэсэг хүмүүст зориулаад эс үгүй бол өнөөдөр хуулиараа англи хэлийг ингээд хориглоцхож байгаа юм шиг ардын хүүхдэд англи хэл сурах боломжийг хаачхаж байгаа юм шиг нэг ийм одоо хариуцлагагүйг амнаасаа унагаж болохгүй. Тэр тусмаа Улсын Их Хурлын гишүүд.

Англи хэл бол Монгол Улсын үндсэн анхдагч хэл байна. Энэнээс нэг ч алхам бид нар ухарч болохгүй. Тэгэхээр үндсэндээ бол одоо бид нарын өнөөдөр энэ Боловсролын ерөнхий хуулийг баталж байгаа Боловсролын одоо дагасан ерөнхий хуулийг дагаж байгаа энэ хуулиуд дээр цаашидаа ерөөсөө Монгол Улсын энэ боловсролын хөтөлбөрийн бодлого тогтвортой байх энэ эрх зүйн баталгааг л бид нар хийж өгч байгаа байхгүй юу.

Өнгөрсөн хугацааны бид нарын алдаа юу байсан гэхээр Засгийн газар бүхэн солигддог. Боловсролын сайдаар ирсэн бүхэн хөтөлбөрийн шинэчлэл зарладаг л ийм л алдаа байсан шүү дээ. Өнөөдрийн бид нарын одоо яг баталж байгаа эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа энэ хууль бол цаашидаа нэг боловсролын хөтөлбөрөөс нөгөө боловсролын хөтөлбөрт шилжихэд тодорхой боловсролын хөтөлбөрийн менежментийн циклтэй болдог. Энэ нь хамгийн багадаа 10-аас 12 жил энэ циклтэй байдаг. Энэ баталгаа, эрх зүйн баталгааг бид нар энүүгээр хийж өгч байгаа юм.

Хоёрдугаар асуудал бол аль хичээлийг хэдэн цагаар одоо аль ангиас одоо хичээллэх вэ, заах вэ гэдэг асуудал бол энэ цэвэр одоо сургалтын хөтөлбөрийн асуудал.

Тийм учраас бид нарын энэ хөтөлбөрийн шинэ хуулийн дагуу хийх гэж байгаа хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд бол энэ үзэл баримтлал дээр хамгийн одоо гол гадаад хэл бол англи хэл байна.

Өнөөдрийн та бүхэн өчигдрийн одоо өнгөрсөн 7 хоногт болсон элсэлтийн шалгалтыг бас та бүхэн харсан байхад үр дүнг нь маш эерэг үр дүн гарсан. Ямар үр дүн эерэг үр дүн гарсан гэхээр төрийн өмчийн сургууль төгсөж байгаа 2 мянга гаруй хүүхэд өнөөдөр олон улсын одоо TOFEL, IELTS-ийн шалгалт буюу одоо олон улсын шалгалтуудад 2 мянга гаруй хүүхэд энэ шалгалтыг өгч тэнцээд өнөөдөр ЭЕШ-аа шалгалтаа дүйцүүлж байна. Энэ бол маш том дэвшил.

Нөгөө талаасаа бол бид нар энэ англи хэлний одоо өнөөдрийн зааж байгаа энэ багш нарын ур чадварын асуудлууд энэ арга зүйн асуудлууд энэ шинэ технологийн асуудлуудыг бид нар одоо өөрчлөхгүйгээр шинэчлэхгүйгээр бид нар энэ хот, хөдөөгийн сургуулийн ялгаа, төрийн сургууль, хувийн сургуулийн ялгааг бид нар арилгана гэж байхгүй.

Өнөөдөр ер нь төрийн сургууль, хувийн сургууль, хот хөдөөгийн сургуулийн хамгийн том ялгаа энэ хэлэн дээр л гараад байна шүү дээ. Тэр тусмаа энэ англи хэлэн дээр.

Тийм учраас өнөөдөр хүүхэд хаана сурч байна хаана одоо амьдарч байгаагаасаа үл шалтгаалж хүүхэд бүр бид нар энэ англи хэл дээр сурах энэ боломжуудыг олгох ёстой. Тэр тусмаа аль болох эрт наснаас нь энэ бодлогоосоо Монгол Улсын Засгийн газар хэзээ ч хойшоо алхаагүй, нэг ч алхам хойшоо алхаагүй. Оюун-Эрдэнэ Ерөнхий сайд Ерөнхий сайд болохдоо Улсын Их Хурлын

чуулган дээр хэлсэн үг дотор англи хэл Монгол Улсын одоо 2 дахь хэл байна гэдгийг албан ёсоор зарласан.

Энэ бол манай Засгийн газрын одоо манай Улсын Их Хурлын ийм бодлого гэж ойлгож байгаа. Энэ бодлогоос бид нар нэг ч алхам ухарч болохгүй.

Тийм учраас өнөөдөр бид нарын энэ одоо өнгөрсөн хугацаанд 6 сарын туршид бид нар энэ английн персон гэж дэлхийд одоо туршигдсан хамгийн том платформыг бид нар туршилаа. Маш том үр дүнд хүрч байна шүү дээ. Хөдөөгийн хүүхдүүд тиймээ сумын хүүхдүүд, аймгийн төвийн хүүхдүүд, хотын хүүхдүүдээс одоо хоцрохгүйгээр суралцаж болдог юм байна гэдгийг энүүгээр бид нар одоо яаж байгаа юм? Туршигдаж одоо цаашидаа бол бид нар ер нь Англи хэлийг бол 3 дугаар ангиас нь л эхэлж заах л гэдэг дээр энэ дээр хүн бүхэн ойлголттой байгаа шүү дээ. Тэрнээс биш одоо өнөөдөр энэ танхимд яг энэ хуулийн нэг нэр томъёог засах тийм нэг заалтыг нөгөө заалтаар нь солихоос болж хүүхдийн англи хэл сурах асуудлыг боломжийг хулгайлж байгаа юм шиг нэг ийм байдлаар одоо бид нар нийгэмд хариуцлагагүй үг үйлдэл хийж болохгүй гэж би ойлгож байгаа.

Тийм учраас бол одоо энэ хуулиар хийгдэж байгаа энэ өөрчлөлтүүдээ дэмжээд яана. Энэ Боловсролын багц хуулиар чинь ганцхан англи хэлний асуудал хөндөгдөөгүй шүү дээ. Боловсролын салбарын бүхэл бүтэн системийн шинэчлэлтийн асуудал хөндөгдөж байгаа байхгүй юу.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайд үг хэллээ.

Саналаа хураачихъя. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Монголын ард түмний саналыг та бүгдийн төлөө зүтгэнэ гээд авчихсан эрхэм Улсын Их



Хурлын гишүүд бид нар энд суугаад ирээдүйг нь хэрхэн бэлдэж ямар хүн болгож гаргах талаар яриад сууж байгаа. Тэд биднээс тэгш боломж л хүсэж байгаа. Тэгш боломж. Тэр тэгш боломж боловсролоор очих ёстой. Хаа газар байгаа Монгол орны 4 зүг 8 зовхист амьдарч байгаа Монголын хүүхдүүд дэлхийтэй хөл нийлүүлж алхах хэрэгтэй. Энэ тэгш боломжийг Монгол Улсын Засгийн газар маш сайн харсан. Монгол Улсын Ерөнхий сайд Оюун-Эрдэнэ Засгийн газрын тэргүүн болж гарч ирээд хамгийн түрүүнд хэлсэн илтгэлийг эрхэм гишүүд санаасай гэж хүсэж байна. Албан ёсны гадаад хэлийг 2 дахь хэлийг англи хэл болгоно гэдэг үгийг илтгэлдээ дурдсан.

Тийм ч учраас Боловсролын ерөнхий хууль болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Монгол Улсын Засгийн газраас Их Хуралд өргөн барихдаа англи хэл хоёрдогч үндсэн одоо боловсролын хэл байна гэдэг томъёоллоор оруулж ирсэн гэж бодож байгаа. Засгийн газраас орж ирсэн энэ төслийг би дахин дахин хэлж байна шүү. Төслийг бид нар анхдугаар хэлэлцүүлгээр дэмжээд гаргачихсан байсан юмыг Байнгын хороон дээр нэг их олон тохиолдоод байдаггүй юм 3-ны 2-ын саналаар унагаж байгаад өөрөөр дахин томъёолж байгаа гэдгийг л одоо бодолцоорой. Бидэнд олон асуудал бий.

Гэхдээ Монголын хүүхдүүд, Монгол орны ирээдүйгээс илүү том асуудал гэж бол байхгүй шүү. Тэгээд одоо Улсын Их Хурлын чуулган дээр байр сууриа дахиад илэрхийлнэ. Тэгээд эрхэм гишүүд дахиж бодоосой гэж та бүгдээс хүсье. Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Санал хураалтдаа оръё.

Тэгэхээр энэ үзэх гадаад хэлийг бол солих гээд байгаа зүйл бол огт биш. Энэ бол ийм санал биш. Ер нь бол шууд ингээд санал хоорондоо зөрөлдөөд хэлэн дээр зөрөлдөөд байгаа зүйл огт биш. Саналын

томъёололд өөрчлөлт ороод ирж байгаа гэдгийг гишүүд бас ойлгож байгаа байх гэж ингэж бодож байна. Агуулгын өөрчлөлт бол огт байхгүй.

Ингээд санал хураалтдаа оръё. 3-ны 2-оор түрүүлж санал хураалт явуулъя гэдэг дээр санал дэмжигдсэн. Ингээд Чинбүрэн гишүүний гаргасан 6 дугаар зүйл дээр энэ уншиж танилцуулсан. Тэгээд энэ танилцуулсан учраас санал хураалт.

Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт 2 санал байгаа юм. Ажлын хэсгээс оруулсан 2 санал байгаа. Танилцуулъя.

1.Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“43.4.1.өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох хувьсах зардал;” Санал гаргасан ажлын хэсэг.

Энэ санал хураалтыг цуцалъя. Чинзориг гишүүн үг хэлье.

**С.Чинзориг:** Энэ 43.1.4, 43.11 хоёр дээр бас нэг санал хэлмээр байгаа юм. Асуух юмнууд байгаа юм. Бид чинь одоо Үндсэн хуулиараа ерөнхий боловсролыг үнэ төлбөргүй олгоно гэсэн хууль Үндсэн хуулийн заалттай. Төрөөс тавьж буй нөхцөл шаардлагыг хангаж байгаа бол хувийн хэвшил ерөнхий боловсролыг бас одоо олгож болно гэсэн заалттай.

Тэгэхээр одоо бид нар энэ боловсролын ялгаатай холбоотой асуудал сая манай гишүүд маш их ярилаа шүү дээ. Энэ дээр чинь л энэ боловсролын ялгаа гарах гол одоо үндэслэл чинь би бол яваад байна гэж л ойлгоод байгаа юм л даа.

Ялангуяа энэ хувийн сургуулиуд ерөнхий боловсролын үйл ажиллагаа явуулж байгаа сургуулиудын төлбөртэй холбоотой асуудлыг энэ Үндсэн хуулийн заалттай одоо нийцүүлэх, ялангуяа тэр төрөөс тавьж буй нөхцөл шаардлагыг биелүүлж байгаа бол хувийн хэвшил гүйцэтгүүлж болно гэдгийг одоо бид юу гэж ойлгодог юм? Тэр ерөнхий боловсролын сургууль боловсролын үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвчлүүдийн байгууллагад тавьж байгаа тэр нөхцөл болзол гэдэг нь одоо төрөөс тавьж байгаа тэр нөхцөл шаардлага гэдэг нь одоо юу байгаа юм гэдгийг бид нар нэлээн сайн ярих хэрэгтэй байх.

Одоо бид нар сая баахан л энэ боловсролын ялгаатай холбоотой асуудал ярилаа. Энэ боломжтой айлын хүүхдүүд нь тэр хөрөнгө мөнгөтэй айлын хүүхдүүд нь дандаа энэ өндөр төлбөртэй хувийн сургуулиудад сураад тэгээд энэ элсэлтийн шалгалтын оноо нь өндөр байдаг. Ялангуяа тэр нөгөө гадаад хэлний түвшин нь өөр түвшинтэй болоод энэнээс чинь болоод л энэ боловсролын ялгаа асар их гараад байна шүү дээ. Энэ чинь бол явж явж одоо тэр хөдөө 10 жил хөдөөгийн говийн сургуульд 12 дугаар анги төгсөж байгаа хүүхэд яаж энэ хувийн өндөр төлбөртэй сургууль төгссөн хүүхэдтэй англи хэлээр ижил түвшинд өрсөлдөж тэр одоо Боловсролын зээлийн сангаас чинь одоо бас дэмжлэг авах ийм боломж нь бүрдэхгүй байна. Энэ бол иргэдийн хүүхдүүдийн боловсролын түвшинд асар их одоо ялгаа гаргаж байгаа юм энэ байгаа юм.

Тийм учраас бол энэ хувийн сургуулиудын ерөнхий боловсролын сургуулиудын үйл ажиллагаа эрхэлж байгаа энэ хувийн сургуулиудын төлбөртэй холбоотой асуудлыг одоо бид нар нэг ярих, хязгаарлах, зохицуулалт хийх зайлшгүй шаардлагатай гэж бол үзэж байгаа юм.

Яах вэ энэ 43.4.1, 43.11 эд нараар бол гэрээний шалгуурыг нь сайд батлах

юм байна. Гэрээний гүйцэтгэлд үндэслэж хувьсах зардал олох олохгүйгээ шийдэх зохицуулалт орж ирж л байгаа юм байна л даа. Гэхдээ энэ дээр одоо бид нар ер нь бол улсын дунджаар хувийн ерөнхий боловсролын сургуулийн төлбөр тодорхой хэмжээгээр энэ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ байдаг юм уу? Амьжиргааны түвшинтэй уялдуулсныг хязгаар зохицуулалт л одоо хийхгүй бол энэ асар их боловсролын ялгаа энэ юм чинь ерөөсөө цаашидаа улам л газар авна шүү дээ.

Одоо хувийн сургуулиудын төлбөр чинь одоо ямар хэмжээтэй байгаа юм? Дээд тал нь бараг л одоо жилийн 10 мянга, 20 мянган долларын, 30 мянган долларын төлбөртэй ийм сургуулиуд байгаад байна шүү дээ. Тэгээд энийг бид нар зөвхөн хувьсах зардлаар нь хязгаарлаад зохицуулна гээд нэгж явж болохгүй. Энийг одоо бид нар нэлээн сайн одоо ярих ёстой. Энэнээс чинь болоод энэ боловсролын ялгаа чинь бол асар улам л одоо гүнзгийрээд байна, холдоод байна шүү дээ.

Энийг одоо бид нэлээн сайн ярих ёстой болов уу гэж л бодож байна. Тийм учраас бол энэ 43.4.1, 43.11 эд нар дээр бас гишүүд нэлээн сайн санал бодлоо ярилцаасай гэж. Энийг нэлээн нэг гарц гаргалгаа олохгүй бол бид нар ингээд нэг зөвхөн хувьсах зардлаар зохицуулна гэх юм бол энэ нэг тийм боловсролын одоо ялгааг бас жаахан багасгах асуудал бол шийдэгдэхгүй л гэж бол бодож байна. Энэ дээр одоо ажлын хэсэг юу гэж одоо үзэж байгаа юм?

**Г.Мөнхцэцэг:** Энэ ажлын хэсгийн гаргасан санал байгаа учраас ажлын хэсгийн ахлагч Дамдинням гишүүн Чинзориг гишүүний асуултад. Энх-Амгалан сайд хариулах юм уу? Энх-Амгалан сайдын микрофоныг өгье.

**Л.Энх-Амгалан:** Бид энэ сургалтын чанар энэ асуудал дээр, сургалтын шинэчлэлийн асуудал дээр,

сургалтын шинэ технологийн асуудал дээр одоо тэргүүлж байгаа, манлайлж байгаа хувийн хэвшлийнхээ сургуулиудыг ад үзэж болохгүй л дээ. Одоо энэ чинь хувийн хэвшлийн сургуулиуд бол нийт хувийн хэвшлийн сургуульд чинь бараг нийт 50-иад мянган хүүхэд сурч байгаа. Боловсролын салбарын тэр тусмаа энэ боловсролын шилжилтийн үеийн хамгийн хүнд ачааг бас төртэй хамт одоо үүрэлцсэн хувийн сургуулиуд бас байгаа. Энийг бид нар хүлээн зөвшөөрөх ёстой. Ер нь яагаад хувийн сургууль руу хүмүүс тэмүүлээд байна гэдгийг бид нар бодох ёстой. Яагаад тэмүүлээд байгаа юм. Яагаад тэр хэлсэн үнийг нь төлж хүүхдүүдээ сургаад байгаа юм. Тэгээд энэ боловсролын чанар байна шүү дээ. Боловсролын стандарт байна.

Тийм учраас бид нар энэ төрийн сургууль одоо энэ 800 сургуулиа харин одоо яаж энэ хувийн сургуулиудтай яаж ойролцоо энэ боловсролын чанарыг энэ хүүхдүүдийн тэгш хүртээмжийн асуудлуудыг яаж ойролцоо болгох вэ л гэдэг асуудал бид нарын толгойны өвчин байхгүй юу. Тэрнээс одоо олон улсын хөтөлбөр оруулаад ирчихсэн энэ сургуулиудын одоо тэр төлбөрүүдийг нь тэдэд бариулна гээд ингээд хуучин социалист маягаар тэгвэл бид нар ер нь ямар нийгэм рүү яваад байгаа юм бэ? Эс үгүй бол нийгмийнхээ сонголтыг цөмөөрөө эргэж харъя. Одоо бид нарын өнөөдөр энэ Боловсролын энэ багц хуулиар шинэчлэгдэх гээд байгаа гол зүйл чинь ерөөсөө л хувийн сургууль, төрийн сургуулиудын ялгааг арилгая, хотын сургууль, одоо хөдөөгийн сургуулиудын ялгааг арилгая. Ялгааг яаж арилгах гээд байгаа юм гэдэг асуудлуудыг л бид нар тогтолцооны шинэчлэл хийх гэж байна шүү дээ. Санхүүжилтээр нь өнөөдрийн бид нар өнөөдөр одоо санхүүжүүлж ирсэн нэг хүүхдийг сургаж байгаа энэ хувьсах зардал чинь хүүхдийн сурлагын чанартай, багшийн ажлын хөдөлмөрийн үнэлэмжтэй хүүхдийн суралцаж байгаа сургалтын орчинтой ямар ч тийм холбоогүй ийм санхүүжилтүүдийг

байгууллага санхүүжүүлсэн санхүүжилтийн тогтолцоог бид нар хийж ирсэн байна.

Тийм учраас өнөөдөр бид нар хүүхэд хаана амьдарч байна, хаана суралцаж байгаагаасаа үл шалтгаалж тэр боловсролын тэгш хүртээмжийг өгөх энэ санхүүжилтийн буюу нэг хүүхдийг хувьсах зардлуудынхаа аргачлалуудыг өөрчилж боловсролын чанар дээр одоо шинэ өөрчлөлтүүд гаргая гэдэг ийм зарчмыг л бид нар барьж байгаа шүү дээ. Гол асуудлууд. Тэр засаглалуудын шинэчлэлтүүдийг нь өөрчлөлтүүдийг хийе. Энэ үнэлгээнийхээ тогтолцоог бид нар өөрчилье. Багш бэлтгэх тогтолцоогоо энэ багшийн одоо хичээл зааж байгаа энэ багш нарын ур чадварынхаа асуудлуудыг бид нар шинэчилье. Багшаа дэмжье. Багшийн сургуулиар төгсөөд очиж байгаа багш нарын боловсролын чанарын асуудал ажлын байран дээрээ тасралтгүй хөгжих энэ багш нарын хөгжлийн асуудлуудыг дэмжих энэ тогтолцоог бид нар хийж өгье.

Цахим шилжилтээр дамжиж өнөөдөр энэ дэлхий дээр явагдаж байгаа боловсролын шинэчлэлт, боловсролын технологийг хүүхэд бүрд тэгш одоо боломж олгоё гэдэг ийм л салбарын тав, зургаахан том шинэчлэлийн хүрээнд бид нар энэ шинэчлэлийг хийж түрүүний Учрал гишүүний ярьж байгаагаар одоо энэнийхээ дагуу яг нөгөө нэг хүүхэд сургаж байгаа хувьсах зардал дээр нь шаардлагатай байгаа тэр санхүүжилтийнх нь эх үүсвэрүүдийг жил бүхэн одоо боловсролын салбараасаа 1 төгрөг ч одоо татахгүй шиг, харамлахгүй шиг тавиад өгөх юм бол бид нар ойрын хугацаанд одоо Монголын боловсролын салбар дахиад сэргэх ийм том боломжууд өнөөдөр бид нарт байгаа шүү дээ.

Тэгэхээр энийгээ одоо бид нар энэ сонгож авч байгаа энэ өдөр ардчилсан энэ нийгэмд, энэ зах зээлийн нийгэмд хүн бүрийн сонголтыг хүндэлж байгаа энэ

нийгэмд амьдарч байж бид нар тэр нийгмийнхээ үзэл баримтлал дээр бид нар явж байж энэ хуулиуд чинь одоо батлагдаж гарч эндээс бид нар тодорхой үр дүн гарна гэж бодож байгаа шүү дээ.

Тэрнээс одоо төрийнхөн, хувийнхан гээд ингээд нүд үзүүрлээд байдаг ийм бодлого би бол байж болохгүй гэж бодож байна. Одоо Чинзориг сайд бол одоо хувийн эмнэлгийн тарифуудыг ингээд улсын эмнэлгийн тарифуудтай адилхан болгох юм байна л даа. Өнөөдөр тэр хувийн эмнэлэг дээр байгаа тэр сайн чанартай үйлчилгээ тэр хүртээмж дээр улсын эмнэлгүүд тэрэн дээр хүрч ажиллах тэр чармайлт, тэр эрмэлзэл бид нарт байхгүй юм уу? Тэр манлайлал бид нарт байхгүй юм уу?

Тэгэхээр энэ асуудлуудыг хөндөж байгаа л ийм л зохицуулалтуудыг нь.

**Г.Мөнхцэцэг:** Чинзориг гишүүн тодруулъя.

**С.Чинзориг:** Гишүүдийн асуултад бас жаахан хүндэтгэлтэй хандаж байх хэрэгтэй шүү дээ. Би бол хуучин нийгэм рүү буцаж оръё эд нар гэж тийм яриагүй шүү дээ. Хувийн хэвшлийг дэмжихгүй гэж яриагүй, хэлээгүй шүү дээ. Үндсэн хуулиар энэ ерөнхий боловсрол чинь үнэ төлбөргүй байна. Хэрвээ хувийн хэвшил гүйцэтгэхгүй бол төрөөс тавьсан тэр нөхцөл шаардлагыг хангаж байгаа бол хувийн хэвшил гүйцэтгэж болно гэсэн Үндсэн хуультай. Энэнтэйгээ л одоо энийгээ уялдуулаач ээ. Олон жил одоо ингээд хувийн хэвшлийг дэмжиж байна гээд ингээд попроод, ингээд одоо энэ иргэдийн хүүхдүүдийн дунд боловсролын асар их ялгаа гаргаад байж болохгүй шүү дээ. Тэр өндөр төлбөртэй хувийн сургуулиудад чинь хөдөөгийн малчин айлын хүүхэд ирээд суух боломжгүй шүү дээ. Энэ одоо орлогын ялгаа асар их бий болчихсон. Хүн амын чинь цөөхөн хэсэг дээр нь энэ орлого төвлөрчихсөн ийм л хэсэг нь тэр хувийн өндөр төлбөртэй өндөр боловсрол эзэмшээд л явж байгаа шүү дээ.

Тэгээд тэр төрөөс тавих тэр нөхцөл шаардлага гэдгээ тодорхой болгогчооч гэж би хэлээд.

**Г.Мөнхцэцэг:** Санал хураалт явуулж байгаа.

Саналын томъёоллоо уншиж танилцуулсан. Ажлын хэсгийн гаргасан саналыг та бүхэнд танилцуулсан.

Асуулт асууж, хариулт авлаа.

Төслийн 43 дугаар зүйлийн 43.4.1 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“43.4.1.өмчийн хэлбэр үл харгалзан цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсролын сургууль, политехник коллежийн нэг суралцагчид холбогдох хууль тогтоомжид заасны дагуу олгох хувьсах зардал;” ажлын хэсэг санал гаргасан.

Санал хураалт явуулъя.

Гуравны хоёроор дэмжигдэх ёстой байгаа.

Энэ санал 72.7 хувиар дэмжигдлээ.

Дараагийн санал хураалт.

Төсөл доор дурдсан.

3-ны 2-оор санал хураалт явуулсан. Одоо энэ саналыг дэмжье гэдгээр ерөдийн олонхоор санал хураалт явуулах дэгтэй байна. Ингээд санал хураалт энэ санал 81.8 хувиар дэмжигдлээ. Ажлын хэргийн хэсгийн гаргасан санал.

Дараагийн саналыг танилцуулъя.

Төсөлд доор дурдсан агуулгатай 43.11 дэх хэсэг нэмэх.

“43.11.Энэ хуулийн 43.4.1-т заасан зардлыг үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж

буй төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуульд олгохдоо гэрээний гүйцэтгэлд үндэслэн олгох бөгөөд гэрээний үр дүнгийн шалгуурыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.” ;” Санал гаргасан ажлын хэсэг.

Доржханд гишүүний нэрийг оруулъя. Доржханд гишүүнээр тасаллаа.

**Т.Доржханд:** Баярлалаа. Би нэг 2 зүйл дээр тодруулга авмаар байна. Бүүр тов тодорхой. Ялангуяа Засгийн газраас, Боловсролын сайдаас. Тэгээд энэ Байнгын хорооны бас удирдлагууд хариулах юм бол их сайн байна.

Нэгдүгээрт юу байна гээд тэгэхээр энэ саяын ярьдаг Монгол Улс яаж хөгжих гээд байгаа юм бэ гээд. 1990 онд ардчилсан хувьсгал хийгдсэн. Анхны жишээ нь Үндсэн хууль хийсэн. Үндсэн хууль дээрээ Монгол Улс ардчилсан улс байна.

Хоёрдугаарт зах зээлийн эдийн засгийг баримжаалж явна гэдэг ийм одоо чиглэлээр бид нар 32 жил явлаа агуулга нь юу юм бэ гээд тэгэхлээр төр төвлөрүүлдэг төр шийддэг биш хувийн сектор, бизнес эрхлэгчдээ дэмждэг, зах зээл дээр тулгуурласан ийм эдийн засгийг бүтцийг бий болгоё гээд явсан. Яг энд чинь хамгийн их үр дүнгээ өгдөг салбар бол боловсролын салбар. Бүгд мэдэж байгаа. Боловсрол нэг доллар хийх юм бол нэг төгрөг хийх юм бол 100 доллар болдог юм. 100 дахин өсдөг юм гээд өгөөж нь. Тэгэхлээр энд хэн хөрөнгө оруулалт хийх вэ гэдэг асуудал гарч ирж байгаа байхгүй юу. Төр хийгээд байх юм уу, хувийн сектор хийх юм уу эсвэл хамтдаа хийх юм уу гээд.

Гэтэл хөгжсөн орнуудын туршилага бол тэр нь хөгжсөн орнуудын туршилага нь болохлоор Африк байна уу, Ази нь байна уу, Америк нь байна уу, Европ нь байна уу бүгдээрээ ийшээгээ хөрөнгө оруулалт хийж байгаад үр дүнд нь нийтээрээ хөгжсөөд байгаа юм. Гэтэл

Монгол Улсад болохлоор сүүлийн үеийн чиг хандлага нь юу байна гээд тэгэхлээр боловсролын хүртээмжийг сайжруулахын тулд ерөөсөө үнэ төлбөргүй болчихъё ингэхийн тулд бас хувийн сектор байх шаардлага байхгүй гээд нэг ийм хандлага яваад байна. Тэгээд энэ дээр Засгийн газрын яг асуудал хариуцсан сайдаас нь бас тодорхой байр чиглэл суурийг нь авчихмаар байгаа юм. Цаашаа яг яаж явах гээд байгаа юм бэ?

Өнөөдөр төр бүгдийг нь ингээд шийдээд яах хөрөнгө байгаа юм уу? Би бол Сангийн яаманд ажиллаж байсан. Төсөв байхгүй шүү дээ, байхгүй. Хувийн сектор чинь ачаа үүрээд байгаа юм уу үүрэхгүй байгаа юм уу? Цаашаагаа хувийн сектор орж ирэх юм уу гаднын хөрөнгө оруулалтууд энэ хувийн сектор чинь орж ирж ажиллах юм уу? Яг энэ дээр нэг тодорхой байр сууриа өгөөд хариулт авчихмаар байна.

Хоёр дахь нь болохлоор Монгол Улс цаашаагаа дэлхийн 200 улсад эрэмбээрээ 136-д яваад байна, хөгжлөөрөө. Улам хойшоо шийддэгдээд байна. Гэтэл Монголчуудын давуу тал чинь 3.4 сая хүнтэй. Монголчууд маш богино хугацаанд бид нар хөгжих боломжтой. Хөгжлийн онол чинь өөрөө хүнээрээ дамжуулаад явж байгаа байхгүй юу. Газар капитал байна. Нөгөө талд нь хүн хүний чинь бий болгодог бүтээмжийг нь өсгөдөг юм чинь бол боловсрол байгаа. Тэрэнд чинь хамгийн их дэлхийн түүхэнд хувь нэмэр оруулсан юм чинь бол англи хэл шүү дээ. Англи хэл яагаад Энэтхэгүүд өнөөдөр хөгжсөөд байна. Яагаад Хонконг хөгжсөөд байна, яагаад Сингапур хөгжсөөд байна. Англи хэлтэй байсан улсууд яагаад хөгжсөөд байна. Дэлхий яагаад ганц англи хэл рүү яваад байна гэдэгт чинь энэ хөгжлийг хурдасгахын тулд л боломжийг олгож байна шүү дээ. Хүүхдүүддээ, иргэддээ, ирээдүйдээ. Гэтэл өнөөдрийн энэ хэлэлцүүлгээр миний авсан мэдээллээр болохлоороо англи хэлийг дараагийн одоо 2 дахь хэл болгоно боловсролын шатны үндсэн туслах хил болгоно. Үндсэн гадаад

хэл болгоно гэдэг энэ заалтыг унагасан байна.

Ингэж болохгүй ингэх юм бол Монгол Улс хөгжихгүй. Өнөөдөр бид нар Хятадуудтай хүний тоогоор өрсөлдөөд хөгжихгүй шүү дээ. Оросуудыг дийлэхгүй өнөөдөр юугаараа вэ гэхлээрээ бид нар хүнээ чадавхжуулах байдлаар дэлхийн хөгжлийг амдаж л угтаж л одоо өрсөлдөхөөс биш дагаж явах ямар ч боломж байхгүй шүү дээ. Гэтэл дэлхийн шинжлэх ухааны хэл чинь англи хэл дээр шүү дээ. Бүгд англи хэл дээр явж байгаа. Энд сууж байгаа хүмүүс бүгдээрээ англи хэл дээр л мэдээлэл авч байгаа биз дээ. Үгүй яагаад энэ боломжийг өнөөдөр суурийг нь хийгээд явахаас та бүхэн татгалзаад байгаа юм бэ? Тэгээд энэ асуулт нь Засгийн газрын бодлого гэж оруулж ирээд өнөөдөр энэ төсөл Засгийн газрын.

**Г.Мөнхцэцэг:** Бид хэлэлцэж байгаа асуудал мөн одоо хураалгаж байгаа саналын томъёололтой холбоотойгоор үг хэлж, асуулт асууж, хариулт авах ёстой хурлынхаа дэгээр. Тийм учраас энэ сая Доржханд гишүүний асуусан тэр одоо зардалтай холбоотой асуултад мөн дээр нь одоо саяын хураалгасан саналын томъёолол, тэр хэлтэй холбоотой асуудлаар Боловсролын сайд хариулт өгчихье.

**Л.Энх-Амгалан:** Доржханд гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр үндсэндээ бид нар энэ Үндсэн хуулиараа тунхагласан хүний эрх, ардчилал, зах зээлийн чиг баримжаатай эдийн засагтай улс орон байх энэ зарчмаасаа би ухрахгүй л болов уу гэж бодож байгаа шүү дээ.

Тийм ч учраас бид нар сүүлийн хэд хэдэн удаагийн Үндсэн хуулийн өөрчлөлт хийж энийгээ улам бэхжүүлэх чиглэл рүү улс төрийн бүх намууд урагшаага алхаж байгаа л гэж ойлгож байгаа. Тэгэхээр энэ боловсролын салбар дээр бол төр хувийн

хэвшлийн түншлэлийн зарчим байна. Энэнээс бид нар ерөөсөө ухрахгүй. Тэгэхээр бид нар одоо Монгол Улсад өнөөдөр үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын одоо хөтөлбөртэй, олон улсын одоо энэ сургуулиуд дээр байгаа энэ боловсролын чанарын асуудал, боловсролын хүртээмжийн асуудлууд, боловсролын шинэ технологийн асуудлууд, шинэ арга зүйн асуудлуудаас бид нар суралцах ёстой.

Тэрнээс биш одоо юу гэдэг юм эд нарыгаа нүд үзүүлээд ингээд байж болохгүй. Одоо бид нарын өмнө тулгамдаж байгаа асуудлууд бол яаж энэ төрийн өмчтэй их дээд сургуулиудаа энэ хувийн сургуулиудын одоо зэрэгт яаж хүргэх вэ, яаж ойртуулах вэ, энэ боловсролын чанар энэ хүртээмжийг яаж ойртуулах вэ, хүүхэд хаана амьдарч, хаана сурч байгаагаасаа үл шалтгаалж энэ тэгш боломжуудыг бид нар яаж олгох вэ л гэдэг энэ л тогтолцооны шинэчлэл хийх эрх зүйн одоо бичиг баримтуудыг л өнөөдөр бид нар хэлэлцээд явж байгаа шүү дээ. Тэгэхээр одоо ганцхан англи хэл яриад, энэ хууль ганцхан англи хэлээр одоо бүх зохицуулалтыг хийх юм шиг англи хэлийг хэддүгээр ангид заах нь энэ хуулиар одоо шийдэгдэж байгаа юм шиг нэг ийм буруу ташаа мэдээллүүд ард иргэдэд өгч битгий ард иргэдийг талцуулаач. Битгий ард иргэдийг битгий бухимдуулаачээ л гэж бодож байгаа.

Ерөөсөө одоо ингээд бид нар юм юмыг нэг ийм бодитойгоор хэлэлцүүлэг хийж байж л яах ёстой. 21 дүгээр зууны ур чадвар бол мэдээж ойлгомжтой шүү дээ. Бид нар одоо 21 дүгээр зууны ур чадварыг хүүхдэдээ юугаар эзэмшүүлэх вэ гэвэл цахим ур чадвар, нөгөөдөх нь англи хэлний ур чадвар.

Тийм учраас бид нарын хөтөлбөрийн шинэчлэл хийх гэж байгаа энэ хөтөлбөрийн шинэчлэлийн хамгийн гол амин сүнс бол цахим ур чадвар, англи хэлний ур чадвар байна. Энэнээсээ Монгол Улс, Монгол Улсын Их Хурал, Монгол

Улсын Засгийн газар нэг ч алхам би хойшоо гишгэхгүй гэж бодож байна. Харин ч одоо бид нар урагшаагаа ингээд гишгээд явах ёстой.

Тийм учраас одоо би түрүүн Доржханд гишүүн байхгүй байх шиг байна л даа. Бид нар энэ баталж байгаа өнөөдрийн эцсийн хэлэлцүүлэг хийж байгаа энэ хуулиар ерөөсөө цаашидаа Монгол Улсад хөтөлбөрийн одоо шилжилт хийхэд тодорхой одоо хөтөлбөрийн, менежментийн цикл гэдэг одоо хамгийн багадаа 10 жил нэг хөтөлбөр амжилттай, тогтвортой хэрэгжиж байж үр дүнг нь харж байж дараагийнхаа хөтөлбөр рүү хөтөлбөр лүү шилждэг энэ эрх зүйн шинэчлэлтүүдийг л бид нар хийж өгч байгаа байхгүй юу.

Тийм учраас бол одоо юу гэдэг юм энэ хуулиас одоо англи хэл гэдэг үг хасагдчихаад нөгөө ардын хүүхдэд англи хэл сурах боломжийг ингээд хуулиар хаачхаж байгаа юм шиг нэг ийм буруу ташаа мэдээллүүд ерөөсөө ард иргэддээ бид нар өгч болохгүй байгаа юм Доржханд гишүүн ээ.

**Г.Мөнхцэцэг:** Доржханд гишүүн тодруулъя.

**Т.Доржханд:** 1 дүгээрт хувийн секторыг дэмжих ёстой. Тэрэн дээр бол Энх-Амгалан сайдтай бол 100 хувь санал нэг байна. Хөрөнгө оруулалтыг нь бүүр сайн дэмжих ёстой боломжийг өгөх ёстой бүгдэд нь. Төсвийн ачааллаа бас тооцож үзэх ёстой. Бүх хүмүүст үнэгүй боловсрол олгоно гэж попрохоо болих хэрэгтэй. Хүртээмжийг сайжруулах нь бол зүйтэй. Гэхдээ энийг хувийн секторын хамтын оролцоогоор шийдэж л явна, төсөв чинь дийлэхгүй эрхэм гишүүдээ. Ингэж ярьж байгаа гишүүдэд хандаж байгаа шүү.

Хоёрт нь англи хэл бол чухал би англи хэл бол зөвхөн энэ асуудал энэ хуулийн одоо үндсэн концепц гэж яриагүй байна. Гэхдээ энэ чинь маш чухал юм шүү

дээ, хөгжлийн асуудал. Тэгээд Засгийн газар нь өөрөө бодлогоо боловсруулаад англи хэлийг дэмжинэ гээд одоо Засгийн газрын тэргүүн нь оруулж ирсэн байлгүй дээ. Тэгээд тэрийгээ энэ Улсын Их Хурал дээр зөв бодлогыг унагадаг нь ямар учиртай юм бэ л гэж асуугаад байгаа юм. Энэ МАН-ын бодлого юм уу?

**Г.Мөнхцэцэг:** Доржханд санал хэллээ. Хураалгаж байгаа саналтай холбогдуулаад санал хураалт. Дэгээрээ 3-ны 2-оор энэ санал хураалтыг явуулах ёстой. Ингээд санал хураалт.

Энэ санал 90.9 хувиар дэмжигдлээ.

Дахиад энэ саналыг одоо ердийн олонхоор ингэж дэмжих санал хураалт явуулах ёстой дэгээрээ.

Санал хураалт ердийн олонхоор. Энэ санал ердийн олонхоор 90.9 хувиар дэмжигдлээ.

Байнгын хорооны хурал дүгээр асуудлын саналын томъёоллоор санал хураалт явуулж дууслаа. Чуулганы нэгдсэн хуралдаанд Байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Гонгорын Дамдинням танилцуулна.

11.30 цагт

Дараагийн асуудалдаа оръё.

Хоёр дугаар асуудал байна. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл. Засгийн газраас 2021 оны 6 дугаар сарын 24-ний өдөр өргөн мэдүүлсэн байгаа.

Энэ одоо Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн нэрс бол түрүүчийн 1 дүгээр асуудал дээр орсон ажлын хэсгийн нэрс хэвээрээ байгаа.

Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн ахлагч Улсын Их Хурлын гишүүн Дамдинням танилцуулна.

**Г.Дамдинням:** Боловсролын ерөнхий хуулийг дагаж өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлаар хэлэлцэхэд бэлэн болсон байгаа. Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн ажлын дэд хэсгээс гаргасан 33 зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор Улсын Их Хурлын ажлын хэсэг ажиллаж одоо бэлэн болгосон байгаа.

Эрхэм байнгын хорооны гишүүд, Улсын Их Хурлын нэгдсэн чуулганд орох анхдугаар хэлэлцүүлгийн өмнөх одоо Байнгын хорооны хэлэлцүүлгийг хийж дэмжиж өгөхийг хүсье.

Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Танилцуулга хийсэн Дамдинням гишүүнд, ажлын хэсгийн ахлагчид баярлалаа.

Тэгээд гишүүний хуулийн төслийн тухай зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн дагуу байнгын хорооны хуулийн төслийн зүйл заалт бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийн зүйл, заалт бүрээр хэлэлцэнэ. Гишүүн хуулийн төслийн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно гэсэн ийм дэгтэй байгаа. Ингээд хуулийн төслүүдийг зүйл бүрээр нь хэлэлцье.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 1 дүгээр зүйл дээр

асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 2 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Ажлын хэсгээс зарчмын зөрөөтэй саналтай байгаа.

Саналын томъёоллыг уншиж танилцуулъя.

Төслийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “эдгээртэй” гэснийг “эдгээр хуультай” гэж өөрчилж, 2.2 дахь хэсгийн “нэгдэн орсон” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

72.7 хувиар санал дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “оюун ухаан” гэснийг “танин мэдэхүй” гэж, 3.2 дахь хэсгийн “ёс зүйтэй” гэснийг “ёс суртахуунтай” гэж, 3.3 дахь хэсгийн “Сургалтын байгууллага” гэснийг “Хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/, ерөнхий боловсролын сургууль” гэж, “захиргааны байгууллагатай” гэснийг “ захиргааны байгууллага, иргэний нийгмийн байгууллагатай” гэж өөрчилж, 3.3 дахь хэсгийн “асран хамгаалагч” гэсний дараа “харгалзан дэмжигч,” гэж /цаашид тохиолдол бүрд/ нэмэх.

Санал хураалт.

Энэ санал 70.0 хувиар дэмжигдлээ.

3.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн “3-5” гэснийг “2-5” гэж өөрчилж, “4.7 дахь хэсгийн “сургуульд” гэсний өмнө “ерөнхий боловсролын” гэж нэмж, мөн зүйлийн 4.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 4.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:



“4.1. Сургуулийн өмнөх боловсролыг 4, бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 12 жилд эзэмшинэ.

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

4.Төслийн 5 дугаар зүйлийн 5.7 дахь хэсгийн “танхимын хичээл, сургалтын үйл ажиллагааг түр зогсоосон тохиолдолд Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу сургалтыг танхимын бус хэлбэрээр үргэлжлүүлэн” гэснийг “сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 8.3-д заасан хэлбэрээр” гэж өөрчлөх.

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

5.Төслийн “ГУРАВДУГААР БҮЛЭГ”-ийн нэрийг “ТЭГШ ХАМРУУЛАН СУРГАХ БОЛОВСРОЛ” гэж, 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсгийн “хөгжлийн онцлог” гэснийг “онцлог” гэж, 6.3 дахь хэсгийн “саналыг” гэснийг “санал, зөвшөөрлийг” гэж, 6.5 дахь хэсгийн “Энэхүү тогтоосон хугацаа нь хүүхдийн сурч боловсрох эрхийг хязгаарлахгүй байна” гэснийг “Тогтоох тохиолдолд ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөгөөр судлах хичээлийн цагийг бууруулахгүй.”, гэж, 6.7, 6.9 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 6.7 дахь хэсгийн “сувилагчтай” гэснийг “сувилагч болон сэргээх, нөхөн сэргээх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн ажилтантай” гэж өөрчилж, 6.1 дэх хэсгийн “Тайлбар”-ыг төслөөс хасаж, 6.4, 6.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“6.4.Энэ хуулийн 6.3-т заасан ганцаарчилсан сургалт зохион байгуулахтай холбогдох журмыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6.6.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суралцаж буй ялгаатай хэрэгцээтэй суралцагчид хөгжлийн дэмжлэг үзүүлэх журмыг боловсрол, нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Санал хураалт.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

6.Төслийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “монгол хэлээр” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 6.1-д заасан хэлээр” гэж өөрчилж, мөн зүйлийн 7.2 дахь хэсгийн “болон” гэснийг, 7.3 дахь хэсгийг төслөөс хасаж, 7.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 7.5 дахь хэсэг нэмэх:

“7.4.Энэ хуулийн 7.2-т заасан суралцагч Монгол хэлний тухай хуулийн 13.1.4-т заасныг үндэслэн хос хэлний хөтөлбөрөөр хичээллэх бөгөөд хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

7.5.Боловсролын ерөнхий хуулийн 6.6-д заасан суралцагч монгол дохионы болон бичгийн хэлээр боловсрол эзэмшинэ.”

Санал хураалт.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсгийн “математикийн” гэсний дараа “болон цахим технологийн” гэж нэмж, 8.3 дахь хэсгийн “хүүхдийн хөгжлийг дэмжих нэмэлт хөтөлбөр” гэснийг “энэ хуулийн 8.2-т зааснаас гадна нэмэлт үйл ажиллагаа” гэж өөрчлөх.

Санал хураалт.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

8.Төслийн 9 дүгээр зүйлийн гарчиг болон 9.1 дэх хэсгийн “сургалтын” гэснийг, 9.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 9.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“9.2.Ерөнхий боловсролын агуулгыг Боловсролын ерөнхий хуулийн 14.4-т заасан агуулга болон математик-байгалийн ухааны, нийгэм-хүмүүнлэгийн, хэл-харилцааны, бие бялдрын, урлаг-зоо зүйн, цахим болон зохион бүтээх технологийн, иргэний боловсрол, амьдрах ухааны мэдлэг, чадварыг хөгжүүлэх чиглэлээр тогтооно.”

Санал хураалт.

60.0 хувиар дэмжигдлээ.

9.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.2, 10.4, 10.6, 10.8, 10.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төслөөс 10.7 дахь хэсгийг хасах.

“10.1.Сургалтын хөтөлбөр нь үзэл баримтлалтай байна. Үзэл баримтлалыг Боловсролын ерөнхий хуулийн 27.1-д заасан Үндэсний зөвлөл хэлэлцэж, Засгийн газар батална.

10.2.Сургалтын хөтөлбөрийг энэ хуулийн 10.1-д заасан үзэл баримтлалд үндэслэн энэ хуулийн 8.2, 9.2-т заасан агуулгын хүрээнд боловсруулна.

10.4.Энэ хуулийн 7.4, 10.2, 10.3, 10.10-т заасан сургалтын хөтөлбөр, ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, Боловсролын ерөнхий хуулийн 14.8-д заасан цахим сургалтын хөтөлбөрийг боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10.6.Боловсролын ерөнхий хуулийн 27.4-т заасан мэргэжлийн зөвлөл нь сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө, сурах

бичиг, хичээлийн жилийн бүтцийн талаар мэргэжлийн дүгнэлт гаргах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Зөвлөл нь багш, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангасан байна.

10.8.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд нийцүүлэн энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрт эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн оролцоотой тохируулга хийж болно.

10.9.Боловсролын ерөнхий хуулийн 14.7-д заасан хугацаанд сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сайжруулж болох бөгөөд сайжруулсан сургалтын хөтөлбөр нь хөтөлбөрийн үзэл баримтлалд нийцсэн байна.”

Санал хураалт.

80.0 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 10 дугаар зүйлийн 10.5 дахь хэсгийн “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэснийг “3 хүртэлх насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих хөтөлбөрийг” гэж, мөн хэсгийн тайлбарын “Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэснийг “Энэ хуулийн 10 дугаар зүйлийн 10.5-д заасан цогц хөгжлийг дэмжих хөтөлбөр” гэж, “0-2 настай” гэснийг “3 хүртэлх насны” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 10.11, 10.12 дахь хэсэг нэмэх:

“10.11.Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт нь төлөвлөх, боловсруулах, турших, сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлэх үйл явцыг багтаасан тасралтгүй, цогц үйл ажиллагаа байна.

10.12.Энэ хуулийн 10.4-т заасан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн түүх, соёл, байгаль, цаг уурын онцлогийг тусгаж болно.”

Санал хураалт.

80.0 хувиар санал дэмжигдлээ. Энэ санал дээр цаг уурын онцлог гэж юу байх юм тиймээ. Энэ дээр бас дахиад найруулах, дахиж харах ийм чиглэлийг өгч байна. Уялдаа холбоо, үг сонголт нь ч гэсэн болоогүй байна. Энэ санал хураалтыг цуцлаад дахиад гүйцээн боловсруулах чиглэл өгч байна. Энэ санал 62.5 хувиар дэмжигдлээ. Цаашид бас найруулга дээр анхаараарай.

11.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.3, 11.9 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“11.1.Энэ хуулийн 10.6-д заасан мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн ерөнхий боловсролын сургалтад хэрэглэх сурах бичгийн жагсаалтыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

11.3.Сурах бичиг зохиоход багш, эрдэмтэн, судлаач, мэргэжлийн холбооны оролцоог хангаж, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, суралцагчийн төлөөллөөс санал авна.

11.9.Харааны бэрхшээлтэй болон энэ хуулийн 7.2-т заасан суралцагчид зориулан сурах бичгийг хөрвүүлнэ. Үндэстний цөөнх, сонсголын бэрхшээлтэй хүүхдийн эх хэлний сурах бичгийг зохионо.”

Санал хураалт.

80.0 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн “сурах бичиг зохиох турших, сургалтад ашиглахтай” гэснийг “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээхтэй” гэж, 11.6 дахь хэсгийн “хөтөлбөрийн хэрэгжилтийн” гэснийг “сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх” гэж, 11.7 дахь хэсгийн “үнэ төлбөргүй” гэснийг “төлбөргүй” гэж, “ашиглуулна” гэснийг “ашиглуулах бөгөөд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт

гаргасан бол сурах бичгийг худалдан авч болно.” гэж, 11.12 дахь хэсгийн “танин мэдэхүйн” гэснийг “сэтгэхүйн” гэж өөрчилж, 11.4 дэх хэсгийн “төрийн захиргааны” гэсний дараа “төв” гэж нэмж, 11.10, 11.11 дэх хэсгийг төслөөс хасах.

Санал хураалт.

81.8 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтын “ахиулах зорилгоор” гэснийг “ахиулахад чиглэсэн” гэж өөрчилж, 12.1.3, 12.1.5 дахь заалт, 12.1.6 дахь заалтын “тайван амьдрах” гэснийг хасах.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

14.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь хэсгийн “дэг журмыг” гэснийг “дүрэм, журмыг” гэж өөрчилж, 13.1.1, 13.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“13.1.1.бие даан суралцах, хувь хүн, бүлэгтэй харилцах, хамтран ажиллах ур чадвараа хөгжүүлэх;

13.1.3.бусад суралцагчийг эрсдэлд оруулах үйлдэл гаргахгүй, сурах, сургах үйл ажиллагаанд саад учруулахгүй байх.”

Санал хураалт.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 14 дүгээр зүйлийн 14.1, 14.2 дахь хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах” гэж, 14.2 дахь хэсгийн “хүүхдийн тооноос” гэснийг “хүүхдийн тоо, ялгаатай хэрэгцээнээс” гэж, мөн хэсгийн “бусад” гэснийг “холбогдох хууль тогтоомжид заасан” гэж, 14.4 дэх хэсгийн “туслах багш” гэснийг “багшийн туслах болон холбогдох хууль тогтоомжид заасан ажилтан” гэж өөрчилж, 14.1 дэх хэсгийн “үйлчилгээний”

гэснийг хасаж, мөн зүйлийн 14.3 дахь хэсгийн “эмч” гэсний дараа “номын санч” гэж, мөн доор дурдсан агуулгатай 14.6 дахь хэсэг нэмэх.

Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя.

“14.6.Цэцэрлэгт сэтгэл зүйч, хоол зүйч ажиллуулж болно.”

Санал хураалт.

Санал хураалтыг цуцалъя.

Ундрам гишүүн үг хэлье, санал хэлье. Ундрам гишүүний микрофоныг өгье.

**Ч.Ундрам:** Энэ заалт дээр надад нэг ийм асуудал байгаа юм. Энэ Ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байгаа номын санчийг энэ одоо олон улсын туршилагаар номын санч бөгөөд багш гэж авч үздэг болчихсон юм байна. Хүүхдэд одоо номын санг хэрхэн хэрэглэх вэ? Өөрийнхөө үзэж байгаа хичээлтэй холбогдолтой номыг яаж ирж олж одоо хэрэглэх вэ? Мөн одоо аль хичээлтэй нь аль номууд илүү ойролцоо байх вэ гээд ерөнхийдөө номын сан, хэрэглэх ном, одоо уншиж хэрэглэж сурах өөртөө шаардлагатай эх сурвалжуудыг бас тухайн судалж байгаа асуудалтайгаа холбоотой эх сурвалжуудыг олж ашиглах гээд энэ чиглэлийн одоо нэг ёсны багшлах үйл ажиллагаа давхар хийгээд байгаа юм байна.

Яг одоо жирийн манай төв номын сан ч байдаг юм уу, Нацагдоржийн номын санд том хүмүүс ороод үйлчлүүлэхээс өөрөөр ийм багшлах үйл ажиллагаа хийдэг юм байна гээд олон улсын чиг хандлага нь ийм болчихсон юм байна.

Тэгээд одоо энэ манайд байгаа хувийн сургуулиуд дээр номын санч багш гэдгээрээ бүр яваад эхэлчихсэн юм байна. Одоо энэ бест туршилагуудаас харах юм

бол. Тэгэхээр манай энэ ЕБС дээр байгаа номын санчдыг номын санч багш гэдэг тэр утгаар нь авч хэрэглэвэл одоо хэрэгжүүлбэл яасан юм бэ? Ажиллуулбал гэсэн ийм санал байгаад байгаа юм. Тэгээд ер нь энэ номын сантай холбоотой манайд одоо ирж ажилласан гаднын судлаачид юу гэж байна вэ гэхээр бид нар хүүхдийг минутад хэдэн үг уншиж байна вэ гэдгийг нь одоо тоолж хэмжээд байдаг мөртөө уншсан агуулгаа ойлгож байна уу үгүй юү гэдгийг нь одоо төдийлөн үнэлэхгүй байна. Нэг их хурдан дуржигнатал ингээд минутад олон үг унших гээд л хүүхдүүд маань яараад байдаг. Гэтэл уншсан юмаа ойлгодоггүй.

Гоё бичиж байна уу, цэвэрхэн бичиж байна уу гэдгийг нь анхаараад байдаг мөртөө нөгөө уншсан юмаа ойлгоод өөрийн болгоод дүгнэлт хийгээд бичиж чадаж байна уу гэдэг агуулга руу нь анхаарахгүй илүү хэлбэр лүү анхаардаг юм байна гэсэн ийм дүгнэлт бас гарсан байсан.

Тэгэхээр номын санч нар бол тухайн уншиж байгаа юмаа агуулгыг нь ойлгодог өөрийнхөө хичээлтэй уялдуулж боддог гээд ийм багшлах ажлыг хийвэл илүү одоо зөв юм гэсэн ийм ялангуяа энэ Ерөнхий боловсролын сургуулийн номын санчдыг гэсэн ийм асуудал ярьж байгаа юм. Тэгэхээр бид нар энэ номын санч багш гэдэг тийм ажлын байрны тодорхойлолттой тийм статустай болгох боломж байгаа юу, үгүй юү гэдгийг одоо сайдаас асуумаар байна.

**Г.Мөнхцэцэг:** Би бас Ундрам гишүүний гаргаад байгаа энэ саналтай бас санал нэг байгаад байгаа. Тэгэхдээ энэ хуульд бол бас тодорхой хэмжээгээр номын санчтай холбоотой номын сантай холбоотой ийм заалтууд бол нэлээд тодорхой хэмжээгээр бас нэмэгдэж бас ингэж орж ирж байгаа. Тэгээд тэр номын санч багш байх гэдэг энэ зүйл заалттай холбоотойгоор ер нь манай ажлын хэсэг дэд ажлын хэсэг бас нэлээн

ярьсан. Тэгээд яг одоо ямар байдлаар тусгаж орж ирж байгаа талаар.

Энх-Амгалан сайд энэ дээр бас нэг хариулт өгчих нь зүйтэй байх.

**Л.Энх-Амгалан:** Ундрам гишүүн Байнгын хороон дарга 2 бас энэ сургуулийн номын сан, сургуулийн номын санчийн статусын асуудал дээр бас нэлээн энэ хууль дээр ахиц гаргая гэсэн ийм юунуудыг өгсөн. Энэ дээр бид нар санал нэг байгаа. Ерөнхийдөө өнөөдөр энэ дэлхий нийтээр ингээд аваад үзэхээр энэ сургуулийн номын сангийн одоо гүйцэтгэх үүрэг роль, чиг үүргүүд, сургуулийн номын санчийн чиг үүргүүд их өөрчлөгдөж байгаа юм байна лээ.

Тэгэхээр багш шууд одоо сургуулийн номын санч багш гэхээр дахиад нөгөө нэг төрийн албаны нөгөө нэг баахан хуулиудын нэр томъёонуудтай жаахан зөрчилдөх юмнууд гарах учраас бид нар угаасаа энэ хууль гарахаар энэ сургуулийн номын санч, сургуулийн эмч, сургуулийн сэтгэл зүйч, сургуулийн хоол зүйчдийн одоогийн чиг үүргүүдийг нэлээн өөрчилж гэж бодож байгаа.

Тэгээд энэнтэйгээ уялдуулаад одоо энэ хуулийн дагуу гарч ирэх журам дээр бол энэ нэлээн зохицуулалтууд орно. Ер нь бол бид нар сургуулийн номын санчийн энэ статусуудыг нэлээн өргөж ганцхан хүүхдэд туслахаасаа илүү бас багш нарт тусалдаг багш нарын хичээлийн бэлтгэл ажлууд дээр одоо тодорхой эх үүсвэрүүд, материалуудыг гардаж өгдөг одоо нэлээн ийм багш нарын дунд одоо хичээлийн энэ үйл ажиллагааг зохион байгуулахад бол энэ номын санчийн гүйцэтгэдэг үүрэг бол маш их юм байна лээ.

Тэгэхээр энэ чиглэл рүү одоо бид нар бас энэ хуулийн яг батлагдаж гарсны дараа бол нэлээн томоохон өөрчлөлтүүдийг хийхээр бол төлөвлөж байгаа гэдгээ бас би тайлбар болгоод хэлчихье гэж бодож байна.

**Г.Мөнхцэцэг:** Санал хураалтдаа оръё. Ажлын дэд хэсэг Ганбаяр сайд нэмэлт хариулт өгье. 5 дугаар микрофон дээр 5 дугаар микрофоныг өгье.

Ганбаяр сайдын дэд сайдын микрофоныг өгөөрэй.

**Г.Ганбаяр:** Ундрам гишүүний ярьж байгаа асуудалтай бол яг 100 хувь санал нэг байгаа. Бид нар дэд ажлын хэсэг дээр ажлын хэсэг дээр энэ номын сантай холбоотой эрх зүйн орчныг нэлээн сайжруулъя. Номын санчдын ажиллах орчин нөхцөл дээрээс нь тэд нарт боломж бололцоог нэлээн нэмэгдүүлье. Суралцагч нарт номын сан дээр одоо суралцах тэр боломж бололцоог өшөө нэмэгдүүлье гэдэг дээр бол бид нар нэлээн ажилласан. Тэгэхээр би нэг зүйлийг л хэлэхийг хүсэж байгаа нь одоо яг Байнгын хороон дээр явж байгаа соёлын бүтээлч үйлдвэрлэлийн хуулийг дагасан Номын сангийн хууль дээр бас та бүхэн энийг харж өгөөч. Энэ хуулиар энэ номын санчдын эрх зүйн орчин нь зохицуулагдаад байгаа учраас бид нар энэ асуудлыг бол яг энэ боловсролын хууль дээр бол Номын сангийн хуулийн бид нар 10.3-т байгаа чиг үүргийг нь бид нар барьж явж байгаа. Тэр хуульд нийцүүлж явж байгаа. Яагаад гэхээр хүчин төгөлдөр байгаа хууль учраас.

Тэгэхээр одоо байгаа тэр соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дагасан байгаа Номын сангийн хууль дээр тэр номын санч гэдэг тэр нэр томъёог тодорхой болгож өгөхгүй бол өнөөдрийн байгаа номын сангийн хуулиар бол номын санч гэдэг эрх зүйн орчин ч байхгүй байгаа юм. Ийм ийм чиг үүргийг хэрэгжүүлсэн ийм мэргэжлийн одоо ийм хүн байна л гэсэн ийм байгаа болохоос биш номын санч гэдгээ өөрөө тодорхойлолт нь байгаад байгаа учраас тэрийг одоо гишүүд та бүхэн байнгын хороон дээр ярих үе дээр анхаарч өгөөч гэж хүсэх гэсэн юм.

**Г.Мөнхцэцэг:** Хариулт хангалттай гэж үзэж байна.

*Ингээд санал хураалт.*

*Санал 70 хувиар санал дэмжигдлээ.*

*16.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “сургуулийн багш” гэснийг “ерөнхий боловсролын сургуулийн багш нь Боловсролын ерөнхий хуульд зааснаас гадна” гэж, 15.1.1 дэх заалтын “сургалтын” гэснийг “боловсролын” гэж, 15.1.3 дахь заалтын “төлөвшил, авьяас чадварыг хөгжүүлэх, амжилттай суралцахад” гэснийг “мэдлэг, чадвар, авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд” гэж өөрчилж, 15.1.5 дахь заалтын “байгуулах” гэснийг, 15.1.1 дэх заалтын “бүрэн” гэснийг, мөн зүйлийн 15.4 дэх хэсгийг төслөөс хасаж, 15.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:*

*“15.2.Багш нь суралцагчийн ялгаатай хэрэгцээнд тохируулан хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулна.”*

*Санал хураалт.*

*60.0 хувиар санал дэмжигдлээ.*

*17.Төслийн 15.1.2, 15.1.6 дахь заалт, 15.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 15.6 дахь хэсэг нэмэх:*

*“15.1.2.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, хариу арга хэмжээ авахтай холбоотой бусад хууль тогтоомжоор хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;*

*15.1.6.хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчдэд ганцаарчилсан хэлбэрээр зөвлөгөө өгөх, холбогдох бусад байгууллагатай хамтран ажиллах.*

*15.5.Багш нь суралцагчийн хувийн мэдээллийг холбогдох хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд ашиглахыг хориглоно.*

*15.6.Энэ хуулийн 27.2-т заасан суралцагчийн үнэлгээг бусдад задруулахыг хориглоно.”*

*Санал хураалт.*

*70.0 хувиар санал дэмжигдлээ.*

*18.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсгийн “Багш нь” гэсний дараа “дээд боловсролтой” гэж, 16.6 дахь хэсгийн “мэргэжил дээшлүүлсэн” гэсний дараа “магистр зэрэгтэй” гэж нэмж, 16.2 дахь хэсгийн “Боловсролын ерөнхий хуульд заасны дагуу багшлах эрхтэй” гэснийг “багшлах эрхийн гэрчилгээтэй” гэж, 16.7 дахь хэсгийн “түвшин” гэснийг “мэдлэг” гэж, “3-5 жил” гэснийг “3 жил” гэж өөрчилж, мөн зүйлийн гарчгийн “тасралтгүй” гэснийг, 16.5 дахь хэсгийн “үндэсний, орон нутгийн түвшинд болон ажлын байранд” гэснийг хасаж, 16.4 дэх хэсгийг 16.4, 16.5 дахь хэсэг болгож, доор дурдсанаар өөрчлөн найруулах.*

*“16.4.Багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн, орон нутгийн, үндэсний түвшинд зохион байгуулна.*

*16.5.Энэ хуулийн 16.4-т заасан цэцэрлэг, ерөнхий боловсролын түвшинд зохион байгуулах багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих сургалт, үйл ажиллагааг Боловсролын ерөнхий хуулийн 12.13-т заасан нэгж зохион байгуулна.”*

*Санал хураалт.*

*60.0 хувиар санал дэмжигдлээ.*

*19.Төслийн 17 дугаар зүйлийн 17.1.3 дахь заалтын “нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэснийг, мөн зүйлийн 17.6 дахь хэсгийг төслөөс хасаж, 17.1.5 дахь*

заалтын “сургуулийн” гэснийг “сургууль, дотуур байрын” гэж өөрчилж, 17.1.3 дахь заалтын “суралцагчийн хөгжил, төлөвшилийг дэмжих” гэсний өмнө “хамран сургах тойргийн хүүхэд бүрийг цэцэрлэг, сургуульд бүрэн хамруулах, бүртгэх ажлыг зохион байгуулах,” гэж, “сургалтын” гэсний дараа “үйл ажиллагааны” гэж, 17.1.5 дахь заалтын “зохион байгуулах” гэсний дараа “эрсдэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэдний эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах,” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 17.1.10, 17.1.11 дэх заалт, 17.7, 17.8 дахь хэсэг нэмж, 17.1.8 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“17.1.8.боловсролын чанар, үр дүнг томилсон этгээд, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, энэ хуулийн 8 дугаар бүлэгт заасан байгууллагад хичээлийн жилд тайлагнах, хариуцах;

17.1.10.энэ хуулийн 18.8-д заасан байгууллагад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх;

17.1.11.Төсвийн тухай хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мэдээллийг багш, ажилтан, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчид ил тод, нээлттэй, ойлгомжтой хэлбэрээр мэдээлэх.

17.7.Боловсролын ерөнхий хуулийн 10.2 дахь хэсэг, энэ хуулийн 13.1.2, 13.1.3-т заасан үүргээ биелүүлээгүй суралцагчийг ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтны болон сэтгэл зүйчийн зөвлөгөө, үйлчилгээнд хамруулж болно. Шаардлагатай тохиолдолд холбогдох хуульд заасан үйлчилгээнд холбон зуучилж болно.

17.8.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулах

гэрээгээр сургалтын төлбөр төлөх, хураамж авах харилцаанд багш, суралцагчийг оролцуулахыг хориглоно.”

Санал хураалт.

72.7 хувиар санал дэмжигдлээ.

20.Төслийн **“ЗУРГААДУГААР БҮЛЭГ”**-ийн нэрийн **“СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА”** гэсний өмнө **“БОЛОВСРОЛЫН”** гэж нэмж, 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“18.2.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, анги, бүлгийн зохион байгуулалтыг суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч уян хатан зохион байгуулах бөгөөд суралцагчийн тоог боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.”

Санал хураалт.

63.6 хувиар санал дэмжигдлээ.

21.Төслийн 18 дугаар зүйлийн 18.3 дахь хэсгийн “үйл ажиллагаандаа баримтлах” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 30.1.23-т заасан үлгэрчилсэн дүрэмд нийцсэн” гэж, 18.7 дахь хэсгийн “өөрийн” гэснийг “өөрийн болон хөндлөнгийн” гэж өөрчилж, 18.1 дэх хэсгийн “хүүхдийн” гэснийг, 18.9, 18.10 дахь хэсгийг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 18.11, 18.12, 18.13, 18.14 дэх хэсэг нэмэх.

“18.11.Ерөнхий боловсролын сургууль дотуур байртай байж болно. Дотуур байрын орчин, үйлчилгээнд тавих шаардлагыг Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд заасны дагуу баталж мөрдөнө.

18.12.Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байранд амьдарч байгаа суралцагчид зориулан энэ хуулийн

20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааны хөтөлбөрийг тусгайлан боловсруулж, хэрэгжүүлнэ.

18.13.Энэ хуулийн 18.12-т заасан хөтөлбөрийг Боловсролын ерөнхий хуулийн 43.1.2-т заасан хүүхдийн эрх, хамгааллын зардлаас санхүүжүүлнэ.

18.14.Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль нь номын сантай байх бөгөөд Номын сангийн тухай хуулийн 10.3-т заасан үйлчилгээ үзүүлнэ.”

Санал хураалт.

63.6 хувиар санал дэмжигдлээ.

22.Төслийн 19 дүгээр зүйлийн нэрийг “Цэцэрлэг” гэж, 19.1 дэх хэсгийн “хүүхдийн цэцэрлэг /цаашид “цэцэрлэг” гэх/” гэснийг “Цэцэрлэг” гэж, 19.2 дахь хэсгийг өөрчлөн найруулж, төсөлд 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг болгох.

“21.2.Сургалт, үйл ажиллагааг бага, дунд, ахлах болон холимог бүлгээр зохион байгуулна.”

Санал хураалт.

63.6 хувиар санал дэмжигдлээ.

23.Төслийн 20 дугаар зүйлийн 20.9 дэх хэсгийг төслөөс хасаж, 20.14 дэх хэсгийн “энэ хуулийн 8.7-д” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 8.1-д” гэж өөрчилж, 20.4, 20.11, 20.16 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“20.4.Энэ хуулийн 20.2-т заасан ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг тогтооход хөгжлийн бодлого, төлөвлөлт, хүн амын нягтаршил, газарзүйн байршил зэрэг хүчин зүйлийг харгалзана.

20.11.Суралцагчийн суралцах үйл ажиллагаа, хөгжил төлөвшлийг дэмжсэн, ажил мэргэжлийн чиг баримжаатай болоход чиглэсэн хичээлээс

гадуурх сургалт, үйл ажиллагаа нь ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны салшгүй хэсэг байна.

20.16.Энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт, үйл ажиллагааг үлгэрчилсэн хөтөлбөр, хуваарийн дагуу холбогдох байгууллага, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, иргэдтэй хамтран зохион байгуулна.”

Санал хураалт.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

24.Төслийн 20 дугаар зүйлийн 20.2.3, 20.2.4 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 20.17 дахь хэсэг нэмэх.

“20.2.3.1-12 дугаар ангитай, эсхүл 6-12 дугаар ангитай бүрэн дунд сургууль;

20.2.4.10-12 дугаар ангитай ахлах сургууль.

20.17.Энэ хуулийн 20.11-д заасан хичээлээс гадуурх сургалт, үйл ажиллагааны үлгэрчилсэн хөтөлбөрийг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.”

Санал хураалт.

60.0 хувиар санал дэмжигдлээ.

25.Төслийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2 дахь заалтын “сургалт” гэсний дараа “, үйл ажиллагаа” гэж нэмж, 21.1.2 дахь заалтын “дэмжигч /явуулын/ багшийн” болон “нүүдлийн бүлгийн” гэснийг “хувилбарт” гэж, 21.3 дахь хэсгийн “боловсролын болон санхүү, төсвийн” гэснийг “боловсролын” гэж өөрчилж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 21.4 дэх хэсэг нэмэх:

“21.4.Хувилбарт сургалт нь энэ хуулийн 5.1-д заасан хугацаанд хамаарахгүй.”



Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

26.Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “сургалтыг” гэснийг “сургалтыг бага, дунд, ахлах” гэж, 22.6 дахь хэсгийн “суралцах, хөдөлмөрийн заах зээлд шилжихэд” гэснийг “суралцахад” гэж, мөн зүйлийн 22.2 дахь хэсгийг хасаж, 22.3, 22.5 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулж, төсөлд 22.7, 22.8 дахь хэсэг нэмэх.

“22.3.Ерөнхий боловсролын сургууль нь нэг бүлэгт суралцах суралцагчийн тоо, суралцагчийн ялгаатай хэрэгцээнээс хамаарч холимог бүлгээр хичээллэж болно.

22.5.Суралцагчийг сургуулийн орчинд дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, сургалтын агуулгыг нөхөх зорилгоор энэ хуулийн 20.11, 20.12-т заасан сургалт үйл ажиллагаа, нэмэлт сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

22.7.Ерөнхий боловсролын сургууль нь Боловсролын ерөнхий хуулийн 30.1.15-д заасан журмыг баримтлан зайн болон цахим сургалтыг зохион байгуулна.

22.8.Эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргаж, энэ хуулийн 22.8.1-д заасан журмын дагуу 1-3 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг хүүхдэд гэрээр эзэмшүүлж болно.

22.8.1.эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүүхдэд гэрээр боловсрол эзэмшүүлэхэд тавих шаардлага, эрх, үүрэг, хариуцлага, сурлагын амжилтыг үнэлэх, баталгаажуулах журмыг Засгийн газар батлах.” Энэ дээр найруулгын зүйлүүд байгаад байна. Энэ дээр жоохон анхаармаар байна. Баталгаажуулалт хийх энэ тэр гээд нэг махчилсан байдлаар хийгээд байх юм. Энэ бичилт дээр жоохон анхаарч ажилламаар байна.

Санал хураалт.

50.0 хувиар санал дэмжигдсэнгүй.  
Би бас ярьж байгаад.

Дахиад санал хураалт явуулъя.

Санал хураалт. 3 хурааж болно.

Санал хураалт.

Энэ санал 70.0 хувиар дэмжигдлээ.

Нэг унаж, нэг дэмжигдсэн тэгээд 3 хүртэл хураалгаж болох учраас дахин санал хураалт.

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

27.Төслийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Зөвлөл” гэсний өмнө “Боловсролын ерөнхий хуулийн 39.2-т заасан” гэж нэмж, 23.2.1 дэх заалтын “хөгжил, бодлого, төлөвлөлт, түүний хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх” гэснийг “хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх явцад санал, дүгнэлт гаргах” гэж өөрчилж, 23.2.5 дахь заалтын “бүх талын оролцоог хангах” гэснийг, 23.2.4 дэх заалтыг төслөөс хасаж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 23.2.8, 23.2.9 дэх заалт нэмэх:

“23.2.8.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүжилт, хөрөнгө оруулалт, төсвийн төлөвлөлтөд хэрэгжүүлэх арга хэмжээ, төслийг эрэмбэлэх, шийдвэрлүүлэх, санал өгөх;

23.2.9.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлттэй танилцах;”

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

28.Төслийн 23 дугаар зүйлийн 23.2.2, 23.2.3 дахь заалтыг нэгтгэн 23.2.2 дахь заалт болгон өөрчлөн найруулж, мөн зүйлийн 23.2.6, 23.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“23.2.2.суралцагчийн хөгжил, төлөвшилийг дэмжих, сурлагын хоцрогдол үүсэхээс сэргийлэх, сурлагын ахиц гаргах, эрүүл, сургалтын аюулгүй орчин бүрдүүлэхэд санхүүгийн болон оролцооны дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг энэ хуулийн 18.8-д заасан байгууллагатай хамтран зохион байгуулах;”

23.2.6.цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, дотуур байрын орчинд аливаа дарамт, ялгаварлан гадуурхалт, хүчирхийлэл, үе тэнгийн дээрлэхэлтээс сэргийлэх, хүүхэд хамгааллын хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, тайланг хэлэлцэх;

23.2.7.Боловсролын ерөнхий хуулийн 45.3-т заасан гэрээнд тусгах саналыг цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн захиралд хүргүүлэх, гэрээний хэрэгжилтийг хэлэлцэх.”

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

Энэ санал дээр найруулгыг нэлээ сургуулийн удирдлагын. Оролцооны дэмжлэг үзүүлэх энэ тэр гээд энэ дээр манай ажлын хэсэг дахиж эргээж хараарай гэдэг чиглэлийг өгч байна.

29.Төслийн 25 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 25.4 дахь хэсэг нэмэх:

“25.4.Багшийн мэргэшүүлэх сургалт, үйл ажиллагааг энэ хуулийн 16.5-д заасан нэгжтэй хамтран зохион байгуулна.”

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

30.Төслийн 26 дугаар зүйлийн 26.3 дахь хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрсөн мэргэжлийн” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан” гэж, 26.6 дахь хэсгийн “18.8-д заасан өөрийн” гэснийг “18.7-д заасан” гэж, 26.7 дахь хэсгийн “боловсролын салбарын мэдээллийн нэгдсэн санд” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 17.7-д заасан байгууллага боловсролын цахим мэдээллийн санд” гэж өөрчлөх.

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

31.Төслийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсгийн “1-2” гэснийг “1-3” гэж, 27.4 дэх хэсгийн “боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны” гэснийг “Боловсролын ерөнхий хуулийн 33-т заасан орон нутгийн” гэж, 27.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах.

“27.6.Суралцагч, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн саналыг үндэслэн давтан сурах боломжийг суралцагчид олгож болно.”

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

32.Төслийн 28 дугаар зүйлийн 28.2 дахь хэсгийг төслөөс хасаж, 28.3 дахь хэсгийн “заавал хамруулах үүрэг хүлээнэ” гэснийг “хамруулахад захиргааны дэмжлэг үзүүлнэ” гэж, 28.6 дахь хэсгийн “мэдээллийн” гэснийг “цахим” гэж өөрчилж, 28.4 дэх хэсгийн “орон нутгийн” гэсний дараа “цэцэрлэг” гэж, мөн зүйлд доор дурдсан агуулгатай 28.10, 28.11 дэх хэсэг нэмэх.

“28.10.Аймаг, сум, нийслэл, дүүргийн Засаг дарга түүнийг томилсон

этгээд хооронд байгуулсан гэрээнд харьяа нутаг дэвсгэрийн хүүхдийг цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд хамруулах, боловсролын чанарын үзүүлэлтийг ахиулах талаар тусгана. Эцсийн найруулгыг уншихгүй бол бас уншихад.

28.11.Ерөнхий боловсролын сургуульд суурилсан суралцагчийн эрүүл мэндийн хяналт, тандалт, бүртгэлийг бүрдүүлж, тодорхой насны давтамжтайгаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг, үзлэг, шинжилгээ, оношлогоонд хамруулах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулах.

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

Энэ томьёолууд дээр жоохон найруулгын засвар хийхгүй бол баахан хавсарсан нийлмэл өгүүлбэр орж ирээд уншигдахгүй байгаад байна. Уншигдахгүй байна гэдэг чинь батлагдахгүй. Батлагдахгүй байна гэдэг чинь хэрэгжихгүй гэсэн үг.

Энэ санал 70 хувиар дэмжигдлээ.

33.Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн дугаарлалт, бүлэг, зүйл, хэсэг, заалтын дугаарыг агуулгын хувьд эрэмбэлэн, үг, найруулгыг жигдлэх, хууль зүйн техникийн болон бусад засварыг хийх.

Санал хураалт.

70.0 хувиар санал дэмжигдлээ.

Санал хураалт яваад дууссан.

Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 29 дүгээр зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 30 дугаар зүйл дээр асуулт, саналтай гишүүн байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй санал гаргасан гишүүн байна.

Энэ хуулийн 4.7-д хөдөө аж ахуйн салбарт ажилладаг өрхийн хүүхэд болон хүүхдийн өсөлт хөгжил, эрүүл мэндийн байдал, бусад хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хүүхдийг 7 настайд нь элсүүлж болно гэж Туваан гишүүнээс саналын томьёолол гаргасан байна. Энэ саналын томьёолол маань өөрөө бас орсон.

Орсон байгаа учраас санал хураах шаардлага байхгүй гэж үзэж байна.

Аан за ийм байна шүү түрүүн бид нар чинь хууль дээрээ болохоороо малчны хүүхэд гээд ингээд тийм тусгай зүйл, заалт оруулчихсан. Хүндэтгэн үзэх шалтгаан гэдгийг нь бид нар одоо бас нэлээн судлах шаардлагатай байсан. Тэгэхдээ оруулсан. Хүндэтгэн үзэх шалтгааныг нь яаж томьёолох вэ гэдгийгээ бас оруулсан байгаа.

Тэгэхээр малчны хүүхэд гээд ингээд оруулчихсан.

Дээр нь бол ингээд тариаланчийн хүүхэд гээд ингээд бас өөр заалтууд одоо орж ирж байгаа юм байна.

Тийм учраас бол энэ дээр санал хураалт явуулах юм байна шүү. Гишүүдээ анхаарлаа хандуулаад санал хураалтдаа оролцъё.

Санал хураалт.

Туваан гишүүний гаргаж байгаа санал.

Санал хураалт явуулах ёстой дэгийнхээ дагуу.

*Санал хураалт.*

Энэ санал 80 хувиар дэмжигдсэнгүй.

Ингээд өнөөдрийн 2 дахь асуудал буюу сургуулийн өмнөх болон Ерөнхий боловсролын сургуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн асуудал 2 дахь асуудал одоо хэлэлцэгдэж дууслаа.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч алдарт Дамдинням танилцуулна.

Хуралдаанд оролцсон гишүүддээ баярлалаа.

#### 12.12 цагт

*Гурав дахь асуудлыг хэлэлцье.*

Ажлын хэсэг, ажлын дэд хэсэгт баярлалаа.

Гурав дугаар асуудал.

Гишүүд анхаарлаа хандуулаарай 3 дугаар асуудалдаа оръё. Гишүүд байнгын хороо ирцээ бүрдүүлээрэй.

*Төрийн өмчийн ЕБС, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлын явц үр дүнгийн талаарх мэдээллийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Энх-Амгалан танилцуулна.*

**Л.Энх-Амгалан:** Улсын Их Хурлын гишүүд, Байнгын хорооныхоо гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Тэгээд төрийн өмчийн цэцэрлэг, ЕБС, дотуур байрны нүхэн жорлонг орчин үеийн ариун цэврийн байгууламжаар солих тухай төслийн ажлын явцын талаар танилцуулга хийе.

Ингээд би бас товчхон хийчихье гэж бодож байна. Яагаад гэвэл энэ презентаци бүх гишүүдэд тараагдсан байгаа. Тэгээд энэ презентацийн хамгийн арын нүүрэн дээр одоо өнөөдрийн байдлаар улсын комисс ажиллаад хүлээж авсан 183 объектын мэдээллийг бид нар QR кодоор одоо унших боломжтой. Ийм юм тараасан учраас бол QR кодоор уншаад тухайн аймаг сумдууд дээр хийгдэж байгаа Улсын комисст авсан ажлуудтай танилцах ийм бололцоо байгаа болов уу гэж бодож байна.

Ерөнхийдөө яг энэ чиглэлээр энэ ариун цэврийн байгууламжийг нүхэн жорлонг одоо солих энэ асуудлаар бол Улсын Их Хурлын 2020 оны 12 дугаар сарын 4-ний тогтоол Засгийн газрын 2 удаагийн тогтоол, Боловсролын сайдын болон одоо Боловсрол шинжлэх ухаан, Барилга, хот байгуулалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдуудын бас тушаалууд гарч энэ ажлыг зохион байгуулж байгаа.

Ерөнхийдөө бид нар бол энэ ажлыг нэг 4 ээлжид одоо ингэж хувааж хийе гэдгийг энэ төлөвлөгөөгөөр ажиллаж байна. Эхний ээлжид эхний нэг болон 2 дугаар ээлжид бол 16 аймгийн 92 сумын нийт 307 объектыг одоо хийхээр төлөвлөж ажиллаж байна.

3 дугаар ээлжид бол 17 аймгийн 130 сумын 303 объектыг одоо хийхээр зураг төслийнх нь ажлууд нь хийгдээд одоо ингээд зарим ажлууд нь одоо эхэлсэн гэж ойлгож болно.

4 дүгээр ээлжийн зураг төслийн ажлууд хийгдэж байна.

Энэ 4 дүгээр ээлж дээр бол 18 аймгийн 92 сумын одоо нийт 243 объектыг одоо хийж гүйцэтгэх ийм ажлуудыг бас бид нар төлөвлөж байна. Ингээд нийтдээ базаад яах юм бол энэ ажлын хүрээнд бол нийт 18 аймгийн 237 сумын одоо 873 объект буюу сургууль, цэцэрлэг, дотуур байрын объектуудыг

одоо нүхэн жорлонг халах энэ ажлууд бас хийгдэж байгаа. Яагаад ингээд 1-ээс 2 дугаар ээлж, 3 дугаар ээлж, 4 дүгээр ээлж болгож задалсан юм бэ гэдэг асуудал байгаа. Тэгэхээр яг үнэнийг хэлэхэд бол намайг ажил авахад одоо энэ ажил маань эхэлчихсэн байсан. Тэгэхдээ нөгөө мордохын хазгай гэдэг шиг их буруу эхэлсэн байсан. Энийг одоо бид нар хэлэх ёстой. Яагаад мордохын хазгайгаар буруу эхэлсэн бэ гэхээр 1, 2 дугаар ээлжийн энэ 307 объектыг зураг төсөлгүйгээр зарлачихсан байсан. Зураг төсөлгүйгээр.

Тийм учраас бол энийг нэгэнт зураг төсөлгүй нөгөө түлхүүр хүлээлгэж өгөх тухай гэрээгээр зарласан байсан учраас энэ дээр бол зураг төсөлгүй эхэлсэн ажил одоо ямархуу гүйцэтгэл гардаг, ямар одоо хүндрэлүүд учирдаг гэдгийг бид нар бүгдээрээ ойлгож байгаа. Тэгээд ерөнхийдөө би энэ ажлыг хүлээж авснаас хойш бол энэ одоо зураг төсөлгүйгээр эхэлсэн энэ ажлуудыг би зогсоосон. 6 сар зогсоосон. Ингээд 6 сар зогсоож Засгийн газар дээр орж ерөнхийдөө одоо энэ Барилга, хот байгуулалтын яам, Байгаль орчны яамны 3 яамны ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэг томилж ажиллаад дахиад одоо яг 1, 2 дугаар ээлж дээр энэ тендер нь зарлагдсан байсан 307 объектуудын одоо яг газар дээр нь очиж бүх энэ хийгдэж байгаа ажлуудын цар хүрээ тулгамдаж байгаа асуудлууд, бодит байдлуудтай танилцаж, бид нар дүгнэлтүүд гаргасан.

Энэ дээр үндэслээд ерөнхийдөө бид нар энэ зураг төслүүдийг нөхөж хийхгүйгээр энэ ажлуудыг одоо цааш нь үргэлжлүүлэх юм бол одоо төсвийн хөрөнгө бол маш ихээр одоо шамшигдуулах ийм нөхцөл байдал өртөг зардал нь нэмэгдэх ийм бодитой эрсдэл байсан учраас бол одоо ямар ч байсан энэ 307 объектын одоо зураг төслүүд нь үндсэндээ хийгдэж дуусаж байна.

Тэгэхээр өнөөдрийн бид нарын энэ 4 ээлжид хийгдэж байгаа ажлуудын гүйцэтгэлүүдийг одоо бас би хэлье. 1-ээс

2 дугаар ээлжид хийгдэж байгаа одоо 16 аймгийн 92 сумын 307 объектоос яг өнөөдрийн байдлаар ашиглалтад орсон нь бол 183 объект ашиглалтад орсон байна. Одоо 29 объект дээр бол улсын комисс ажиллахад бэлэн болсон, 95 объект дээр бол угсралтын ажил одоо үргэлжилж байгаа. Өвөл бол зогссон одоо угсралтын ажил үргэлжилж байна. Юуны хувьд бол 3 дугаар ээлжийн одоо 17 аймгийн 130 сумын одоо 330 объектоос одоо өнөөдрийн байдлаар нэг аймгийн 30 объект барилга угсралтын ажлын одоо гүйцэтгэгч нь шалгарсан. 2 аймгийн одоо 53 объект дээр барилга угсралтын ажлын тендер нь зарлагдсан.

3 аймгийн 60 объект дээр барилга угсралтын ажлын үнэлгээний хороо одоо байгуулагдаад ингээд явж байна. 11 аймгийн 160 объект дээр одоо зураг төсөв зураг төсөл магадлан хийгдэж байгаа. Аймагтай нь бас зөвшилцөх ажлууд хийгдэж байна. Ингээд зургийн ажил үргэлжилж байгаа одоо 160 объектууд байна. Ингээд 4 дүгээр ээлжид бид нар 18 аймгийн 92 сумын нийт 243 объектуудыг одоо бас энэ нүхэн жорлонг халах энэ ажлуудыг төлөвлөж байна. Төлөвлөж байна гэдэг нь одоогоор бол 4 дүгээр ээлжийн зургууд хийгдэж байгаа. Ингээд зургууд нь хийгдэж дууссаны дараа бол энэ тендерүүд нь зарлагдана.

Санхүүжилтийн хувьд тодорхой хүндрэлүүд үүссэн. Гэхдээ энэ санхүүжилтийн хүндрэл бол зөвхөн одоо гүйцэтгэлээс гэдэг юм уу төсөвт өртөг одоо нэмэгдсэнээс болсон ийм санхүүжилтийн хүндрэл гэж одоо бид нар ойлгож болохгүй. Эрдэнэт үйлдвэрээс нийгмийн хариуцлагын хүрээнд одоо гаргаж байгаа энэ 100 тэрбум төгрөг бол үндсэндээ энэ одоо бид нарын бүх хийгдэх объектуудыг 100 хувь санхүүжүүлэх ийм эх үүсвэр одоо биш. Энэ бол нийт одоо 18 аймгийн 267 сумын одоо 853 объектуудыг хийхэд одоогийн байдлаар урьдчилсан байдлаар бол бол 160 орчим тэрбум төгрөгийн санхүүжилт шаардлагатай гэсэн ийм тооцоо гарч байгаа.

Би яагаад энийг ингэж хэлж байгаа юм бэ гэхээр та бүхэнд 3 харьцуулалтууд үзүүлж гэж бодож байна. Одоогийн байдлаар ингээд Архангай аймгийн Хайрхан сумын дотуур байрны ариун цэврийн байгууламжийг одоо байгуулах тийм төсөвийг та бүхэн харж байгаа байх. Энэ дээр гадна бохир 63 сая, гадна цэвэр усны байгууламж 46 сая, дотор ариун цэврийн өрөө 40 сая, тоног төхөөрөмж нь 116 сая гээд яг одоо Архангай аймгийн Хайрхан сумын дотуур байран дээр бол 267 сая төгрөгийн төсөвт өртөг одоо гарсан. Баян-Өлгий аймгийн Булган сумын одоо сургуулийн ариун цэврийн байгууламжийн төсөвт өртөг нь 341 сая, Хэнтий аймгийн Батноров сумын хүүхдийн цэцэрлэгийн ариун цэврийн байгууламжийн төсөвт өртөг нь 104 сая гэсэн одоо ийм 3 янзын төсөв гарч байгаа юм. Яагаад ингээд төсвүүд их өөр өөр болж байна вэ гэхээр энэ өөрөө их тийм онцлогтой одоо төсөл арга хэмжээ юм байна. Бараг үндсэндээ бол одоо барилга барихад шаардагддаг бүх одоо инженерийн ажлууд энэ төсөлд хийгдэж байгаа юм.

Барилгын ажил байна, цэвэр бохир усны асуудал байна, сантехникийн асуудал байна, цахилгааны асуудал байна, инженерийн байгууламжийн асуудлууд байна.

Тэгээд үндсэндээ бол бид нарын одоо нөгөө 1, 2 дугаар ээлж дээр одоо удаан явж байгаа гол асуудлууд бол анх одоо тухайн сум дээр хийгдэх объектуудын сонголтын асуудлууд, хөрсний асуудлууд, тэгээд нөгөө яг ариун цэврийн байгууламжийг дотор нь хийхэд одоо тухайн сум орон нутгаас санал болгосон байрнуудын асуудлууд зарим нь актлагдчихсан байр хүртэл өгчихсөн байгаа шүү дээ. Тэгээд энэнээс шалтгаалаад бол маш их олон хүндрэлүүд гарсан маш их олон хүндрэлүүд.

Тийм учраас бол одоо зовлон тоочих бол бид нарт тийм эрх байхгүй.

Энэ ажлыг бол хамгийн чанартай одоо гүйцэтгэх ёстой. Тэгэхээр ерөнхийдөө бид нарын одоо тооцоогоор бол энэ дунджаар ерөнхийдөө 1 сум дээр хийгдэх энэ ариун цэврийн байгууламжийн одоо төсөвт өртөг бол 160-аас 180 сая төгрөг байх юм байна гэсэн дундаж тооцоо гарч байгаа юм. 160-аас 180 сая төгрөг.

Тийм учраас би өнөөдөр энэ 3 сум дээр хийгдсэн ажлуудын одоо төсвийг харьцуулж та бүхэнд ингээд харуулж байгаа юм. Тэгэхээр одоо Эрдэнэт үйлдвэрээс санхүүжүүлж байгаа 100 тэрбум төгрөгөөр бид нар бол нийт нэг 600 гаруй одоо объектын ажлыг санхүүжүүлэх ийм л хэмжээний санхүүжилт байна.

Тийм учраас бид нар энэ жил ямар ч байсан энэ 10 сарын 1-нээс өмнө бол нөгөө 850 гаруй одоо объектуудаас нэг 600 гаруй объектуудыг бол Эрдэнэт үйлдвэрийн 100 тэрбум төгрөгөөр одоо санхүүжүүлээд хийж дуусгана.

Ингээд цаанаа бол 250-260 объект дээр нэмэлт санхүүжилт шаардлагатай байгаа. Энэ бол мэдээж тухайн одоо нарийвчилсан зургууд өнөөдөр гарч дуусаагүй учраас бол бид нар яг эцсийн тоо бол илэрхийлэхэд хэцүү. Ямар ч байсан нэмэгдэл 50-аас 60 тэрбум төгрөгийн санхүүжилт байхад бид нар Монгол Улсын хэмжээнд нийт одоо анхны төлөвлөж байсан бүх сургууль, цэцэрлэг, дотуур байрныхаа нүхэн жорлонг одоо халчих ийм ажлыг одоо зохион байгуулах ийм бүрэн боломжтой гэж харж байгаа. Ингээд энэ хүрээнд бол манай Байнгын хороо одоо бол маш их тийм бодлогын дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа.

Энэ дээр одоо би Баярсайхан гишүүнд бас талархал илэрхийлэх ёстой. Баярсайхан гишүүн 2023 оны 5 сарын 4-ний өдөр одоо техникийн зөвлөлдөх уулзалтуудыг хийсэн. Ингээд техникийн зөвлөлдөх уулзалт дээр гүйцэтгэгч байгууллага, хяналт тавьж байгаа байгууллагууд, технологийн шийдлийн

асуудлууд, ашиглагч байгууллагуудаас одоо үүсэж болох асуудлуудыг бид нар ингээд ерөнхийд нь ярьсан.

Тэгэхээр гүйцэтгэгч байгууллагуудын зүгээс одоо ямар ямар асуудлууд үүсэж байна вэ гэж.

Нэгдүгээрт нь алслагдсан сумдуудад бараа материал тээвэрлэхэд тээвэр ложистикийн хүндрэлтэй байдал үүссэн. Ковид бас нөлөөлсөн.

Хоёрт нь төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоо хамтран ажиллах байдал бол маш хангалтгүй байсан. Орон нутгийн удирдлагууд, аймгийн удирдлагууд ингээд одоо гүйцэтгэгч байгууллагууд. Энэ захиалагч байгууллагууд хяналт тавьж байгаа байгууллагуудын ажлын уялдаа бол хангалтгүй байсан гэдэг. Бид нар хүлээн зөвшөөрөх ёстой.

Гуравдугаарт нь бол зургийн даалгавар бодит байдалтай маш зөрөөтэй байсан.

Анх тендер зарлахад 4 дүгээрт нь бол яг тодорхой зарим төсөл арга хэмжээнүүдийн давхцалууд үүссэн. Одоо зарим сум бол манайх одоо өөрөө сумынхаа дэд бүтцүүдийн ажлуудыг эхэлсэн байгаа гэсэн нэрийдлээр одоо зарим ажлуудыг зогсоосон.

Зарим нь бол нөгөө ЭМЯ-ны чиглэлээр одоо хийгдэж байгаа тухайн яг суман дээр одоо хийгдэж байгаа тэр эмнэлгийн ариун цэврийн байгууламжтай одоо бас энэ ажлуудыг зохицуулах давхцал үүсгэхгүй байх талаар одоо сум орон нутгийн удирдлагуудын хэлж байсан саналуудыг бид нар бас харгаж байж үзэж одоо тодорхой өөрчлөлтүүдийг хийх ийм хэрэгцээ шаардлагууд бас үүссэн байгаа.

Хөрсний одоо хүндрэлтэй нөхцөлүүдэд одоо ажил гүйцэтгэхэд бол

маш их том ажлууд юунууд эрсдэлүүд, сорилтууд бид нарын өмнө тулгамдсан. Манай одоо аймаг дотроо сум бүхэн хүртэл өөр өөр хөрстэй цэвдэгшилтэй байдаг учраас бол энэ дээр бол маш том одоо эрсдэлүүд энэ барилгын ажлыг гүйцэтгэхэд эрсдэлүүд үүссэн. Бид нарын сонгож авсан технологи маань өөрөө хөрсөнд шингэдэг дал хүртэл 70-аас 80 хувь нь одоо хөрсөнд нөгөө саарал ус нь хөрсөнд шингэдэг ийм технологи сонгочихсон байхад нөгөө энэ технологиор хийгдсэн сумдууд дээр одоо цэвдгүүд үүссэн учраас цаашаага одоо ингээд энэ саарал ус нь шингэхгүй байх ийм хүндрэлүүд үүсэж одоо 7, 8 сум дээр бол тэр саарал усыг одоо зөөхөөс өөр аргагүй буюу тухайн сум дээр одоо тэр нолийн машин нөгөө бохирын машин зайлшгүй шаардлагатай нөхцөл байдлууд үүсэж байгаа.

Энэнээс болоод одоо зарим хийгдсэн байгаа ариун цэврийн байгууламжуудад маань одоо ашиглагдаж чадахгүй байгаа нөхцөл байдлууд одоо үүсэж байна. Хяналт тавьж байгаа буюу одоо Барилгын хөгжлийн төвөөс одоо ажлын зураггүйгээр угсралтын ажил эхлүүлснээс үүдэж зураг төсөвт өөрчлөлт оруулах байдлаар одоо маш их олон хүндрэлүүд үүссэн. Энэ зүйлийг бид нар техникийн зөвлөгөөний үеэр одоо ярилцаж ойлголцсон байж байгаа.

Технологийн шийдлийн хувьд бол бага оврын цэвэрлэх байгууламж буюу экулос төхөөрөмжийг нэгдсэн байдлаар төлөвлөсөн буюу одоо төлөвлөсөн нь бүс орон нутгийн онцлог нөхцөл байдалд одоо тохируулахад хүндрэл одоо үүссэн. Ерөөсөө нэг компанийн нэг технологийг нь сонгоод бүгдэд нь гэрээ хийгээд эхний 1, 2 дугаар ээлжид бол 330 одоо юуг зөвхөн нэгхэн технологиор хийх нэг ийм давуу эрх олгогдчихсон байсан. Энэ бол буруу шийдэл байсан гэж бодож байгаа.

Тэгэхээр энэ дээр бид нар нөгөө зураг төслүүдийг нь хийгээд зарим одоо

шийдлүүдийг бид нар тэр цэвдэгтэй байгаа сумууд одоо худаг гарахгүй байгаа одоо сумууд дээр бид нар өөр буюу одоо тэр септик технологиудыг бас одоо оруулж ирж хийж байна. Энэ нь бол бас тодорхой төсөв мөнгөний өртгийн хувьд ч гэсэн хямд яг Монголын онцлогт тохирсон одоо бас ийм шийдлүүд байх болов уу гэж харж байгаа.

Хоёрт нь бол их олон одоо 303 сумны дээр яг адилхан нэг технологиор хийх ийм захиалга орж ирсэн учраас энэ захиалгыг нийлүүлэх дээр бол энэ нийлүүлэгч компани технологийн компани дээр бол ачаалал үүссэн. Цаг хугацаандаа энэ тоног төхөөрөмжөө нийлүүлж чадаагүй. Ийм асуудлууд үүссэн.

Дөрөвт нь бол энэ аюулгүй ажиллагааны заавар зөвлөгөөг өгсөн хэдий ч цахилгаан эрчим хүчний доголдол үүсэх, хариуцсан мэргэжилтэн байхгүйн улмаас эвдрэл доголдол гарах эрсдэлтэй байгаа. Ингээд ерөнхийдөө энэ сумуудын гол асуудал бол энэ соёл гэх юм уу одоо ингээд нэг ийм яг энд ариун цэврийн байгууламжуудыг одоо ашиглах, ашиглаж сурах энийг хариуцах энэний одоо урсгал зардлууд буюу энэ юунуудын засвар хийх энэ асуудлууд дээр бол үнэхээр одоо манайх үнэхээр сул талтай байна. Одоо сүүлдээ бүүр энэ сургуулиуд цэцэрлэгүүдэд нь ерөөсөө энэ яамыг одоо энэний урсгал зардлыг санхүүжүүлж засварыг санхүүжүүлнэ, тоног төхөөрөмжүүд нь дутуу ирсэн эвдрэлтэй хийсэн юмнуудыг сольж өг гэсэн ийм нөхцөл байдлууд үүсэж байгаа учраас ерөөсөө одоо яг энийг ашиглачихъя, энийг нэг байнгын, энэ нэг хүүхдүүдийг нэг ингээд нэг ариун цэврийн байгууламжид нь оруулаад ингээд нэг бие засуулаад ингээд нэг соёлыг түгээчихье гэсэн ийм сэтгэл дутаж байгаа. Мааш их олон асуудлууд байна.

Тэгэхээр энэ бол бас бид нарын өмнө тулгамдаж байгаа ийм сорилт гэж харж болно. Тэгээд цаашидаа бол бид нар энийг одоо тогтвортой энэ ариун цэврийн

байгууламжуудыг ашиглахад өвлийн улиралд тэр тусмаа энэний ашиглалтыг хариуцах тоног төхөөрөмжүүдийг хариуцах, байнгын цахилгаан эрчим хүчний одоо эх үүсвэрийг тогтвортойгоор одоо доголдол үүсгэхгүйгээр хангах гэх мэтчилэнгээр энэ асуудлыг бас цогцоор нь шийдвэрлэх ийм шаардлага байна гэж харж байгаа.

Ашиглагч байгууллагуудын талаас буюу сургууль, цэцэрлэг, дотуур байрны зүгээс одоо зарим сумдын хичээлийн байранд ариун цэврийн зориулалтаар өрөө гаргах боломжгүй одоо байдлууд үүссэн. Ариун цэврийн байгууламжтай боловч энэхүү төслийн хүрээнд их засвар хийх шаардлагатай байгаа тухай хүсэлт захиалгууд бас ихээр ирж байгаа.

Нөгөө өмнө Мобиком, Дэлхийн зөнгийн одоо юугаар санхүүжилтээр бас ийм ариун цэврийн байгууламжууд их олон хийгдсэн юм байна лээ. Тэгэхдээ ихэнх нь дандаа гадна хийгдсэн. Тэгээд энийгээ бид нар ашиглаад засваруудаа хийгээд явъя, энийгээ сургуультайгаа холбочихъё энэ танай төслийн хүрээнд гэсэн ийм олон одоо хүсэлт захиалгууд бас ирж байгаа.

Бага оврын цэвэрлэх байгууламжийг хариуцан ажиллах одоо мэргэжилтэй боловсон с хүчний дутагдал маш ихтэй байна. Бохир ус татан зайлуулах, цэвэр ус түгээх машин байхгүй гэж би түрүүн хэлсэн. Хөрсний онцлогоос шалтгаалж бас гүний худаг гаргах боломжгүй одоо ийм сумдууд бас гарч ирж байгаа зөврийн усаар одоо ашиглах ийм сумдууд бас гарч ирж байгаа юм. Зэрэг одоо иймэрхүү олон хэрэгжилтийн явцад барилга байгууламжийн явцад ийм одоо сорилтууд бид нарын өмнө тулгамдсан учраас энэ асуудлуудыг шийдвэрлэх шийдлүүдийг бид нар одоо тухай бүрд нь гаргаж, гүйцэтгэгч байгууллага, энэ ашиглагч байгууллага дээр бол тодорхой мэдээллүүдийг хангаж байгаа гэж та бүхэн ойлгож болно. Ингээд одоо яг нийт иргэдийн дунд үүсчихсэн байгаа энэ Эрдэнэт үйлдвэрийн



100 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж хийгдэж байгаа энэ нүхэн жорлон халах ажлууд бол хэт их өндөр өртөгтэй одоо ингээд татвар төлөгчдийн мөнгийг гарын сарвуугаар одоо урсгасан ийм хайхрамжгүй ажлууд болж дуусаж байна гэдэг нэг ийм буруу ойлголтууд бол байна. Энэ ойлголтуудыг бид нар засах ёстой.

Баярсайхан гишүүн бас Улсын Их Хурлын хэд хэдэн гишүүдтэй хамт явж яг газар дээр нь энэ гүйцэтгэлтэй холбоотой асуудал дээр бол нүдээрээ үзэж танилцсан гэж ойлгож байгаа.

2 гүйцэтгэлийн явцад бол 2 байгууллага дээр бол тэр тоног төхөөрөмжид нь одоо шатсан ажиллаагүй ийм нөхцөл байдлууд үүссэн байгаа. Энийг бид нар бол тэр гүйцэтгэгч байгууллагатай одоо холбоо барьж энэ ажлуудыг бас хийсэн.

Ингээд ерөнхийдөө дүгнээд хэлэхэд бол бид нар энэ жил ямар ч байсан энэ хичээлийн жилд багтаж одоо 100 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр бол бид нар 600 гаруй одоо объектуудын нүхэн жорлонг халж орчин үеийн цэвэрлэх байгууламжтай болгоно гэдэг дээр бол одоо бид нар зорьж ажиллаж байгаа.

Цаана нь үлдэж байгаа одоо 240 гаруй объектууд дээр бол нэмэлт санхүүжилтүүд шаардлагатай болж байгаа. Энийг бид нар маргаашийн Засгийн газрын хуралдаан дээр оруулж одоо үлдэгдэл санхүүжилтийн асуудлуудыг шийдвэрлэх ийм шийдвэрүүд гаргана гэсэн ийм төлөвлөлттэй ажиллаж байгаа гэдгийг бас та бүхэнд хэлэхийг хүсэж байна.

Тэгээд энэ дээр нөгөө ашиглалтад орсон ариун цэврийн байгууламжуудын видео одоо зурган танилцуулгууд бүх гишүүдэд хүрсэн учраас бол дэлгэрэнгүй одоо ярих шаардлагагүй гэж би үзэж байна.

**Г.Мөнхцэцэг:** Танилцуулга хийсэн Энх-Амгалан сайдад баярлалаа.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийг танилцуулъя.

Ням-Очир Боловсролын Ерөнхий газрын дарга, Алтангэрэл Боловсролын Ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газрын дарга\* Амарбаяр Боловсролын Ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн, Цэрмаа Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газрын зөвлөх инженер, Амарзаяа Боловсролын ерөнхий газрын Хөрөнгө оруулалтын хэрэгжилт зохицуулалтын газрын ахлах мэргэжилтэн. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг хуралдаанд оролцож байна.

Сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Жаргалмаа гишүүн. Жаргалмаа гишүүнээр тасаллаа.

Баярсайхан гишүүн асуултаа асууя.

**Б.Баярсайхан:** Сайдын мэдээллийг сонслоо. Надад одоо хэд хэдэн асуулт байна. Ер нь бол энэ Засгийн газар бас солигдоход төдийлөн бас бараг эхэлж амжаагүй байсан ийм одоо төсөл Энх-Амгалан сайдыг ажлаа авч байх үеэр ингэж явсан байгаа. Анхны хүмүүсийн хийсэн алдааг бол мэдэж байгаа. Гэхдээ энийг бол одоо өнөөдөр ярих нь бол зохимжгүй. Одоо бараг 3 жилийн өмнөх асуудал болох гээд байна. Тэгэхлээр энэ асуудлыг аль хэдийн шийдчихсэн. Анхны одоо ажлын хэсгийн алдаа хуучин яаманд ажиллаж байсан эрх бүхий хүмүүсийн гаргасан алдаа тэр зураггүйгээр түлхүүр гардуулах нөхцөлөөр энэ тендер зарласан энэ алдааг бид нар аль хэдийн зассан гэж хэлсэн. Тэгэхээр одоо энэ асуудлыг бол өнөөдөр ярих бол ямар ч шаардлагагүй гэж бодож байна.

Хоёрдугаарт энэ 3 ТНБД ахалж байсан энэ дэд ажлын хэсэг дээр агентлагийн даргаар ахлуулж энэ ажлын хэсгийг ингээж явж байгаа нь дэд ажлын хэсгийг энэ ажил гүйцэтгэхэд өнөөдөр хэр одоо бүтэмжтэй байгаа гэж танай яам өөрсдөө үзэж байгаа юм бэ? Би бол одоо сэтгэл ханамж бол тун дундуур байгаа. Танай дэд ажлын хэсгээс хэдэн удаа хөдөө орон нутагт ажилласан бэ? Би ингээд 4 аймгийн арваад сумаар явахад яг 7 хоногийн өмнө ингээд очоод чанаргүй хийж байгаа бүтээн байгуулалт дээр үүрэг даалгавар өгөөд явахад буцаад ирэхэд чанарыг нь сайжруулаад тавьж болоод байна. Гэтэл энэ ажлууд хий одоо чанартай, чанаргүй, чанартай, чанаргүй хийгдэж байна гэдэг энэ асуудал орон нутгаас сонгогдсон Улсын Их Хурлын гишүүдийн одоо гомдол дотор бол нэлээн яригдаж байна. Тэгэхлээр энэ ажлын хэсэг ажлаа хийж чадаж байгаа юм уу?

Энэнээс илүү үр бүтээмжтэй байх байсан гэж бодож байна.

Энэ 2023 он он гэхэд Ням-Очир дарга надад энэ ажлыг бүрэн дуусна гэж хэлсэн. Би Их хуралд бас ажлын хэсэгт хяналт тавьж байгаа. Ажлын хэсгийг ахалж байгаа хүний хувьд энэ одоо нэмэлт санхүүжилт хэрэгцээтэй шаардлагатай гэдгийг одоо дөнгөж сая сайдын амнаас сонсож байна. Тэгээд энэ одоо хэзээ ийм асуудал гарсан юм, яагаад ийм асуудал гарсан юм бэ гэдэг нь бас маш бүрхэг байна. Техникийн зөвлөгөөн хийсэн. Энэ техникийн зөвлөгөөнийг одоо хийхдээ цаашаа ямар нэгэн техникийн асуудал гаргахгүй гэдэг одоо зорилгоор энэ техникийн зөвлөгөөнийг хийсэн байгаа. Энэний энэ ажлын үр дүн нь ч гэсэн өнөөдөр одоо мэдээлэгддэггүй. Ерөнхийдөө би дэд ажлын хэсэгт яагаад сэтгэл дундуур байна гэхлээр Их Хурал дахь том ажлын хэсэгт мэдээлэл өгдөггүй ямар ч харилцаа холбоогүй.

Тэгээд энэ ажлын хэсгээс санаа тавиад энэ газар дээр нь энэ бүтээн

байгуулалттай ажиллаж байгаа асуудал өнөөдрийг хүртэл ерөөсөө байхгүй шүү Энх-Амгалан сайд аа. Тэгээд би ажлын хэсгийн дарга Ням-Очир даргад энэ НҮБ, Койкатай хамтраад энэ Вош гээд төсөл хэрэгжүүлээд байна. Бид нар ямар НҮБ-аас мөнгө авах гэж байгаа биш энэ дээр зөвлөхөөр ингээд Юнисефээ авч болдоггүй юм уу. Энэ байгууллагатай та нар уулзаад өгөөч гэсэн одоо болтол байхгүй. Би аймаг аймагт одоо 2 сарын өмнө Ням-Очир даргад би үүрэг өгсөн. Энэ ажлын хэсгийн бас нарийн бичгийн даргаар ажиллаж байгаа энэ Пүрэвсүрэн 2-т.

Аймаг аймгаар энэ бүтээн байгуулалтуудын мэдээллийг өгөөч гэсэн. Өнөөдөр дөнгөж сая одоо яг миний ширээн дээр ингээд тавьж байна. Яагаад энэ хөдөө орон нутагт байгаа хүүхдүүдийн энэ аюулгүй байх амар тайван суралцах, энэ асуудалд ийм хайнга сэтгэлгүй ийм одоо хандаа даад байгаа юм бэ гэдэг ийм бухимдал надад бол үнэхээр байна.

Тэгээд би бол намар энэ талаар асуулга тавина. Энэ зуны 3 сард одоо ямар ажлыг амжуулах гэж байгаа юм. Энэ барилгын одоо сезоны үед та нар ямар ажлыг амжуулах гэж байгаа юм? Цэрмаа инженер та энд одоо бас тодорхой хэмжээгээр өндөр цалин аваад ажиллаж байгаа. Энд таны одоо оруулж байгаа үүрэг юу байна?

**Г.Мөнхцэцэг:** Баярсайхан гишүүний асуултад Энх-Амгалан сайд эхлээд хариулъя. Тэгээд бас нэр зааж асуулт тавьсан учраас холбогдох хүмүүс нь хариулаад ингээд явъя. Энх-Амгалан сайд.

**Л.Энх-Амгалан:** Өмнөх л гарсан алдааг бид нар зассан залруулсан одоо өмнөхтэй ерөөсөө яриад байх юм байхгүй. Бид нар одоо урагшаа харж ажиллах ёстой. Энэ боловсролын салбарт жил бүр 100-аас доошгүй нүхэн жорлонтой сургууль, цэцэрлэг, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн байгууламжтай

болгох зорилт Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан. Тэгээд би ингэсэн юм.

Энэ Улсын Их Хурлын тогтоол гарахад улсын эмэгтэй гишүүдийн санаачилгаар одоо хийсэн энэ 100 тэрбум төгрөгийг 100 тэрбум төгрөгөөр одоо энэ 900 орчим объектыг хийчихнэ гэдэг энэ саналыг хаанаас өгсөн санал вэ? Хаанаас хийсэн тооцоо вэ гэдгийг би шалгуулж байгаа юм. Мэдээж Улсын Их Хурал одоо шийдвэр гаргахдаа энэ чинь тооцоотой судалгаатай шийдвэр гарч байж гарах ёстой шүү дээ. Тэгэхэд бол яг манай яамнаас одоо яг ингээд энэ 100 тэрбум төгрөгт багтаагаад энэ 900 гаруй объектуудыг хийчихнэ гэсэн энэ тооцоо судалгаанууд гараагүй юм байна лээ. Тэгэхээр энэ миний ойлгож байгаагаар бол Эрдэнэт нийгмийн хариуцлагын хүрээнд 100 орчим тэрбум төгрөгийг одоо бид нар санхүү юу гаргая. Энийгээ бол энэ нүхэн жорлонг одоо орчин үеийн ариун цэврийн байгууламж дээр одоо яах солих энэ ажил дээр санхүүжилт хийе гэсэн иймэрхүү л одоо ерөнхий ойлголцоор одоо ингэж энэ юунууд гарсан юм байна гэж шийдвэрүүд.

Тийм учраас би юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр Эрдэнэт 100 тэрбумаа 100 тэрбумаар 900 объектыг бүгдэнг нь солиорой гэсэн энэ санхүүжилтийг бид нар хийж байгаа шүү гэсэн үг биш. Энэ бол одоо энэ ажлыг эхлүүлэе энэ ажлыг хэрэгжүүлэе. Ямар ч байсан эхний ээлжид шаардлагатай байгаа энэ санхүүжилтийг одоо Эрдэнэтээс гаргая гэдэг ийм ойлголцоор энэ ажлууд эхэлсэн юм байна гэж бодож байгаа юм. Тэгэхээр би түрүүн та бүхэнд нэг тооцоо үзүүлээ шүү дээ. Нэг сум дээр энэ ариун цэврийн байгууламжийг хийхэд бодитой төсөвт өртөг нь дунджаар хэд гарч байна вэ гэж. Одоо 240 саяас 110 сая төгрөгийн хооронд хэлбэлзэж байгаа биз. 340 саяас. Тэгэхээр одоо бид нарын цаашидаа хийж байгаа энэ тооцоо судалгаа бол нэг сум дээр хийж байгаа нөгөө ажил. Тухайн сумын барилга байгууламжийн насжилт

тухайн сумын одоо хөрс хөрсний асуудлууд, усны эх үүсвэрүүдээс шалтгаалаад энэ бол 160-180 сая төгрөгөөр одоо хийгдэх ийм төсөвт өртгүүд гарч байна. Бид нар нэг зүйлийг одоо баттай хэлж байна вэ гэхээр ямар ч байсан бид нар энэ одоо өнөөдрийн байдлаар бол 40 орчим тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарчихсан байна.

Эхний 300 одоо объект дээр ингээд 10 сарын 1 гэхэд бид нар хэрэв энэ 100 тэрбум дээр төгрөг дээр одоо нэмэлт санхүүжилт гарч ирэхгүй ирэхгүй байх нөхцөл үүссэн тохиолдолд бол энэ 100 тэрбумаар бид нар 600 гаруй одоо объектуудыг хийгээд яг одоо шаардлага хангасан стандартын одоо ийм объектуудыг бид нар улсын комисст хүлээж авах ийм боломжтой, ийм төлөвлөгөөтэйгөөр л ажиллаж байна гэдгийг бас би бүүр хариуцлагатайгаар хэлье гэж бодож байна.

Тэгээд маргаашийн Засгийн газрын хуралдаан дээр орж энэний тодорхой үлдэж байгаа санхүүжилтийн асуудлууд шийдвэрлэгдэх учраас энэ дээр тодорхой шийдлүүд гарах болов уу гэсэн одоо юутай байна бодолтой байна. Юуны хувьд бол энэ дэд ажлын хэсэгт одоо ингээд нэг ийм сэтгэл дутаад байгаа зүйл бол байхгүй болов уу гэж бодож байна.

Яагаад гэвэл манай Боловсролын ерөнхий газар ингээд тусдаа агентлаг болж гарснаар бол яам жинхэнэ утгаараа одоо бодлогын газар болж байгаа. Хуучин та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа манай Баярсайхан гишүүн ТНБД байсан. Үндсэндээ яам бол зунжингаа тендер зарлаад л дуусдаг байсан шүү дээ. Тендерээ ч бүрэн зарлаж дуусаж чаддаггүй ажил 10, 11 сар руу ордог байсан.

Тийм учраас Боловсролын ерөнхий газрыг байгуулсны гол зүйл бол бодлогын хэрэгжилтийг ийг одоо хангах энэ агентлагтай болсноор бид нар маш том дэвшилүүд гарч байгаа. Өнөөдөр яам

тендерийн яам биш болсон бодлогын яам болсон. Тэгэхээр одоо ер нь бол энэ Боловсролын ерөнхий газар дээр байгаа хөрөнгө оруулалтын газрууд бол.

**Г.Мөнхцэцэг:** Энх-Амгалан сайдад нэг минут нэмж өгье, гүйцээж хариулъя.

**Л.Энх-Амгалан:** Тэгэхээр одоо хэн нэгнийг буруутгаж буруутан хайх биш одоо явж байгаа ажлуудаа цөмөөрөө яаж цаашдаа хамтраад одоо эрчимжүүлээд явах вэ л гэдэг асуудал байгаа. Яах вэ Баярсайхан гишүүний хувьд нэг над руу ч бас 2, 3 удаа хэлсэн.

Энэ 3 ТНБД-ын түвшинд байгуулсан ажлын хэсгийг одоо илүү агентлагийн нэг дарга руу шилжүүлээд ингээд яачихсан. Ингэж байгаа нь одоо ямар давуу талыг үүсгэх юм бэ? Ер нь одоо ухралт болчихсон юм биш үү гэсэн нэг ийм зүйл хэлсэн. Харин ч ухралт болоогүй одоо дэвшилт болсон гэж ойлгож байгаа. Яагаад гэвэл энэ Боловсролын ерөнхий газар чинь өөрөө хэрэгжүүлэх агентлаг. Одоо бүх шийдвэрээ өөрсдөө гаргаад явж байгаа. Гүйцэтгэх одоо удирдлага гүйцэтгэх одоо хүний нөөц нь энэ дээр байгаа учраас бол харин ч одоо илүү дэвшилт болж байгаа гэж би харж байгаа. Ингээд тэр техникийн зөвлөгөөний үеэр яригдсан энэ бүх ажлуудыг одоо бүгдийг нь бид нар энэ зөвлөмжөөр бүх байгууллагуудад одоо хангаж ажиллаж байгаа.

Тэгээд харин зүгээр яах вэ энэ гүйцэтгэж байгаа гүйцэтгэлүүдийн энэ мэдээллүүдийг яг рийл таймаар одоо ингээд бүх гишүүдэд уг нь одоо хүргэсэн дээ.

**Г.Мөнхцэцэг:** Ажлын хэсгийнхэнд асуулт тавьсан. Хэдэн номерын микрофон дээр байна. Ням-Очир дарга 7 номерын микрофон дээр байна уу? Хэдэн номерын микрофон дээр байна? Нэг номерын микрофон дээр Ням-Очир дарга хариулт өгье.

**Т.Ням-Очир:** Баярсайхан гишүүний асуултад хариулъя.

Боловсролын ерөнхий газрын дарга Ням-Очир. Бид нар яг энэ байнгын ашиглалтад хүлээж авсан 183 объектыг хүлээж авахад Боловсролын ерөнхий газрын хариуцсан инженерүүд зөвлөхүүд бол нэг бүрчлэн очиж комисст орж ажиллаж хүлээж авч байгаа. Тэгэхээр яг газар дээр нь инженерүүд технологийн шийдэл нь, барилга угсралтын ажил нь, одоо тавигдах шаардлага стандарт нь ямар байгааг бол нэг бүрчлэн хянаж байгаа. Мөн одоо 1, 2 дугаар ээлжийг одоо хэрэгжүүлэх хүрээнд бүсээр нь одоо 2022 он, 2023 онд бид нар бол газар дээр нь очиж ажиллаж байгаа. Дунджаар нэг объект дээр ашиглалтад орсон объект дээр бол хүлээж авах хүртлээ 2-3 ашиглалтад ороогүй объектууд дээр бол манай хүмүүс 18 аймаг дээр ямар ч байсан объект бүр дээр 1, 2 дугаар ээлжийнхээ хүрээнд очоод ажиллачихсан гэж ингэж ойлгож болно.

Бид 5 дугаар сарын эхний 7 хоногт Баярсайхан гишүүнээс өгсөн чиглэлийн дагуу Улсын Их Хурал дээр хариуцсан референтээрээ дамжуулаад аймаг тус бүрээр, сум тус бүрээр, объект бүрээр ажлын төлөвлөгөө цаг хугацааны графикийг бол гаргасан. Энэ гаргасан график төлөвлөгөөг пэйж хуудас болон аймгуудад бол яг нэг бүрчлэн хүргэсэн байгаа.

Тэгэхээр энэ бол 5 сарын 7-нд гарсан ийм график байгаа. Энэ графикаа бол ерөнхийдөө зарим объектууд дээр, зарим сумууд дээр бол алдагдал байгаа хэдий ч яг энэ графикаараа бол одоо гүйцэтгэгч байгууллагууд зургийн болон одоо угсралтын ажлын гүйцэтгэгч байгууллагуудаа бол нэг бүрчлэн шахаад одоо ингээд явж байгаа. Цаг хугацааны бол объект тус бүр дээр олон объект учраас тодорхой тохируулга шийдлүүд бол байгаа. Тэгээд яг гүйцэтгэл ямар байгааг бас сая сайдын илтгэлд бол нэг бүрчлэн танилцуулсан. Одоо бол

ашиглалтад орсон 183 объектын байнгын ашиглалттай байх энэ чиглэл рүү нь одоо гарын авлага материалууд гаргах зөв соёл дадал хэвшил сургах, эрүүл мэндийн хичээлийнхээ хөтөлбөртэй уялдуулах эмчийн албан тушаалын тодорхойлолтод нь бас чиг үүрэгтэй нь уялдуулах зэргээр бол энэ ажлууд хийгдэж байгаа. Энэ бол яг техникийн зөвлөлдөх уулзалтаас бол ашиглагч тал дээр бол ийм асуудлууд үүсэх нь гэдэг дээр бол нэлээдгүй ийм асуудлууд гарсан учраас бид нар бол энд анхаарах ёстой юм байна.

Цаашидаа энэ урсгал зардал энэ бүх зүйлүүд дээр бол нэлээн ийм одоо зөвлөн чиглүүлж хэвшүүлэх ажил бол хэрэгтэй юм байна гэж ингэж харсан.

Вош төслийн хувьд бол би энэ вош төсөл дээр бол 2, 3 удаагийн хуралд суусан. Манай энэ технологийн шийдэл гаргаж байгаа зарим зөвлөхүүд бас энэ вош сүлжээн дээр бол явж байгаа учраас яг энэ вош төсөл дээр анхааруулж байгаа. Ялангуяа мэргэжилтэй боловсон хүчин байж засвар үйлчилгээг байнгын хийж зөвхөн сургууль, цэцэрлэг, дотуур байр гэхгүй тэр сумын дэд бүтцийг яг энэ ариун цэврийн байгууламжтай холбоотой дэд бүтцийг харууцаж явах тал дээр бол илүү анхаарч байгаа.

Тэгээд бид нар энэ экос төхөөрөмжийг одоо суурилуулсан компанитай хамтраад ариун цэврийн байгууламж байнгын ашиглалтад орсон сумдууд дээр 1,1 хүнийг сургалтад хамруулж яг энэ экос төхөөрөмжийг ашиглах гарын авлагыг боловсруулж гаргаж сургуулийн удирдлага, багш нарт зориулсан одоо зөвлөмжийг өгч, 2 эмэгтэй 00, эрэгтэй ариун цэврийн өрөө гээд ингээд энэ бүрд нь тохирсон анимэйшнүүдийг бэлдэж бас ингэж хүргээд явж байгаа.

Бидний хувьд бол яг энэ төслүүдээ бол 11 сарын 20 гэдэг графикаар бол ерөнхийд нь бол бүх одоо зураглал тооцооллуудаа гараад явж байгаа. Гэхдээ

энэтэй холбоотой сая бас сайдын хэлсэн санхүүжилттэй холбоотой асуудлууд бас бид нарт Засгийн газар дээр хуралдаанд танилцуулж чиглэл авах зүйл байгаа гэж ингэж хэлэхийг хүсэж байна.

Баярлалаа.

**Г.Мөнхцэцэг:** Баярсайхан гишүүн. Тийм инженерээс асуулт тавьсан, Цэрмаа инженерт.

Цэрмаа инженер зөвлөх инженер байгаа. 4 дүгээр микрофон дээр Цэрмаа инженерийн микрофоныг өгье.

**Г.Цэрмаа:** Сайн байцаана уу? Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Би энэ ариун цэврийн байгууламж дээр зөвлөх инженерийн үүргээр 2022 оны 6 сараас эхэлж ажилласан. Энэ дээр ажиллаж байх хугацаанд бол эхний ээлжид 1, 2 дугаар ээлжийн ажил ерөнхийдөө газар дээрээ зураггүйгээр эхлээд тэгээд ажлаас нь зургийг нь хийж байгаа байдалтай байсан. Энэ дээр бол мэдээж инженер хүний хувьд бол одоо тэр зурган дээр гарч байгаа алдаа оноо юу байна одоо юу нь болохгүй техникийн технологийн шийдлүүд нь ямар байна гэдэг талаас л одоо байнгын зөвлөгөө өгөөд ингээд 1, 2 дугаар ээлжийг бол ямар ч байсан 12 сар гэхэд бол ерөнхийдөө магадлалын зураг нь үндсэндээ дуусаж байсан. Энэ хооронд ажил нь хийгдчихээд дараа нь зураг хийгдэж байгаа учраас зураг нь норм дүрмийн дагуу гарахад бол нэлээд зөрөөтэй зүйлүүд гарч байсан. Тэр зургийн дагуу мөн одоо буцааж газар дээр нь хийгдсэн ажлуудыг буулгах дахиж засуулах гэх мэтчилнээр одоо газар дээр нь бодит байдлаар явж үзэж одоо эд нарыг нэлээдгүй цэгцэд орууллаа. 1, 2 дугаар ээлжийн энэ одоо өнөөдрийн байдлаар 95 объект ингээд яг ашиглалтад өгөхгүй зайлигүй он дамжих хэмжээнд хүрсэн явдал нь бол үнэхээр ажлын зургийг хүлээж байсан учраас ийм процесст хүрсэн. Ажлын зургийг зөв

эхлээд зөв голдирлоороо эхэлчихсэн бол болох байлаа.

Дараад нь ер нь энэ ажлын зураггүйгээр эхэлсэн ажил ямар байдалд хүрч байна гэдэг байдлаас хөрөнгийн багцаа ч гаргах боломжгүй байсан учраас 3, 4 дүгээр ээлжийг бол одоо ерөнхийд нь, аймгуудаас нь, аймаг бүрээр нь судалгаа гаргуулаад ажлын зургийнх нь үйл ажиллагааг зохион байгуулсан.

Гуравдугаар ээлжийн энэ одоо 130 сумын энэ 303 объектой нэг бүрчлэн би тулж ажиллаж байна. Энэн дээрээс үнэхээр одоо ёстой өглөөний нарнаас орой хүртэл энэ олон зургийг зүгээр одоо нэг мэдээ гаргах төдийд биш зүгээр нэг хурлын тэмдэглэл хөтлөх төдийд биш нэг бүрчлэн техник технологийнх нь шийдэл гарч байна уу гэдгээрээ би одоо судалгаандаа яваад ирсэн аймгийн гүйцэтгэгч нартай нэг бүрчлэн уулзаад тэд нарын гаргасан шийдэл яг газар дээрээ очоод үнэхээр бодитоор байна уу, үгүй юү гэдгийг яг тухайн цэцэрлэгийн эрхлэгч, сургуулийн захирал нартай нэг бүрчлэн газар дээр нь утасдаж асууда. 3, 4 дүгээр ээлжийг бас тодорхой хэмжээгээр алдаа оноонд оруулчихгүйн тулд мөн эд нартай зөвшилцөөд ерөнхийдөө техник, технологийн шийдэл зөв гарсны үндсэн дээрээс аймгуудын газрын харилцаа хот байгуулалтын газрын тухайн одоо зургийг зөвшилцөх мэргэжилтнүүдтэй хэлтсийн дарга нартай бас нэг бүрчлэн тулж энэ хийж байгаа зургуудыг би Барилгын хөгжлийн төвд хамааруулахгүйгээр одоо эхний урьдчилсан шийдлийг объект нэг бүрээр нь 303 объект, нэг бүрээр нэг бүрчлэн хүнтэй тулж ажиллаж шийдлүүдийг гаргадаг.

Одоо бохир нь зөв юм уу? Өнөөдөр орой тэр байгаа хуучин зуурмагийг буулгах нь зөв юм уу? Эдийн засгийн үр ашиг нь ямар байгаа юм? Өнөөдөр сонгож байгаа одоо тэр септик нь ямар юм зөв юм уу? Экологийг тавивал энэ сумд ямар байх нь вэ? Тог нь яаж тасардаг

юм? Хэрвээ тэгвэл ашиглалтын явцад яаж хүндрэл гарах нь вэ? Болж өгвөл одоо тэнд энд сумууд одоо яг мэргэжлийн сантехникийн чиглэлийн хүмүүс байдаггүй учраас тухайн сумд энэ техник технологийг бодит байдал дээр нутагшил суурьшилд нь яаж ажил тохируулбал ямар байх нь вэ, ашиглалт нь ямар байна гэдгийг нэг бүрчлэн хандаж одоо энэ 3 дугаар ээлжийн зургийг хүлээж авч байна. Мөн одоо 4 дүгээр ээлжийг сая гаргаад ирэхэд мөн адил гарахаас нь өмнө одоо та нар ажил яаж удааширалтай байна очоод та нар ямар байдлаар судалгаагаа хийх вэ? Байг гэхэд очоод одоо нэг цооног байхад.

**Г.Мөнхицэг:** Баярсайхан гишүүнд нэмж асуулт асууж, санал хэлэх микрофоныг өгье.

**Б.Баярсайхан:** Баярлалаа. Тэгвэл өнөөдрийн Байнгын хорооны хурлаар хэд хэдэн зүйлийг маш сайн ойлголоо. Бүх одоо бүтээн байгуулалтад энэ 819 сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлон чанарын өндөр түвшинд хийгдэх юм байна гэж ойлголоо. Өөрөөр хэлбэл чанарт бол санаа зоволтгүй юм байна гэж өнөөдөр ойлголоо. Санхүүжилтийг энэ маргаашийн засгийн хурлаар оруулж одоо нийт хийгдэх ажил дээр дутагдаж байгаа санхүүжилтийг бол сайд Засгийн газарт шийдүүлнэ гэж ойлголоо. Мөн одоо энэ ажлын хэсэг бол сайн ажиллаж байна гэж ойлголоо. Тэгээд бидний ажилд бол хүүхдүүд дүн тавина.

Өнөөдөр Улаанбаатар хотын түгжрэл Улаанбаатар хотод байгаа цэцэрлэгийн хүртээмж гээд л бид нар төсөвт тодотгол хийж байгаад шийдсэн. Тэгвэл Улаанбаатар руу хүүхдүүдийг нүүлгэхгүй энд одоо түгжрэлийг сааруулж энэ цэцэрлэг, сургуулийн хүртээмжийг сайжруулах.

**Г.Мөнхицэг:** Баярсайхан гишүүний микрофоныг өгье. Ажлын хэсгийн ахлагч.

**Б.Баярсайхан:** Тэгж бодож байгаа бол энэ одоо хөдөө орон нутагт байгаа хүүхдүүдийн тохь тухтай аюулгүй амьдрах энэ асуудлыг л шийдэх ёстой. Чанартай бүтээн байгуулалт бий болсон сумд бол сумын хүүхдүүд бол маш их баяртай байна. Үнэхээр одоо их бахархалтай суманд төвд гэртээ айлуудын хүүхдүүд хүртэл бид нар дотуур байранд амьдаръя гэсэн ийм хүсэлтийг ээж аавдаа тавьж байна. Чанаргүй байгаа газар бол үнэхээр хэцүү байна. Тэгээд Энх-Амгалан сайд зарим одоо нолио сольчихсон сумд дулаарахаар гадаа нольдоо бие зас гэдэг юм уу эсвэл дотуур байрны одоо багш үйлчлэгчдийн зөвхөн шөнө бие зас өдөр бол бие засаж болохгүй гэдэг иймэрхүү асуудлууд бол нэлээн гарч байгаа гэдэг нь сая намайг хөдөө орон нутагт явж байхад бол харагдаж байсан юм. Энд надтай хамт явсан Амарзаяа инженер бас сууж байна. Бүх асуудлыг бол сонссон байгаа.

Тэгэхлээр би бол одоо энэ энэ зун бол нэлээн одоо шахуу энэ жорлонг солих бүтээн байгуулалт бол хийгдэх юм байна гэж ойлголоо. Тэгээд өнөөдөр сошиалаар Солонгосын Од одоо жүжигчин ирэхэд түүний бие засах газарт их санаа тавьж улсаараа их санаа зовоод байх шиг байна. Уул нь улсаараа ялангуяа энэ ажил хариуцсан хүмүүс нь хөдөө орон нутагт хүйтэн мөсөн дээр бие засаж байгаа энэ хүүхдүүдийн асуудал, энэ сургуулийн орчны аюулгүй байдлын асуудал, модон жорлонд хүүхдүүд унаж амь насаа алдаж байгаа энэ асуудал энэ хөдөө орон нутаг, дотуур байр, сургуулийн орчин тохь тухгүй байгаа учраас малчид 6 настай хүүхдээ аваад сум дээр амьдардаг.

Малчин аав нь хөдөө амьдардаг. Үүнээс болоод гэр бүл салалт өндөр байгаа энэ асуудал олон олон олон олон асуудал та бүхний хийж байгаа энэ бүтээн байгуулалтыг ямар байхаас шийдвэрлэгдэх гээд байгаа юм гэдгийг бол бүүр хариуцлагатайгаар хэлье.

Тэгээд энэ ажил бол МАН-ын мөрийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан. Ийм одоо сүүлийн 100 жилд хамгийн том бүтээн байгуулалт болох ийм ажил байгаа. Тэгээд энэ жил 4 аймаг 100 жилээ тэмдэглэж байгаа. Ядаж одоо эхний ээлжид та бүхэн энэ 100 жил тэмдэглэж байгаа 4 аймгийг модон жорлонгоос нь одоо салгаж чадах юм бол бас 100 жилээ тэмдэглэж байгаа нэг баяр хөөр, бүтээн байгуулалт амжилт юм даа гэж одоо ингэж харж байна. Тэгээд ажлын хэсгийг илүү одоо их сэтгэлтэй суман дээр хийгдэж байгаа сум болгон дээр хийгдэж байгаа энэ ажлыг үнэхээр чанартай хийж гүйцэтгэх тал дээр одоо сайн ажиллаарай гэж бас өнөөдөр албан ёсоор хэлж байна. Та бүхний одоо энэ дурдаад байгаа муу байшин өгч байгаа, сум орон нутгийнх нь хүмүүс сэтгэлгүй анхны тэр одоо нэг алдаатай байсан энэ асуудлуудыг бол үнэхээр одоо сонсохыг хүсэхгүй байна. Яагаад гэвэл та нар энэ ажлыг чадна гээд хариуцаж аваад хийж байгаа бол тэгээд л хийгээд л дуусгамаар байна.

Тэгэхээс биш одоо тэр нэг ТНБД танай Хөрөнгө оруулалтын газрын даргын ажиллаж байсан 2 хүний асуудлыг одоо 3 жил яриад яах вэ дээ. Та нар тэрийг л чадна гээд л ажлын хэсгээ өөрчлөөд орж ирсэн биз дээ тэ. Тэгэхлээр энэ зун бол энэ орон нутгуудаар бас явъя гэж бодож байна. Бусад аймгуудаар бас явъя гэж бодож байна. Тэгээд ажлын хэсэг бас энэ дээр энэ Их Хурал дахь ажлын хэсэгтэйгээ хамтраад бас ажиллана гэж бодож байна. Баярлалаа.

**Г.Мөнхицэг:** Жаргалмаа гишүүн асуултаа асууя.

**Б.Жаргалмаа:** Өдрийн мэнд би бас энэ ажлын хэсэгт орж ажилласан гишүүний хувиар бас хэд хэдэн зүйлийг асууя. Үнэхээр одоо парламентад сууж байгаа эмэгтэйчүүд Эрдэнэт үйлдвэрийн нийгмийн хариуцлагын хүрээнд хүлээсэн үүрэг дээр тулгуурлан хөдөө орон нутгийн ЕБС, дотуур байрны нүхэн жорлон орчин

үеийн ариун цэврийн байгууламжаар солих энэ төсөл эхэлсэн байгаа. 2021 оны 1 сарын 20-нд яг энэ үйл ажиллагаа ерөнхийдөө одоо ажиллаж эхэлсэн гэж би ойлгож байгаа. Өмнө нь бид нар бас ажлын хэсгийн хүрээнд ямар технологи байх вэ? Байгаль цаг уурын өөрчлөлтөөс шалтгаалан орон нутгийн өөрчлөлтөөс үүдэн технологи бүр өөр байх юм байна. Төсөл хөтөлбөрүүд нь үнийн дүн төсөвт зарцуулалт нь хүртэл өөр байх юм байна гэдэг олон ажлыг маш олон судалгаан дээр үндэслэж ярьж байсан.

Гэтэл өнөөдөр энэ нэгэнт технологиор нэг компанид давуу эрх олгосон гэдэг бол бас энэ цаагуураа ер нь ямар асуудал үүссэн юм бэ гэдгийг бас эргээж харах зайлиггүй шаардлагатай гэж би бодож байна. Ер нь энэ бол хариуцлагын асуудал. Бид нар бас өмнө нь бас хөдөө орон нутгаар явж энэ нүхэн жорлонгийн асуудлыг хэрхэн яаж шийдэж байна вэ ажил ямар шатад явж байна вэ гэдэг зүйлийг бас судлах тэр явцад юу харагдаж байсан бэ гэх юм бол сая инженер өөрөө хэлж байна л даа. Газар дээрээ зураггүй ажил эхэлсэн. Зураггүй барилгын ажил эхэлнэ гэдэг бол эргээд төсөвт өртөгт өөрчлөлт орох, төсөв үрэлгэн зарцуулагдах гээгдэх энэ асуудал бол хийгдсэн. Зүгээр л нэг жишээн дээр шугам хоолойны одоо хэмжээсээ буруу тавьснаас шалтгаалан 700-аас 800 метрийн зөрөө гарсан. Энэ төсөвт өртгийг хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдэг асуудал хүртэл үүсэж байсан. Энэ мэт хариуцлагагүй асуудал яг энэ төрийн аливаа үйл ажиллагаан дээр бас байгаад байгаа нь харагдаад байгаа. Ажлын хэсэг уг нь 3 яамны ТНБД нар хамтарч ажиллаж эхлээд яг хэн хариуцах вэ гэдэг дээр бас ажлын хэсгийн гишүүд бас асуудал тавьж байсан. 3 яамны дунд орхигдчих вий дээ гэдэг зүйлийг бид нар бас маш ихээр ярьж байсан. Яг л тэр одоо анхааруулга тэр жишгээр бол энэ ажил ингээд удааширсан.

Хэдийгээр Эрдэнэт үйлдвэр төрийн нийгмийн хариуцлагын хүрээнд

гэж 100 тэрбумыг өгч байгаа боловч энэ бол төрийн мөнгө, татвар төлөгчдийн мөнгө. Бид үргүй зарцуулах ёсгүй. Ямарваа нэгэн байдлаар хариуцлага алдсан зураг төсөв буруу хийсэн энэ компаниудад гэдэг юм уу тэр одоо төсөв захиран зарцуулж байгаа орон нутгийн удирдлагуудад тэр сургуулийн захирлуудад би хариуцлагын асуудал яримаар байна. Эргээж төлөвлөх асуудлыг яримаар байна. Гүйцэтгэл дээр бид нар хяналт тавих ёстой. Энэ бол өнөөдрийг хүртэл 600-аас мянган хүүхэд сурч байгаа нэг сумын сургуулийн хүүхдүүд дөрөвхөн нүхэн жорлон дээжлээд бие засдаг гэдэг ийм байж боломгүй жишээ хүртэл байсаар байсан. Энийг л бид нар халах гэж уг нь оролдсон.

Бид ирээдүйгээ эрүүл аюулгүй орчинд сурч хүмүүжүүлэхээс гадна эрүүл Монгол иргэнийг бий болгохын тулд энэ нүхэн жорлонгийн асуудлыг хөндөж тавьсан гэдгийг хүн болгон мэдэж байгаа. Би хариуцлагын асуудлыг нэхмээр байна. Өөрөөр хэлэх юм бол гүйцэтгэгч компаниуд дээр одоо зарцуулагдсан төсөв дээр хариуцлага тооцож эргэн төлүүлэх гэдэг юм уу эсвэл гүйцээх энэ асуудлыг одоо хийж өгөөч сайдаа. Үнэхээр төсөв одоо 35 тэрбум нь гараад үлдсэн тэрбум нь 900 одоо объектыг бид нар барьж байгуулж чадахгүй гэж бодож байгаа бол ер нь байгаа төсөвтэй яг одоо бид нар энэ удаагийн барилгын улиралд ер нь хэчнээнийг нь яг дуусгаж хүлээлгэж өгөх хэмжээнд байгаа юм бэ? Нарийн тоог бас бидэнд өгөөч. Эргээд олон нийт бас биднээс хариуцлага нэхэж байгаа. Ер нь бол энэ эхлүүлсэн ажил дээрээ өөрсдөө хариуцлагатай байна уу, үгүй юү гэдгийг бас биднээс шаардаж байгаа учраас би бас ийм 2 асуултад хариулт авахыг хүсэж байна.

**Г.Мөнхцэцэг:** Жаргалмаа гишүүний асуултад Энх-Амгалан сайд хариулт өгье.

**Л.Энх-Амгалан:** Зөв өө зөв Жаргалмаа гишүүн ээ. Одоо хариуцлагын



асуудлыг бид нар үнэхээр дээр доороо ярих одоо цаг нь болсон болсон. Одоо алийн болгон бие биеийнхээ толгойг илж амьдрах вэ. Тэгээд яах вэ гэхдээ би хэлээд байна шүү дээ. Түрүүн Баярсайхан гишүүнд ч гэсэн хэллээ. Одоо зовлон тоочиж амьдрахгүй. Тийм жаахан урагшаа харж амьдаръя гэлээ. Гэхдээ урагшаа харж амьдарна гэдэг нь өнгөрсөн хугацааныхаа одоо ингээд хариуцлага алдсан юмнуудыг ингээд үлдээгээд ингээд явчихна гэсэн үг биш л дээ. Зохион байгуулсан хүмүүсийн одоо амжилтгүй юу гэдэг юм бэлтгэл муутай зураг төсөлгүй одоо ингээд энийг тендерийг зохион байгуулсан хүмүүстээ хариуцлага тооцох ёстой. Би энэ дээр дандаа санал нэг байна.

Хоёрдугаар асуудал бол энэ захиалагчийн одоо буруу хариуцлагагүй байдлаас үүдсэн гүйцэтгэгч дээр одоо очиж байгаа гүйцэтгэлийн явцад гарсан алдаа дутагдлууд байх юм бол энийг бид нар хүссэн хүсээгүй хариуцлага тооцох ёстой энэ хэдийгээр Эрдэнэтийн мөнгө гэж эд нар ярьж байгаа боловч би Монголын татвар төлөгчдийн мөнгө л гэж ойлгож байгаа. Тийм учраас бол энэ дээр одоо хариуцлага тооцох, ер нь хариуцлага тооцоход нэг цаг хугацааны хувьд бол оройтоогүй болов уу л гэж бодож байна. Тэгээд одоо Баярсайхан гишүүний хэд дахин хэлээд байгаа та нар одоо хийнэ гээд л авсан юм бол хийсэн шиг хий л гэж хэлж байгаатай би санал нэг байна.

Харин хариуцлагатай хэлчихье. Одоо ингээд энэ 100 тэрбум төгрөгт бид нар 600 орчим объектуудыг бол яг чанарын шаардлага хангасан хэмжээнд бид нар гүйцэтгээд хүлээлгэж өгнө. Гэхдээ энэ нэг зүйлийг хэлэхэд бол одоо энийг цаашаа ашиглаад явах энэ байгууллагуудын идэвх санаачилга сэтгэл маш их хэрэгтэй байна. Энэ бол сэтгэлгээний маш их том өөрчлөлт гарч байгаа байхгүй юу. Энэ чинь соёлын маш том хувьсгал яваад байгаа юм. Тиймээ ганц нэг дотуур байр сургуулиудын

жорлонг нүхэн жорлонг ариун цэврийн байгууламжтай болгож байгаа биш энэний цаана өөрөө энэ хүүхдүүдийн эрх, хүүхдүүдийн энэ хот хөдөөгийн сургуулиудын ялгааг арилгах чиглэл рүү энэ бол маш том дэвшил болж байгаа юм. Маш том дэвшил болж байгаа юм.

Тэгэхээр энэ чиглэл рүү одоо бид нар ингээд сэтгэлгээнийхээ хандлагуудыг одоо өөрчлөх ийм асуудал байна. Тэгэхгүй бол одоо ингээд хүнд лаахайдаад ингээд аятайхан маш сайхан ийм ариун цэврийн байгууламж хийж өгчхөөд байхад тэрийгээ цоожилчихоод хүүхдээ оруулахгүй байгаа тэр сургуулиудын удирдлагуудтай бид нар одоо яах вэ тийм гэх мэтчилнээр ингээд одоо яг ингээд бүх оролцогч байгууллага, одоо ашиглагч байгууллага цаашидаа ингээд энэ сургуулиудыг хөдөө орон нутгийн сургуулиудын удирдлагуудын хариуцлага, сэтгэлгээний асуудал дээр бол одоо бид нар хамтарч байж л энэ сэтгэлгээг өөрчлөхгүй бол нэлээн одоо хүндрэлүүд бас үүсэж байна.

Тэгээд яг ингээд ажил хийхэд бас зовлонгууд бас их байна. Бас яг газар дээр очоод ингээд ажиллаж байгаа энэ гүйцэтгэгч компаниуд сум орон нутгийн удирдлагууд сургуулийн удирдлагуудаас болж байгаа гүйцэтгэлийн одоо чанар энэнээс шалтгаалж байгаа олон зүйлүүд байгаа учраас одоо ингээд тал талдаа л одоо ингээд хичээж ажиллахаас өөр одоо аргагүй л гэж бодож байна. Энд нэг зүйлийг хэлэхэд бол бид нар бол маш том одоо туршилага хуримтлуулж байна. Ер нь бол Монгол Улс яг ингээд анх удаа бараг үндсэндээ 330 сумынхаа хүрээнд 267 сум гэж байгаа. Энэ хүрээндээ ингэж ийм хэдийгээр ажлын обьём багатай ч гэсэн барилгын бүх ажлууд орсон. Барилга угсралтын ажил орсон, их засвар орсон, инженер техникийн ажлууд орсон. Худаг усны одоо усны эх үүсвэрүүд шийдвэрлэсэн. Хөрсний судалгаануудын инженерүүдийн ажлууд хийж байгаа анхны тохиолдол байхгүй юу? Зэрэг хийж байгаа анхны тохиолдол? Тэгэхээр энэ

бүхэн дээр одоо ингээд сум бүхнээс шалтгаалж байгаа объект бүхнээс шалтгаалж байгаа асуудал байгаа учраас хаа хаанаа одоо хүлээцтэй одоо хандах л ийм л зүйл байгаа болов уу гэж бодож байна. Тэгээд өнөөдөр Монголын бүх хүүхдүүд тэр тусмаа хөдөө орон нутагт амьдарч байгаа бүх хүүхдүүдэд бид нар нэг аятайхан нэг ийм хотоос хотын хүүхдүүдээс дутахгүй ийм ариун цэврийн байгууламжид одоо ингээд болох энэ чиглэл рүү л цөмөөрөө байгаа хүч бололцоогоо бүгдэнг нь л дайчилж одоо ажиллаад байна гэж бодож байна.

Тэгээд эцэст нь хэлэхэд одоо хариуцлага хүлээхэд би бэлэн. Ямар ч байсан.

**Г.Мөнхцэцэг:** Жаргалмаа гишүүн нэмж тодруулъя. Чинзориг гишүүний нэрийг оруулчхаарай.

**Б.Жаргалмаа:** Баярлалаа. Үнэхээр одоо хариуцлагын асуудлыг бид нар одоо авч чаддаггүйгээс шалтгаалан бидний ийм хариуцлагагүй байх тийм төсвийн мөнгийг үргэн үрэлгэн зарцуулах, идэж уух, шамшигдуулах, тендерт будилаан үүсгэх энэ асуудал байсаар байгаа. Би улсын төсөв дээр бас тодорхой хэмжээнд улсын хөгжлийг хараач гэдэг зүйлийг байнга ярьдаг. Тэр ч үүднээсээ төсөвт Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт ороод ажиллаж байгаа. Бид аливаа асуудлыг нэг гүйцээгүйгээр дандаа нэг дутуу төсөв царцаасан ийм байдалтайгаар одоо төсвийг тавьдаг нь бас алдаа. Та сая хэллээ нолио одоо тийм хүлээлгэн өгчихсөн байтал түгжээд байдаг асуудал. Энэ нөгөө л технологийн асуудал бол болов уу гэж би харж байна л даа. Өөрөөр хэлэх юм бол дахин боловсруулах соруулах. Одоо ийм технологитой баригдсан сургууль дээр нөгөө дараагийн ашиглалтын зардал нь төсөвт нь байхгүй учраас сургууль нь түүнийгээ ашиглаж чадахгүй. Ийм алдаанууд гараад байдаг.

Ер нь 2024 оны төсөвтөө яг энэ зарцуулалтаа бид нар үнэхээр тусгаж чадах уу? Өөрөөр хэлэх юм бол бид нар байгуулсан ариун цэврийн байгууламж нолийн асуудлаа бүрэн ашиглах хүүхдүүд.../минут дуусав/.

**Г.Мөнхцэцэг:** Жаргалмаа гишүүн төсөвтэй холбоотойгоор саналууд ерөнхийдөө хэлчихлээ. Засгийн газрын хуралдаанд одоо энэ асуудлуудаа бас бид нар авч орох гэж байгаа гээд сайд бас нэмэлт хариулт өгсөн учраас маргаашийн хуралдаанд тийм учраас бол энэ асуудал Байнгын хорооны гэхээсээ илүүгээр Засгийн газрын хуралдаанаар одоо шийдэгдээд ингээд явах юм байна гэж ингэж ойлгож байна.

Чинзориг гишүүн асуултаа асууя.

**С.Чинзориг:** Энэ Энх-Амгалан сайд бас хүлээцтэй хандах ёстой тэвчээртэй хандах ёстой л гээд байгаа юм. Бас тэвчээрт хязгаар бий л дээ зовлонтой л байх юм. Энэ бас зовлонг нь бол бид нар бол сайн ойлгож байгаа. Барилгууд чинь бол зураг, төсөв нь өөр, стандарт нь өөр, яг стандартын зориулалт барилга байхгүй ядаж л нөгөө цэвэр бохирын шугам байхгүй энэ тэр гээд л асар их одоо асуудалтай. Гэхдээ бас тэвчээр хүлээлтэд бас хязгаар байна.

Манай Өвөрхангай аймгийн 4 сумын асуудал 2021 онд л эхэлсэн юм. Анхны 1 дүгээр ээлжид нь орсон юм. Тэгээд одоогоор орсон юм байхгүй нүхэн жорлонгоосоо салаад тэр боловсон 0-той болох нь битгий хэл тэр нэг гадаа нь очоод үзэхлээр нэг жоохон шороо тарваганы нүх ухсан юм шиг жоохон шороо ухаад тэгээд хаячихсан одоо 2 жил болж байгаа юм. Баян-Өндөр, Бүрд, Зүйл гээд сумдууд зүүн талын сумдууд. Тэгээд одоо энийг хэзээ орох юм бэ? Одоо энэ чинь 2 жил одоо бараг л ч 3 дахь жил рүүгээ орлоо шүү дээ. Тэгээд Өвөрхангай аймагт бол орсон юм байхгүй. Энэ нөгөө хөтөлбөрийн хүрээнд сургууль дотуур байр боловсон 0-той болсон юм байхгүй.

Эхний ээлжид орсон 2, 3 сум нь одоогоор ороогүй 2 жил одоо 3 дахь жилийнхээ нүүрийг үзэж байна. Бүрд, Зүйл гээд та нар мэддэг л байлгүй дээ. Тэнд толгой сэгсрээд л байх юм. Байхгүй гэж байгаа юм болов уу? Байгаа л даа. Би саяхан очоод ирсэн ноднин очиход жоохон тарваганы нүхний дайны ч биш нэг жоохон өнгөцхөн шороо ухаад л хаячихсан. Яасан юм гэхлээр нөгөө нүхэн жорлон боловсон жорлон болгох гэж байгаа асуудал ингээд болохоо байчихсан гээд л ажилладаггүй. Нэг дэх асуудал.

Ингээд явц их удаан байгаа юм. Зарим аймгууд нь болохлоор ингээд ороод байгаа бололтой яваад байгаа юм шиг юм яриад байх юм.

Хоёрдугаарт энэ хуваарь хийхдээ Энх-Амгалан сайд би ноднин ч гэсэн яриад л байсан маазраад л дэмий яриад л. Жорлон ч байсан дээгүүрээ хуваагаад авчих юм гээд л дэмий яриад л байсан юм. Аймгуудад яагаад ингээд тэгш бус хандаад байгаа юм бэ? Энэ 21 аймгийг чинь одоо ижил тэгш хандаад сумынх нь тоогоор нь жигд аваад явчхаж болдоггүй юм уу? Зарим одоо аймгууд нь бараг л 100 хувь ороод дуусаж байна шүү дээ. Гэтэл одоо Өвөрхангай аймаг хөдөөгийн 18 сумтай. Одоо энэ материалыг чинь харахлаар Өвөрхангай аймгийн 10 сум нь 4 дүгээр ээлжид орно гээд хавьцаа тавьсан байгаа байхгүй юу. Тэгээд 4 дүгээр ээлжийн чинь мөнгө нь байхгүй гээд ингээд. Тэгээд та нарын одоо энэ хүүхдүүдэд нөгөө тэгш боломж олгоё, сурах хөгжих тэгш боломжийг нь олгоё гэдэг чинь одоо ингээд тэгээд аймгуудаас нь хамаараад одоо ялгамжтай хандаад эд нар байдаг өөрсдөө та нар шийдвэр гаргадаг улсууд ингээд хүүхдүүдэд тэгш бус хандаад байдаг асуудал чинь одоо юунаас үүдэлтэй юм? Яагаад одоо ингэдэг юм ярихгүй яваад байхлаар нь ингэдэг юм уу? Юм яриад хэрүүл хийгээд байвал дэмжээд байдаг юм уу? Ингэж болохгүй шүү дээ. Энэ одоо хувиараа одоо өөрчлөх боломж байдаг юм уу? Тэгээд одоо наад 4 дүгээр ээлжид Өвөрхангай

аймгийн 10 сум орно гээд тавьсан байгаа юм. 10 сум чинь нийт сумдын чинь бараг 60 хувь нь байгаа байхгүй юу. Хөдөөгийн 18 сумтай аймаг. Тэгээд эхний 1, 2 эхэлнэ гэсэн нь одоогоороо ороогүй. Тэгээд үлдсэн сумдуудыг нь болохоор 4 дүгээр ээлжид тавьчихсан. 18 сумын чинь 10 сум гэдэг чинь бараг 60 хувь нь 4 дүгээр ээлжид орох юм байна. Гэтэл наад 4 дүгээр ээлжийн чинь эх үүсвэр нь одоогоороо шийдээгүй мөнгө байхгүй, эх үүсвэр одоо яаж шийдэх вэ? Засаг дээр бас санал танилцуулна гээд сайд тийм юм яриад байгаа шүү дээ.

Тэгээд яагаад одоо ингээд орон нутгуудад ингээд тэгш бус хандаад байдаг юм? Та нар чинь одоо өнөөдөржингөө л одоо энэ ардын хүүхдийг алга үзэхгүй тэгш боломжийг нь олгоно гээд баахан яриад байгаа биз дээ. Энийгээ одоо засах арга байна уу? Энийгээ засмаар байна шүү дээ. Би ноднин бас хэлсэн юм байгаа юм. Яг яг энэний үгийг хэлж байсан. Тэгээд яг тэр хэвээрээ л хаячихсан байгаа байхгүй юу. Ингэж одоо ялгамжтай хандаж болохгүй шүү дээ.

**Г.Мөнхцэцэг:** Чинзориг сайдын асуултад Энх-Амгалан сайд хариулъя даа.

**Л.Энх-Амгалан:** Жорлонг дээгүүрээ хувааж авах нь ч юу байх вэ дээ. Энэ чинь ерөөсөө 1 дүгээр ээлж, 2 дугаар ээлжийг чинь бараг үндсэндээ тендерийг нь нэг мөсөн зураг төсөлгүйгээр зарлачихсан. Тэгээд Өвөрхангай аймгийн хувьд бол 1, 2 дугаар ээлж дээр нийлүүлээд би яах вэ энэ тоог нь нийлүүлээд л ингээд сууж байна л даа. 1 дүгээр ээлж дээр 2 сумын 7 объект, 2 дугаар ээлж дээр 3 сумын 13 объект ингээд 20 объект, 3 дугаар ээлж дээр 7 объект гэхээр нийт 1, 2, 3 дугаар ээлж дээр бол бараг үндсэндээ 27 объектууд бол одоо яг ингээд ариун цэврийн байгууламжаа хийчих энэ боломжууд нь бүрдсэн л гэж харж байгаа юм.

Тэгэхээр яах вэ? Энэ дээр бас дахиад зовлон ярьж байгаа асуудал биш шүү. Ер нь бол цэвэр анхны хэрэгцээ шаардлага тодорхойлсон нь бол орон нутаг өөрөө тодорхойлсон шүү дээ. Яам, тодорхойлоогүй. Яам тэр тухайн сум дээр байгаа тэр Өвөрхангай аймгийн тэр Бүрд сум дээр байгаа жорлонг тоолоод явна гэж бол байхгүй шүү дээ. Тэгээд орон нутагт бид нар маш их итгэл хүлээлгэсэн. Орон нутаг өөрсдөө тодорхойлсон. Харамсалтай нь орон нутаг энийгээ хийгээгүй хийгээгүй. Аймаг нь сэтгэл гаргаагүй, сум нь сэтгэл гаргаагүй.

Тийм учраас бид нар одоо ингээд энэ төслийг зогсоож байгаад 6 сард зогсоож байгаад бид нар сум орон нутаг дээр яг газар дээр нь очиж үзэж энэ ажлын объёмуудыг тодорхойлж өнөөдөр ямар ч байсан улсын хэмжээнд бол нэг ийм 852 объектуудыг нүхэн жорлон байна. Энийг одоо ариун цэврийн байгууламжаар сольё гэдэг нэгдсэн тоотой болж авсан байгаа юм.

Тэгэхээр энэ дээр одоо мэдээж би ч гэсэн хөдөө орон нутгаас сонгогдсон гишүүн. Тойрог дээрээ ажиллахад бол хамгийн түрүүнд л одоо очиж ажиллаж байгаа. Магадгүй зүгээр сайд нь байна гээд ингээд энэ аймаг дээр байгаа гүйцэтгэл сайн гараад байна гэж би бодохгүй л байна л даа. Жигд л одоо гүйцэтгэж байгаа компаниуд дээр байгаа асуудлууд бүгд л аймаг дээр бүх сум дээр л адилхан байгаа бол болов уу гэж бодож байгаа юм. Тэгэхээр ингээд нэг яам одоо ингээд дээр нь ингээд нэг хэдэн жорлон аль аймгийн аль сумын жорлонг эхний ээлжид 1, 2 дугаар ээлжид одоо ингээд хуваарилчихсан юм шиг ийм одоо буруу ойлголттой байж болохгүй Чинзориг гишүүн ээ. Та Засгийн газрын гишүүн. Одоо та энэ жилээс авхуулаад танай эмнэлэг хөдөөгийн эмнэлэг яг энэ ариун цэврийн байгууламжийг сольж эхэлнэ. Ингээд яг надад ирсэн зовлон танд одоо удахгүй ирнэ.

Тийм учраас бол та энэ 330 сум дээр хийгдэж байгаа энэ жорлонгийн энэ ариун цэврийн байгууламжийн асуудлаар бид нараас маш том сургамж аваарай. Маш том сургамж аваарай. Яагаад гэвэл алдаа гаргахгүйн тулд.

**Г.Мөнхцэцэг:** Засгийн газрын бүтээгдэхүүн хоорондоо ингээд л харилцан ярилцаад байх юм уу? Чинзориг сайдын микрофоныг нэмж өгье.

**С.Чинзориг:** Тэр 1, 2 дугаар ээлжийнхнийгээ одоо тэгээд хэзээ оруулах юм бэ? Түргэн оруулмаар байна. 2021 онд эхэлсэн. Одоогоор ерөөсөө ороогүй. Байшин руугаа ч орсон юм байхгүй, нүхээ ч бүрэн ухаж янзалсан юм байхгүй байгууламж ерөөсөө баригдсан юм байхгүй байгаа шүү дээ. Тэгээд л одоо 3 жилийнх нь нүүрийг үзэж байна. Би сая 5 сарын дундуур яваад л ирсэн. 2021 оны тэр чинь одоогоор эхлээгүй байхгүй юу. Тэгээд тэр 4 дүгээр ээлжээ та нар хараарай ичихгүй бол хараарай. Өвөрхангай аймаг 18 хөдөөгийн сумтай 10 сум нь 4 дүгээр ээлжид орно гээд тэр нь мөнгөгүй ээлж, 4 дүгээр ээлж. Бусад тэр одоо дарга нарын сумыг хараарай аймгуудыг 2-оос 5 сум л үлдсэн байна шүү дээ 4 дүгээр ээлжид. Тэгээд яагаад ингээд бүхэл бүтэн нэг аймгийг ингээд 60 хувийг нь одоо ингээд үлдээчихдэг юм бэ? Хөвсгөл тавхан сум байна. Өвөрхангай 10 сум байна, Дундговь хоёрхон сум байна ингэж ялгамжтай хандаж болохгүй шүү дээ та нар төрийн ажил хийж байгаа юм байгаа биз дээ. Ижил тэгш хандах ёстой юм байгаа биз дээ.

**Г.Мөнхцэцэг:** Хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор ер нь бол гишүүд бас хангалттай асуулт асуугаад ингээд хариулт аваад дэгээрээ явж байгаа. Тэгээд ер нь Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд маань бас санал санаачилга гаргаад Эрдэнэт үйлдвэр нийгмийн хариуцлагын хүрээнд энэ одоо 100 тэрбум төгрөгөөр одоо гадаа нүхэн жорлонгуудыг солих ийм ажлуудыг бол одоо бас ингээд үндсэндээ 2, 3 жил бид

нар бас ярьчихлаа. Ажлын хэсэг бол одоо бас Улсын Их Хурал дахь эмэгтэй гишүүд одоо бас ороод энэ ажлын хэсэг гараад ингээд ажилласан. Энэ ажлын хэсгийг манай Баярсайхан гишүүн бол одоо бас нэлээн одоо шахаж сайн ажиллуулсан гэж бас ингэж бодож байгаа. Ингэж бас үнэлж дүгнэж байгаа.

Тэгээд өөрөө бас одоо тэр тойргуудаар зөвхөн өөрийн тойрог гэхгүйгээр хөдөө орон нутгуудаар явж ингэж одоо бас ажил байдалтай нь танилцсан. Ер нь одоо бас гишүүдийн хэлээд байгаатай миний хувьд ч гэсэн бас санал нэг байгаад байгаа. Ер нь одоо бид нар бас энэ хэрэгжилт дээр нь маш их хяналт тавьж ингэж ажиллах шаардлагатай байгаад байгаа. Эхнээсээ бид бас ярь гэж байсан. Ер нь энэ говийн бүс бүсчлээд хийвэл яасан юм бэ. Энэ зураг төсөл хөтөлбөрүүдийг нь бүсчлээд хийвэл яасан юм бэ? Онцлог байгаа. Бүсийн онцлог байгаа гээд ингээд ярьж байсан. Одоо харамсалтай нь одоо тухайн одоо аймаг орон нутгийн удирдлагууд гэдэг юм уу энэ зүйл дээр одоо бас тийм хангалттай бус ажилласан байна.

Аймгуудад одоо бас тодорхой хэмжээний зөрчлүүд үүссэн байна. Энийг гишүүд бол бас яриад байгаа. Энэ дээр бол бас санал нэг байгаад байгаа. Тэгэхээр ер нь бол одоо бид нар цаашид өнөөдөр одоо бас ингээд Байнгын хороонд асуудал болгоод оролцуулаад ингээд хэлэлцүүлж байгаагийнх цаашид бид нар одоо бас яаж ажиллах юм бэ гэдэг дээрээ ер нь яам одоо бас нэг гарц гаргалгаа гарга. Ер нь одоо бас өнөөдрийн хэлэлцэж байгаа асуудалтайгаар гишүүдийн тавьж байгаа асуудалтай холбоотойгоор 3 зүйлийн чиглэлийг одоо бас Байнгын хорооноос одоо өгье өө гэж ингэж одоо бас бодож байна.

Тэгэхээр ер нь бол ингээд гишүүд хэлээд байна. Өмнө нь одоо бас ингээд яваад ирсэн, одоо 2 дахь, 3 дахь 4 дэх ээлж рүүгээ ороод явж байна гээд. Өмнөх одоо

энэ 2, 3 дахь ээлжид хийгдсэн ажлууд маань одоо бас хангалттай бус байна. Ийм учраас энэ дээр алдаа гаргасан энэ одоо хүмүүстэйгээ хариуцлага тооц оо, яаж энэ алдаагаа засах юм бэ? Энэ дээр яам одоо цаашид яаж ажиллах юм. Энэ дээр бас нэг чиглэл юу гарга. Дээр нь мөн ашиглалт дээр анхаарч ажилла гэдгийг бас хэлж байна. Ашиглалт дээр хяналт тавь тийм. Одоо яг хэрэгжүүлж байгаа хэрэгжүүлж байгаа орон нутгуудад энэ чинь бас хангалттай одоо хэрэгжүүлж байгаа биш. Зарим нэг одоо төсөл хэрэгжүүлээд эхэлчихсэн энэ одоо сумдууд, зарим нэг багш, сургуулийнх нь удирдлагууд одоо нолио цоожилчихдог ч байдаг юм уу, мөн одоо тэр угаалтуур юм руу нь одоо бас хог новиоо хийчихдэг ч юм уу. Ингээд гацаачихдаг, ийм түгжрэл үүсгэчихдэг, тэгээд тэр бохиоо бас цааши нь одоо цэвэршүүлэгч байдаг юм уу, ер нь одоо ингээд ил задгай хаядаг ч байдаг юм уу? Ингээд энэ хөдөө орон нутгуудад одоо харилцан адилгүй ийм одоо олон зөрчлүүд үүсээд байгаа. Энэ дээрээ тодорхой хэмжээгээр бас нэг тийм эргээж хяналт тавих ажлыг бас яам анхаараач гэдэг энэ зүйлүүдийг ярьж байна.

Дээр нь бас нэмэлт санхүүжилтээр одоо энэ дуусах гэж байгаа 4 дүгээр ээлжид шаардлагатай байгаад байгаа хуучин одоо 2, 3 жилийн өмнө одоо байсан энэ төсөв чинь мэдээж одоо хүрэхгүй байгаа ойлгомжтой. Гэхдээ одоо нэг одоо байгууламжийг байгуулахад одоо 100-аас 160-аад сая төгрөгийн нэмэлт санхүүжилт хэрэгтэй байна гээд байгаа. Энэ санхүүжилтийн асуудлуудаа одоо бас яаралтай шийдүүлээд энэ Засгийн газрын хуралдаанаар оруулаад энэ 2024 оныхоо төсөв дээр нэмж тавьдаг юм уу, ер нь ямар зохион байгуулалтад оруулах ёстой юм тэгээд энэ одоо нэмэлт санхүүжилтийг хийж энэ ажлыг бүрэн гүйцэд дуусга гэдэг ийм чиглэлийг өнөөдөр Байнгын хорооны асуудалд оруулаад ингээд хэлэлцүүлж байгаа.

*Ийм чиглэлийг Байнгын хорооны зүгээс өгч байна.*

*Тэгээд ер нь бол гишүүдийн гаргасан санал, дүгнэлтүүдийг одоо харгалзаад ийм үндсэн 3 чиглэлийг өгч байна.*

*Ингээд өнөөдрийн Байнгын хорооны хуралдаан дуусаж байна,*

*өндөрлөж байна. Ингээд байнгын хорооны өнөөдрийн хуралдаан хаасныг мэдэгдье.*

*Дууны бичлэгээс буулгасан:  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ  
П.МЯДАГМАА*